



ХҮН ХУДАЛДААЛАХ БОЛОН, БЭЛГИЙН МӨЛЖЛӨГИЙН ГЭМТ ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ: --- ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА



ХҮН ХУДАЛДААЛАХ БОЛОН, БЭЛГИЙН МӨЛЖЛӨГИЙН ГЭМТ ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ: ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

МЭДЭГДЭЛ

Энэхүү тайланг Америкийн Нэгдсэн Улсын Төрийн Департаментын санхүүгийн дэмжлэгтэйгээр “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төслийн хүрээнд хийж гүйцэтгэсэн болно. Энд дурдагдсан үзэл бодол, үр дүн, мэдээлэл, дүгнэлт нь зөвхөн зохиогчийнх бөгөөд Америкийн Нэгдсэн Улсын Төрийн Департаментын болон Азийн сангийн үзэл бодлыг илэрхийлээгүй болно.

ТОВЬЁГ

УДИРТГАЛ	5
Судалгааны зорилго	5
Судалгааны хамрах хүрээ	5
Судалгааны арга зүй	6
Судалгааны үр дүнгийн хураангуй	6
Зөвлөмж	7
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭНД ТУСГАГДСАН ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН УХАГДАХУУН	8
1.1 НҮБ-ын Палермогийн протокол батлагдахаас өмнөх үе	10
1.2 НҮБ-ын Палермогийн протоколд тусгасан агуулга	13
1.3 Хүн худалдаалах ба бусад гэмт хэргийн харилцан хамаарал	16
1.4 Цахим орчин ба хүн худалдаалах гэмт хэрэг	16
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ, УХАГДАХУУН	18
2.1 НҮБ-ын Палермогийн протоколд нэгдэн орохоос өмнө	20
2.2 НҮБ-ын Палермогийн протоколд нэгдэн орсны дараа	22
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ	39
3.1 Шүүхээр шийдвэрлэсэн байдал	40
3.2 Эрүүгийн хариуцлага	43
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	46
4.1 Америкийн Нэгдсэн Улс	48
4.2 Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	51
4.3 Тайвань Улс	61
4.4 Бүгд Найрамдах Солонгос Улс	64
4.5 Канад Улс	66
ДҮГНЭЛТ	76
НОМ ЗҮЙ	79
Тайлбар	83

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ЕХ	Европын Холбоо
УДШ	Улсын дээд шүүх
ЦДХтХ	Цагаачлал, дүрвэгсдийг хамгаалах тухай хууль

УДИРТГАЛ

Энэхүү судалгааг Азийн сангийн дэмжлэгтэйгээр Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн Судалгааны төвийн дарга, хууль зүйн доктор Б.Дөлгөөн (Ph.D) удирдаж, Эрүүгийн эрх зүйн секторын эрхлэгч О.Инжиннаш, судлаач Э.Янжинлхам, Э.Баасанбямба, Б.Ундрам нар 2024 оны 04 дүгээр сараас 07 дугаар сар хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Монгол Улс нь хүн худалдаалах гэмт хэргийг 1986 оны Эрүүгийн хуульд “хууран мэхлэх замаар хүмүүс элсүүлэх”, 2002 оны Эрүүгийн хуульд “хүн худалдах, худалдан авах” гэмт хэрэг хэмээн хуульчилж байжээ. Үүний дараа 2008 онд НҮБ-ын Палермогийн протоколд нэгдэн орж уг протоколд нийцүүлэх үүднээс хүн худалдаалах гэмт хэргийн зүйл, хэсэгт 2008 болон 2012 онд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан байдаг. Харин одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд хүн худалдаалах гэмт хэргийг хуульчилсан байна.

Гэвч хууль тогтоогч Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйлд заасан бэлгийн мөлжлөг гэмт хэргийг хуульчлахдаа хүн худалдаалах гэмт хэргийн бэлгийн мөлжлөгийн зорилго, зарим үйлдэл, үйлдлийн аргыг диспозицод тусгаснаар өрсөлдөх хэм хэмжээ бий болгосон нь хүн худалдаалах болон бэлгийн мөлжлөг гэмт хэргийн шинж давхцах, шүүхийн практикт хууль хэрэглээний зөрүү үүсэх, шударга ёсны зарчим хөндөгдөх зэрэг асуудлыг дагуулжээ.

Иймд судалгааны багийн зүгээс энэхүү судалгаагаар хүн худалдаалах гэмт хэргийн ухагдахууныг олон улсын эрх зүйн баримт бичигт тусгасан агуулгыг тодруулах, мөн манай улсад хуульчилж ирсэн уламжлал, шүүхээр шийдвэрлэж буй практикийг судлахаас гадна гадаадын зарим улс орны эрх зүйн зохицуулалттай харьцуулан судалж уг гэмт хэргийг хуульчлах, өрсөлдөх хэм хэмжээнээс ялган зүйлчлэх, ялын бодлогын хүрээнд санал дэвшүүлэхийг зорилоо.

СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү судалгааны хүрээнд Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцын нэмэлт болох “Хүн ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай” протокол болон түүнд холбогдох тайлан, зөвлөмжийг судлав.

Мөн Хүн худалдаалах гэмт хэргийг Эрүүгийн хуульд хуульчилж ирсэн түүхэн уламжлал, одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хууль, уг хуулийн хувийн

хэрэг, Гэмт хэргийн тухай хуулийн төсөл, төслийн ажлын хэсгийн зарим гишүүдийн ярилцлага, эрдэмтдийн бүтээлээс хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбогдох хэсгийг авч үзлээ. Шүүхийн практикийн хувьд сүүлийн гурван жилийн хугацаанд буюу 2021-2023 оны шийдвэрийг судалсан.

Харьцуулан судалсан хэсэгт Англи-Америкийн бүл, Эх газрын бүл, холимог бүлийг төлөөлүүлэн Бүгд Найрамдах Солонгос Улс, Тайвань Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Америкийн Нэгдсэн Улс, Канад Улсыг сонгон судлав. Эдгээр улсыг сонгохдоо хүн худалдаалах гэмт хэргийн тайлангийн шатлалыг харгалзан үзсэн болно.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгааг гүйцэтгэхдээ эрх зүйн социологийн судалгааны аргууд болох задлан шинжилж, нэгтгэн дүгнэх (анализ, синтез), баримт бичиг судлал, түүхчлэн судлах, ганцаарчилсан ярилцлага, эмпирик, харьцуулсан судалгааны аргуудыг ашиглав.

СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ

2015 оны Эрүүгийн хуульд хүн худалдаалах гэмт хэргийн үйл явцыг хамруулсан үйлдлийг тусгай ангийн 13.1 дүгээр зүйлд, үр дүнг хамруулсан үйлдлийг 12.3 дугаар зүйлийн хүндрүүлэх шинжид тус тус хуульчилжээ. Гэвч хууль тогтоогч хохирогчийн эрх, эрх чөлөөг хязгаарласан хэр хэмжээнд тулгуурлан тусад нь хуульчлахдаа хорих ялын хугацааг зөрүүтэй томъёолсноор бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг үйлдсэн дийлэнх этгээд 2-3 жил, хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн дийлэнх этгээд 4-5 жилийн хугацаатай хорих ял шийтгүүлжээ. Протоколын зөвлөмжид зааснаар хүн худалдаалахад хамаарах бусад гэмт хэргийг тусад нь хуульчлах боломжтой ч аль нэг мөлжлөгийн хэлбэрийн нийгмийн хор аюулыг багасгаж буй хэрэг биш юм.

Энэхүү судалгаагаар авч үзсэн улс орнууд эрх зүйн тогтолцоо, үзэл баримтлалаасаа хамааран хүн худалдаалах гэмт хэргийг харилцан адилгүй байдлаар хуульчилсан байна. (I) хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэргийг хамтад нэг зүйлд хуульчлах (АНУ, Тайвань, БНСУ, Канад), эсхүл (II) хүн худалдаалахаас өмнөх үйл явцыг хамруулсан үйлдлийг хүн худалдаалах гэмт хэрэгт тооцож, бусад мөлжлөгт оруулсан үйлдлийг тусад нь гэмт хэрэгт тооцож хуульчилсан (Герман, Австри) нийтлэг зүй тогтолтой. Эдгээр улсад хэрхэн хуульчилснаас үл хамааран бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэргийн ялын бодлогыг хүн худалдаалах гэмт хэргээс хатуу байх бодлогыг баримталснаас гадна дээрх гэмт хэргүүдийг хохирогчийн бие махбодод хохирол учруулж үйлдсэнийг хүндрүүлэх бүрэлдэхүүнд хуульчилж байна. Иймд бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн шинж, ялын бодлогыг өөрчлөх шаардлага бий болжээ.

ЗӨВЛӨМЖ

Энэхүү судалгааны үр дүнд үндэслэн дараах зөвлөмжийг гаргав:

- Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг “Албадан бэлгийн харьцаанд оруулах” хэмээн томъёолж өөр зүйлд хуульчлах, 12.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг буюу бэлгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэргийг 13.1 дүгээр зүйлийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд хуульчлах;
- Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн хүндрүүлэх шинжид оногдуулах эрүүгийн хариуцлагыг хүн худалдаалах гэмт хэргээс хүнд ял оногдуулахаар хуульчлах;
- Дээрх гэмт хэргүүдийг хохирогчийн эрүүл мэндэд хохирол учруулж үйлдсэн, амь насыг нь хохироосныг хүндрүүлэх бүрэлдэхүүнд хуульчлах;
- Улсын дээд шүүхээс хүн худалдаалах гэмт хэрэгт хамаарах бусад гэмт хэргийг ялган зүйлчлэх талаарх албан ёсны тайлбар гаргах.



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭНД ТУСГАГДСАН ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН УХАГДАХУУН

1.1 НҮБ-ын Палермогийн протокол батлагдахаас өмнөх үе	10
1.2 НҮБ-ын Палермогийн протоколд тусгасан агуулга	13
1.3 Хүн худалдаалах ба бусад гэмт хэргийн харилцан хамаарал	16
1.4 Цахим орчин ба хүн худалдаалах гэмт хэрэг	16

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭНД ТУСГАГДСАН ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН УХАГДАХУУН

Хүн худалдаалах гэмт хэргийн тухай дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн нэгдмэл тодорхойлолтыг олон улсын эрх зүйн хэм хэмжээнд тусгах үйл явц XX зууны туршид үргэлжилсэн. Тодруулбал, XX зууны эхэн үед эхэлсэн үндэстэн дамнуулан эмэгтэйчүүдийн биеийг үнэлүүлэх явдлын эсрэг олон улсын хамтын ажиллагааны үр дүнд хүн худалдаалах гэмт хэргийн талаарх орчин үеийн ойлголтын суурийг тавьжээ. Энэхүү гэмт хэргийг олон улсын эрх зүйн хэм хэмжээнд тусгаж ирсэн түүхээс харахад хохирогч нарын шинж, гэмт үйлдэл, үйлдлийн арга, зорилго, үндэстэн дамнасан байх зэрэг шинжүүд нь өөрчлөгдсөөр ирсэн байна.

1.1 НҮБ-ЫН ПАЛЕРМОГИЙН ПРОТОКОЛ БАТЛАГДАХААС ӨМНӨХ ҮЕ

XIX-XX зуунд англи хэлээр ярьдаг улс орнуудад /англ.Anglophone/ “цагаан боолчлол” /англ.White slavery/ хэмээх ойлголтоор цагаан арьст эмэгтэйчүүдийг бэлгийн зорилгоор буюу биеийг нь үнэлүүлж боолчлох явдлыг илэрхийлдэг байжээ. 1899 онд Лондон хотод **“Эмэгтэйчүүд, хүүхдүүдийн худалдааг зогсоох олон улсын товчоо”** байгуулагдсан нь энэ чиглэлээр тэмцэх улс үндэстнүүдийн хамтын ажиллагааны суурийг тавьсан бөгөөд 1904-1910 онд “Цагаан боолчлолын худалдааг зогсоох олон улсын конвенц”¹-ыг баталж, улмаар 26 орон нэгдэн орж байжээ. Уг конвенцод **“бусад хүний бэлгийн сонирхлыг хангахын тулд хуурч, хүч хэрэглэж, заналхийлж, эрх мэдлээ урвуулан ашиглаж болон бусад байдлаар дарамтад оруулж эмэгтэйчүүд, охидыг ёс бус зорилгын төлөө худалдсан, татан оруулсан, авч явсан”**² бол ял шийтгэхээр тусгасан байна. Энэ тодорхойлолтоор гэмт хэргийн хохирогч нь зөвхөн эмэгтэйчүүд, охид байх бөгөөд хил дамнуулан биеийг нь үнэлүүлэх зорилгоор худалдсан буюу татан оролцуулсан нөхцөлд хүн худалдаалах гэмт хэрэгт тооцно. Үүний дараа Үндэстнүүдийн Лигээс баталсан “Эмэгтэйчүүд болон хүүхдүүдийг худалдахыг таслан зогсоох” (1921), “Насанд хүрсэн эмэгтэйчүүдийг худалдах явдлыг таслан зогсоох” (1933) зэрэг конвенцод ч мөн охид, эмэгтэйчүүдийг хил дамнуулан биеийг нь үнэлүүлэх зорилгоор зөөвөрлөх “үйл явцыг” гэмт хэрэгт тооцохоор тодорхойлдог байжээ.³

Хүн худалдаалах гэмт хэргийн объектив талд хамаарах үйлдлүүдийг үйл явц (process)-ыг хамруулсан үйлдэл, үр дүнг (result) хамруулсан үйлдэл хэмээн ялгаж болдог. Хохирогчийг элсүүлэн нэг газраас нөгөөд хүргэх буюу мөлжлөгийн газарт хүргэх хүртэлх үргэлжилсэн процессыг тодорхойлсон үйлдлүүдийг “үйл явцыг хамруулсан үйлдлүүд” гэнэ. Нэгдсэн Үндэстний Байгууллага /цаашид “НҮБ” гэх/-аас 1949 онд “Хүн худалдаалах, бусдын биеийг үнэлүүлж мөлжих явдлыг таслан зогсоох конвенц” батлагдах хүртэл хүн худалдаалах гэмт хэрэгт зөвхөн үйл явцыг

илэрхийлсэн үйлдлүүдийг хамааруулахаар тодорхойлж иржээ. Өөрөөр хэлбэл, хүнийг тодорхой хэлбэрийн мөлжлөгт оруулах гэмт үйлдлийг хүн худалдаалах гэмт хэргийн шинжид тооцдоггүй байсан. Харин дээрх конвенц батлагдсанаар хүн худалдаалах гэмт хэргийг дараах байдлаар томьёолсон байна:

Бусдын бэлгийн сонирхлыг хангах зорилгоор

- (1) тухайн хүний зөвшөөрсөн эсэхээс үл хамааран хүний биеийг үнэлүүлэх зорилгоор худалдсан, татан оруулсан, авч явсан;
- (2) тухайн хүн зөвшөөрсөн эсэхээс үл хамааран биеийг нь үнэлүүлж мөлжсөн бол ял шийтгэхээр тусгажээ.

Ингэснээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч “аль ч хүйсийн хүн” байж болохоор тодорхойлсноос гадна хил дамнуулан мөлжлөгт оруулах хүртэл үргэлжилсэн процесс, үүний үр дүнд хохирогчийг мөлжлөгт оруулсан үйлдлийг давхар гэмт хэргийн шинжид хамааруулжээ. Уг конвенцод заасан биеийг нь үнэлүүлж мөлжих ойлголтын хүрээнд буурчийн газар, зочид буудлын эзэн гэх мэтчилэн гуравдагч этгээд хохирогчийн биеийг үнэлүүлж олсон мөнгийг бүхэлд нь, эсхүл тодорхой хувийг нь авах явдлыг ойлгодог байжээ.⁴

Үүнээс хойш олон улсын түвшинд хууль бус цагаачлал, үүнтэй холбоотой гэмт явдлууд болон бэлгийн замын халдварт өвчний тархалт нэмэгдсэнтэй холбоотойгоор 1990 оны үеэс хүн худалдаалах гэмт хэрэгт дахин онцгой анхаарал хандуулж эхэлжээ. Улс орнууд эдгээр асуудлын эсрэг үр дүнтэй хамтран ажиллахад хүн худалдаалах гэмт хэргийн талаарх нэгдмэл ойлголт дутагдаж байсан бөгөөд хууль бусаар цагаачлах зэрэг бусад гэмт хэргээс хэрхэн ялгарах талаар нэгдмэл ойлголтод хүрэх шаардлагатай тулгарсан. Энэхүү шаардлагыг үндэслэн НҮБ-аас Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг, түүний хүрээнд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын эрх зүйн хэм хэмжээг боловсруулах ажлыг эхлүүлсэн байдаг.

Энэ хүртэл улс орнууд гол төлөв хүн худалдаалах гэмт хэрэг нь охид, эмэгтэйчүүдийн биеийг үнэлүүлэх, бэлгийн мөлжлөгт оруулах зорилгоор хил дамнуулан үйлдэгдэнэ гэсэн ойлголтыг түгээмэл ашигласаар иржээ. 1994 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас хүн худалдаалах гэмт хэргийг дараах байдлаар тодорхойлсон нь өмнөх агуулгаас өргөн хүрээнд ойлгох суурийг тавьжээ.⁵

Элсүүлэгч, худалдагч, гэмт бүлэглэлийн ашгийн төлөө эмэгтэйчүүд, охидыг бэлгийн, эсхүл эдийн засгийн харгис болоод мөлжлөгийн нөхцөл байдалд оруулах зорилгоор хууль бусаар, нууцаар нэг улсын дотор, эсхүл олон улсын хил дамнуулан зөөвөрлөсөн; мөн албадан зарцлах, хуурамч гэрлэлт, нууцаар хөдөлмөрлүүлэх болон албадан үрчлүүлэх гэх мэт хүн худалдаалахтай холбогдох бусад хууль бус үйл ажиллагаануудыг ойлгоно.

Дээрх тодорхойлолтоор хүн худалдаалах гэмт хэрэг нь хохирогчийг зөвхөн бэлгийн мөлжлөгт оруулахаас гадна бусад зорилгоор үйлдэгдэх боломжтой. Мөн заавал нэг

улсаас нөгөө улс руу хил дамнуулан үйлдэгдэх албагүй буюу нэг улсын дотоодод үйлдэгдэж болохыг тогтоосноороо гэмт хэргийн шинжид чухал ач холбогдолтой өөрчлөлтүүдийг оруулсан байдаг.

Гэсэн хэдий ч улс орнуудад нэгдсэн ойлголт тогтож чадаагүй хэвээр байв. Тухайлбал 1996 онд Европын холбооны парламент, Европын зөвлөлөөс хүн худалдаалах гэмт хэргийг “бэлгийн мөлжлөгийн зорилгоор гуравдагч орноос эмэгтэйчүүдийг Европын холбооны нутаг дэвсгэрт оруулах (дараа нь гишүүн орнуудын нутаг дэвсгэрийг дамжуулан зөөвөрлөсөн байж болно) ... Бэлгийн мөлжлөгт оруулах зорилгоор худалдаалах гэдэгт худалдаалсны улмаас эмэгтэйчүүдийг айлган сүрдүүлэх, эсхүл хүч хэрэглэх явдлыг хамааруулна. Зарим тохиолдолд хохирогч өөрийн биеийг үнэлэх гэж буйг мэдсээр байж хүн худалдаалах процессын аль нэг шат руу орж болох боловч дараа нь хүний суурь эрхүүдийг хязгаарлаж боолчлолтой ижил нөхцөлд байлгадаг учир хохирогч зөвшөөрсөн эсэх нь хамааралгүй.”⁶ хэмээн тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл, зөвхөн “эмэгтэйчүүдийн” биеийг үнэлүүлж бэлгийн мөлжлөгт оруулахын тулд хүч хэрэглэн эрх, эрх чөлөөг нь ноцтой хязгаарлаж боолчлолтой ижил нөхцөлд оруулахыг энэ гэмт хэрэгт хамааруулж үзсэн нь өнөөгийн ойлголттой харьцуулахад харьцангуй хязгаарлагдмал хүрээнд уг гэмт хэргийн илрэх хэлбэрийг тодорхойлсон байна.

Ийнхүү улс орнуудын дунд нэгдмэл ойлголтыг бий болгох зорилгоор НҮБ-аас томилсон эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг тусгай илтгэгч хүн худалдаалах гэмт хэргийн шинжийг шинээр томъёолсон нь уг гэмт хэргийн талаарх олон улсын эрх зүйн хэм хэмжээнд тусгагдсан одоогийн тодорхойлолттой хамгийн ойр агуулгыг багтаасан байдаг. Тусгай илтгэгчийн тодорхойлсноор:⁷

Хүн худалдаалах гэдэг нь хүнийг өөрийнх нь амьдарч буй нийгмийн хүрээлэлээс өөр хүрээлэлд албадан хөдөлмөрлүүлэх буюу боолчлолтой ижил нөхцөлд (2) байлгах буюу тогтоон барих зорилгоор хүч хэрэглэхээр заналхийлж, хүчирхийлж, хулгайлж, хүч хэрэглэж, хууран мэхэлж, итгэл эвдэж, өрөнд баригдаж боолчлогдсон (1) элсүүлсэн, тээвэрлэсэн, арилжсан, зарсан, шилжүүлсэн, орогнуулсан, эсхүл хүлээн авсан үйлдлийг хэлнэ.

Дээрх тодорхойлолтоор хохирогчийг нийгмийн өөр хүрээлэлд шилжүүлэхэд хангалттай буюу заавал нэг улсаас нөгөөд зөөвөрлөсөн байхыг шаардахгүй бөгөөд үйл явцын болон үр дүнг хамруулсан үйлдлүүдийг аль алийг нь багтаахыг зорьжээ. Тодорхой аргуудыг хэрэглэж тогтоон барих буюу хохирогчийг эцсийн цэгт хүргэн боолчлох, албадан хөдөлмөрлүүлэх нь хүн худалдаалах гэмт хэрэгт хамаарна. Элсүүлэх, тээвэрлэх, арилжих, шилжүүлэх, орогнуулах, хүлээн авах зэрэг үйлдлүүд (2) нь хүнийг нэгээс нөгөө цэгт мөлжлөгт оруулах үргэлжилсэн процессыг илэрхийлэх бол мөлжлөгт оруулж буй газарт тогтоон барьсан /англ. *placing or holding*/ (1) явдал нь үр дүнг хамруулсан үйлдэлд тооцогдоно.⁸

XXI зууныг хүртэл хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хэн байх, үндэстэн дамнасан шинжийг заавал агуулах эсэх, зөвхөн биеийг нь үнэлүүлэх, бэлгийн мөлжлөгт оруулах зорилготой байх эсэх талаар гол маргаан өрнөж иржээ.

1.2 НҮБ-ЫН ПАЛЕРМОГИЙН ПРОТОКОЛД ТУСГАСАН АГУУЛГА

Ийнхүү 2000 онд НҮБ-аас Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын нэмэлт болох Хүн ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколыг баталснаар өмнөх маргаан бүхий шинжүүдийг улс орнуудын харилцан ойлголцол, зөвшилцөлд тулгуурлан шийдвэрлэж хүн худалдаалах гэмт хэргийн талаарх анхны нэгдмэл тодорхойлолтыг олон улсын эрх зүйн хэм хэмжээнд тусгажээ.

НҮБ-ын Хүн ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколын 3 дугаар зүйл.

"Хүн худалдаалах" гэж мөлжих зорилгоор эрхшээлдээ байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг олж авахын тулд төлбөр төлөх, хүлээн авах, давуу байдал бий болгох эсхүл эмзэг байдлыг нь ашиглах, эрх мэдлээ урвуулан ашиглах, хууран мэхлэх, залилан мэхлэх, хулгайлах, бусад хэлбэрээр албадах, хүч хэрэглэх, заналхийлэх замаар бусдыг элсүүлэх, тээвэрлэх, шилжүүлэх, орогнуулах, хүлээн авах үйлдлийг хэлнэ.

Хүн худалдаалах гэмт хэргийг /зорилго, үйлдэл, арга/ гурван элементийн нэгдэлд тодорхойлсон байна.

Зорилго	Үйлдлийн арга	Үйлдэл
Мөлжлөг: 1. Бэлгийн мөлжлөг, 2. Биеийг үнэлүүлэх, 3. Албадан хөдөлмөр, үйлчилгээ, 4. Боолчлол, 5. Түүнтэй төстэй үйл ажиллагаа, 6. Эд эрхтнийг нь авах	1. Төлбөр төлөх, 2. Төлбөр хүлээн авах, 3. Давуу байдал бий болгох 4. Эмзэг байдлыг нь ашиглах, 5. Эрх мэдлээ урвуулан ашиглах, 6. Хууран мэхлэх, 7. Залилан мэхлэх, 8. Хулгайлах, 9. Бусад хэлбэрээр албадах, 10. Хүч хэрэглэх, 11. Хүч хэрэглэхээр заналхийлэх	1. Элсүүлэх, 2. Тээвэрлэх, 3. Шилжүүлэх, 4. Орогнуулах, 5. Хүлээн авах

Конвенцыг боловсруулагчид хүнийг хүчирхийллийн шинжтэй аргуудыг ашиглаж мөлжлөгийн ноцтой нөхцөл байдалд оруулах буюу тийм байдал дор байлгахыг хүн худалдаалах гэмт хэрэгт хамаарахаар тодорхойлсон.⁹ Гэсэн хэдий ч Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц болон нэмэлт протоколд эдгээр шинжүүдийн тайлбарыг тусгаагүй. Ямар нөхцөл байдалд хохирогчийн эрх, эрх чөлөөг хэр хэмжээтэй хязгаарласныг мөлжлөг гэж үзэх, хохирогчийн эмзэг байдлыг далимдуулсан шинжийг хэрхэн тодорхойлох гэх мэт олон асуудлыг протоколын агуулгаас шууд ойлгох боломжгүй. Энэ мэтчилэн тодорхойгүй асуудлуудыг улс орнууд өөр өөрөөр тайлбарласаар байна.

Гэмт хэргийн зорилго: “Мөлжих” /англ.exploitation/ хэмээх үг нь хэл зүйн ерөнхий утгаараа **нэгдүгээрт** тодорхой эд зүйл буюу нөхцөл байдлаас үр ашиг хүртэх, ашиглах; **хоёрдугаарт** хүмүүс хоорондын харилцааны сөрөг илрэл буюу өөрийн ашгийн төлөө бусдыг ашиглах гэсэн утгыг илэрхийлдэг.¹⁰ Үүнээс үзэхэд тодорхой аргуудыг ашиглаж эрх, эрх чөлөөг нь ноцтой зөрчиж өөрт ашигтай үр дагаврын төлөө хохирогчийг ашиглахыг мөлжих гэж ойлгож болохоор байна.

Протоколын тодорхойлолтод наад зах нь хүний биеийг үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг үйлдэх, албадан хөдөлмөр, үйлчилгээ эрхлүүлэх, боолчлох, түүнтэй төстэй үйл ажиллагаа, эд эрхтнийг нь авах зэргийг хамааруулжээ. Протоколд мөлжлөгийн хэлбэрийг заахдаа “наад зах нь” хэмээн нээлттэй үлдээсэн нь хүн худалдаалах гэмт хэргийн хамрах хүрээнд мөлжлөгийн бусад хэлбэр буюу түгээмэл бус, шинэ төрлийн хэлбэрийг авч үзэх боломжийг олгосон бөгөөд оролцогч улс наад зах нь протоколд заасан мөлжлөгийн хэлбэрүүдийг дотоодын хууль тогтоомждоо тусгасан байх ёстой.¹¹ Энэ нь урт хугацааны туршид улс орнуудын дунд нэгдмэл байр сууринд хүрж чадахгүй явсаар ирсэн хүн худалдаалах гэмт хэргийн зорилгыг тодорхойлох оролдлого мөн. Нөгөөтээгүүр ирээдүйд гарч болох мөлжлөгийн шинэ хэлбэрүүдийг нийтлэг хамааруулж хүн худалдаалах гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх зорилгын илрэл юм.

Гэхдээ хүн худалдаалах гэмт хэрэгт заавал хохирогчийг мөлжих зорилго хангагдсан байхыг шаардахгүй. Хохирогчийг мөлжих зорилгоор үргэлжилсэн процесст хамаарах аль нэг үйлдлийг гүйцэтгэснээр уг гэмт хэрэг төгсөж болно.

Гэмт үйлдэл: Протоколын тодорхойлолтод хүн худалдаалах гэмт хэрэгт “элсүүлэх”, “тээвэрлэх”, “шилжүүлэх”, “орогнуулах”, “хүлээн авах” гэсэн 5 үйлдлийг хамааруулжээ. Эдгээр нь үйл явцын болон үр дүнд холбогдох үйлдлүүдийг бүхэлд нь хамруулна.¹² Протокол болон бусад олон улсын эрх зүйн эх сурвалжид эдгээр үйлдлийн талаар тодорхойлолт, тайлбарыг тусгаагүй. Харин НҮБ-аас гаргасан Палермогийн протоколын хууль тогтоомжийн гарын авлага (англ.legislative guide) болон бусад судалгааны тайлан, зөвлөмжид эдгээр үйлдлийг дараах байдлаар тайлбарлажээ.

“Элсүүлэх” (англ.**Recruitment**) гэдэгт хүнийг аливаа үйл явцад аман хэлбэр, зар сурталчилгаа, цахим сүлжээ зэрэг төрөл бүрийн арга хэлбэр ашиглан татан оролцуулах аливаа үйлдлийг ойлгоно. Үндэстэн дамнах тохиолдолд улсаас гарах, дамжин өнгөрөх, эсхүл товлосон улс дахь үйл ажиллагааг хамааруулж ойлгоно.

“Тээвэрлэлт” (англ.**Transportation**) гэдэгт бүхий л төрлийн тээврийн хэрэгсэл ашиглан газар, далай, агаараар тээвэрлэсэн үйлдлийг ойлгоно. Тээвэрлэлт нь нэг улс дотор эсхүл улсын хил нэвтэрч ойрын болон холын зайд хийгдэж болно.

“Шилжүүлэх” (англ.**Transfer**) гэдэгт хүнийг тээвэрлэх буюу тухайн хүнийг бусдын хяналт, эрхшээлд шилжүүлэхийг ойлгоно.

“Орогнуулах” (англ. **Harbour**) болон хүлээн авах нь үр дүнд хамаарах үйлдлүүд юм.¹³ Тухайлбал хохирогчийн эрх, эрх чөлөөг хязгаарлаж мөлжлөгийн нөхцөл байдалд оруулах, эсхүл тийм нөхцөл байдалд орогнуулан байлгаснаар хүн худалдаалах гэмт хэргийн эцсийн цэг буюу мөлжих зорилго хангагдаж буйг илэрхийлнэ.

“Орогнуулах” үйлдлийн хэлбэрийг улс орнууд харилцан адилгүй ойлгож хэрэглэдэг боловч үгийн ерөнхий утгаар нь уян хатан ойлгож хэрэглэхийг зөвлөсөн байна.¹⁴ Англи хэлний “*harbouring*” хэмээх үг нь “орон байраар хангах, орогнуулах” /англ. *accommodating and sheltering*/ гэсэн утгыг илэрхийлдэг. Түүнээс гадна зарим тохиолдолд “*conceal*” буюу хохирогчийг нуух агуулгыг илэрхийлж болно.¹⁵

Хохирогчийг орогнуулах гэдэг нь заавал орон байраар хангаж тэндээ байлгах, мөн байлгаж буй орчин нь заавал дорой, хүнлэг бус, доромжилсон нөхцөлд байхыг шаардахгүй.¹⁶ Өөрөөр хэлбэл, гэмт этгээд хохирогчийг тодорхой байршилд өөрийн хяналт дор байлгах нөхцөлд түүнийг орогнуулсан гэж үзнэ. Жишээлбэл, хохирогч буурчийн газарт бусдад биеэ үнэлэх явцад тухайн орчинд хохирогчийг орогнуулсан гэж үзнэ.

“Хүлээн авах” (англ.*Receipt*) ойлголтыг “шилжүүлэх” үйлдэлтэй холбож авч үзэх бөгөөд тухайн хүн ирэх, тохиролцсон газар уулзах, өөрийн хяналтдаа шилжүүлэн авахыг ойлгож болно. Үүнд хүнийг албадан хөдөлмөрлүүлэх буюу хөдөлмөр эрхлэлтийн зорилгоор хүлээн авахыг хамааруулж болно. Түүнчлэн уг ойлголтод үе дамжсан өрөнд албадан хөдөлмөрлүүлэх (англ.*inter-generational bonded labour*), эсхүл хууль ёсны ажлын хэлбэрээс албадан хөдөлмөрлүүлэх мөлжлөгийн хэлбэрт шилжсэн нөхцөл байдал мөн хамаарна.

Үйлдлийн арга: Протоколд заасан аргуудаар хохирогчийг худалдаалахад хохирогч өөрөө зөвшөөрсөн эсэх нь хамааралгүй.¹⁷ Түүнчлэн хүүхдийг мөлжлөгийн зорилгоор элсүүлэх, тээвэрлэх, шилжүүлэх, орогнуулах, хүлээн авах үйлдэл хийхэд дээр заасан арга хэлбэрийг ашиглаагүй нь хүн худалдаалах гэмт хэрэг гэж үзэхгүй байх шалтгаан болохгүй. Өөрөөр хэлбэл, хүүхэд худалдаалахад эдгээр аргуудыг ашигласан эсэхээс үл хамааран хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэнд тооцно.

Үйлдлийн аргуудаас хохирогчийн “эмзэг байдлыг далимдуулан” гэмт хэрэг үйлдсэн эсэхийг тогтооход нухацтай хандаж тодорхой тогтоох шаардлагатай. Хохирогчийн эдийн засаг, нийгмийн хувьд хүнд нөхцөлд байгааг гэмт этгээд мэдэж байсан нь энэ аргаар гэмт хэрэг үйлдэгдсэн гэж үзэх хангалттай үндэслэл болохгүй. НҮБ-ын хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх хорооноос гаргасан удирдамжид:¹⁸

“Хохирогчийг элсүүлэх, тээвэрлэх, шилжүүлэх, орогнуулах, хүлээн авахын тулд хүний хувийн болон тухайн нөхцөл байдлаас үүдэлтэй эмзэг байдлыг нь зориудаар ашиглах, ингэснээр хохирогч гэмт этгээдийн хүслийг дагах нь цорын ганц бодит, боломжит сонголт хэмээн итгэж, ийнхүү итгэсэн нь хохирогчийн байгаа нөхцөл байдлын үүднээс дүгнэхэд бодитой байна. Үүнийг тогтоохын тулд хохирогчийн хувийн шинж болон тухайн үед хохирогчийн байсан нөхцөл байдлыг харгалзан үзэх шаардлагатай” гэжээ.

1.3 ХҮН ХУДАЛДААЛАХ БА БУСАД ГЭМТ ХЭРГИЙН ХАРИЛЦАН ХАМААРАЛ

НҮБ-аас гаргасан “Хүний эрх болон хүн худалдаалах гэмт хэргийн талаарх зарчим ба удирдамжууд” зөвлөмжид¹⁹ улс орнуудыг “хүн худалдаалах гэмт хэрэгт хамааралтай бусад гэмт хэргүүд” /англ.related offences/ буюу хүн худалдаалах гэмт хэргийн зорилгод тодорхойлсон гэмт хэргүүдийг эрүүгийн хуульдаа бие даасан гэмт хэрэгт тооцон хуульчлахыг зөвлөжээ. Үүнд бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөрлүүлэх, боолчлох буюу түүнтэй адилтгах нөхцөлд байлгах, өрөнд баригдаж боолчлогдох, хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр хийлгэх, хүчээр гэрлүүлэх гэмт хэргүүд, мөн хүчиндэх, биеийн болон бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргүүд, хууль бусаар хорих зэрэг хүн худалдаалах гэмт хэргийн нийтлэг шинжийг илэрхийлдэг үйлдлүүдийг багтаах шаардлагатай.²⁰

Хүн худалдаалах гэмт хэрэг нь ээдрээ төвөгтэй, мөрдөн шалгах, нотлоход нарийн төвөгтэй элементүүдээс бүрддэг тул ийнхүү бие даасан гэмт хэргүүдийг хуульчлах нь гэмт этгээдэд ял завшуулахаас сэргийлэх, хүний эрхийг бүрэн, бодитой хамгаалах нөхцөл болно.

Дараах нөхцөлд энэхүү аргыг хэрэглэх нь үр дүнтэй гэжээ. Үүнд²¹:

- Хүн худалдаалах гэмт хэргийг бие даасан гэмт хэрэгт тооцон хуульчлаагүй байгаа улс орнууд;
- Хүн худалдаалах гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэл нь гэмт хэргийн нийгмийн аюулын хэр хэмжээнд нийцээгүй;
- Хэрэгт цугларсан нотлох баримтууд нь хүн худалдаалах гэмт хэргийн шинжийг тогтооход хангалттай биш боловч бусад гэмт хэргийг хангалттай нотолж байгаа тохиолдолд гэх мэт.

1.4 ЦАХИМ ОРЧИН БА ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ

Олон улсад хүн худалдаалах ойлголтыг уламжлалт байдлаар ойлгохоос гадна цахим хэрэгсэл ашиглан мөлжих ойлголтыг ч хамааруулж үзэж байна.

“Цахимаар худалдаалах” гэдэгт мөлжлөгийн зорилгоор хохирогчийн зөвшөөрлөөр, хүчээр, хууран мэхлэхийн тулд компьютерын систем, интернэт үйлчилгээ, хөдөлгөөнт төхөөрөмж, ухаалаг мэдээллийн самбар, цахим мэдээлэл хадгалах, дамжуулах үйлдэл бүхий төхөөрөмж ашиглан “хүн тээвэрлэх” явдал юм. Хүнийг тээвэрлэх /англ.Transport in persons/ гэж мөлжлөгийн зорилгоор хохирогчийн зөвшөөрсөн эсэхээс үл шалтгаалж элсүүлэх, сурталчлах, уруу татах, тээвэрлэх, худалдах, худалдан авах, шилжүүлэх, орогнуулах, хүлээн авахыг хэлнэ.²²

НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас цахим сүлжээ, технологийн элемент агуулсан хүн худалдаалах гэмт хэргийн шүүхийн шийдвэрийн судалгаанд “Веб камер болон шууд дамжуулалт нь мөлжлөгийн шинэ хэлбэрийг бий болгож,

хохилогчдыг тээвэрлэх, шилжүүлэх хэрэгцээг багасгаж байгаа" талаар дурджээ.²³ Хүн худалдаалагчид хохирогчдын хүчирхийллийн дүрс бичлэгийг шууд дамжуулж давтамжтай мөлжиж байх бөгөөд энэ нь хууль сахиулах байгууллагуудад тус гэмт хэрэгтэй тэмцэхэд улам бэрхшээлтэй болгож байна.²⁴

Бүлгийн дүгнэлт: Хүн худалдаалах гэмт хэрэг нь ХХ зуунд бий болсон бөгөөд ХХI зууныг хүртэл уг гэмт хэргийн агуулга, зорилго өөрчлөгдсөөр иржээ. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцын нэмэлт Хүн ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколд уг гэмт хэргийн дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн тодорхойлолтыг анх тогтоосон. Энэ нь улс орнуудын харилцан зөвшилцлийн үр дүн бөгөөд уг тодорхойлолтыг үндэсний хууль тогтоомждоо тусгахдаа хүн худалдаалах гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх протоколын зорилгод нийцүүлэн тайлбарлаж хэрэглэхийг зөвлөж байна. Олон улсын хэм хэмжээнд заасан агуулгыг хэт өргөжүүлэх буюу хэт явцуу хүрээнд тайлбарлах нь уг гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын зорилготой зөрчилдөнө.

Өөртөө ашиг олох зорилгоор хохирогчийн эрх, эрх чөлөөг ноцтой хязгаарлаж хүсэл зоригийнх нь эсрэг мөлжлөгийн шинжтэй үйлдэл хийсэн, тийм нөхцөл байдалд оруулах үйл явцад оролцсон бол хүн худалдаалах гэмт хэрэгт тооцно. Энэ явцад хохирогч гэмт этгээдийн хяналт дор орсон байдаг. Олон улсын эрх зүйн хэм хэмжээнд хохирогчийн эрх, эрх чөлөөг хязгаарласан гэж үзэхэд шалгуур тогтоогоогүй. Ямар нөхцөл байдал дор хохирогчийн эрх, эрх чөлөөг хэр хэмжээнд хязгаарласнаар хүн худалдаалах гэмт хэргийн шинжийг хангах нь тухайн улс дахь уг гэмт явдлын илрэх хэлбэр, онцлогоос шалтгаална.

Гэмт хэргийн шинжид хамаарах ойлголтуудыг улс орнууд өөр өөрөөр тайлбарлан хэрэглэх явдал байсаар байгаа хэдий ч протоколд заасан агуулгыг үгийн ерөнхий утгаар нь уян хатан ойлгож хэрэглэх, ямар ч нөхцөлд хүн худалдаалах процессыг бүхэлд нь хамааруулан тодорхойлох ёстой. Жишээлбэл, хохирогчийг орогнуулах үйлдэл нь заавал орон байраар хангаж тэндээ хорих утгыг илэрхийлэхгүй бөгөөд тодорхой орон зай, цаг хугацаанд хохирогчийг мөлжих буюу албадан хөдөлмөрлүүлэх, биеийг нь үнэлүүлэх явцад гэмт этгээдийн хяналт дор хохирогчийн эрх, эрх чөлөө хязгаарлагдаж байгаа бол түүнийг орогнуулсан шинжид хамааруулж үзнэ.

Сүүлийн жилүүдэд протоколд заасан хүн худалдаалах тодорхойлолтод шууд нэрлэн заагдаагүй шинэ төрлийн мөлжлөгийн арга хэлбэрүүд технологийн тусламжтай бий болж байх бөгөөд энэ төрлийн цахим бэлгийн мөлжлөгийг олон улсын эрх зүйн субъектүүд, эрдэмтэн судлаачид тус протоколыг өргөжүүлэн тайлбарлах замаар түүнд хамааруулан ойлгож байна.



ХОЁРДУГААР БҮЛЭГ.

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ, УХАГДАХУУН

2.1 НҮБ-ын Палермогийн протоколд нэгдэн орохоос өмнө	20
2.2 НҮБ-ын Палермогийн протоколд нэгдэн орсны дараа	22

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ, УХАГДАХУУН

Хууль цаазын түүхэн уламжлалыг судлахын ач холбогдол нь тухайн үеийн нийгэм, улс төр, хууль цаазын онцлогийг танин мэдэх, тэдгээрийн ололттой талыг уламжлан алдаа дутагдлыг давтахгүй байх, ард түмнийхээ зан заншил, уламжлалаас суралцах, түүнчлэн уламжлал шинэчлэлийг уялдаа холбоотойгоор авч үзэхэд оршино.²⁵ Иймд энэхүү бүлэгт Монгол Улс Палермогийн протоколд нэгдэн орохоос өмнө болон нэгдэн орсны дараа хүн худалдаалах гэмт хэргийн шинжийг эрүүгийн эрх зүйн эх сурвалжуудад хуульчилж ирсэн түүхэн уламжлалыг судаллаа. Эрүүгийн хуулиудад хүн худалдаалах гэмт хэргийн шинжийг хүнийг худалдаалахаас өмнөх үйл явцыг хамруулсан үйлдэл эсвэл хүнийг худалдаалж мөлжлөгт оруулсан буюу үр дүнг хамруулсан үйлдэл байхаар томьёолсон эсэхийг хуульчилсан, шүүхийн, онолын тайлбаруудад тулгуурлан тодруулахаар зорив.

2.1 НҮБ-ЫН ПАЛЕРМОГИЙН ПРОТОКОЛД НЭГДЭН ОРОХООС ӨМНӨ

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (1996)²⁶

1996 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар тухайн үед хүчин төгөлдөр дагаж мөрдөж байсан 1986 оны Эрүүгийн хуулийн “Хүний хувийн эрх чөлөөнд халдсан гэмт хэрэг” бүлгийн 1111 дүгээр зүйлд “Хууран мэхлэх замаар хүмүүс элсүүлэх” гэж хүн худалдаалах гэмт хэргийг анх хуульчилж байжээ.

111 дүгээр зүйл. Хууран мэхлэх замаар хүмүүс элсүүлэх²⁷

1. Биеийг нь үнэлүүлж ашиг олох зорилгоор хууран мэхэлж хүмүүсийг элсүүлсэн бол дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
2. Энэ гэмт хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг этгээд үйлдсэн, эсхүл насанд хүрээгүй хүмүүсийг элсүүлсэн буюу биеийг нь үнэлүүлэх зорилгоор гадаадад гаргасан бол гурваас найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Хууран мэхлэх замаар хүмүүс элсүүлэх гэмт хэргийн үндсэн шинж нь ашиг олох зорилгоор буюу зөвхөн **“биеийг нь үнэлүүлэх”** хэлбэрээр үйлдсэн байхаар заасан байна. Объектив талын үйлдэлд **элсүүлэх**, үйлдлийн аргын хувьд **хууран мэхлэх** хэмээн гурван элементийн нэгдэлд тодорхойлжээ. Уг гэмт хэрэгт хамаарах албан ёсны тайлбар²⁸ байхгүй боловч албан ёсны бус тайлбарууд байна. Үүнд:²⁹ **“Элсүүлэх”** гэж тодорхой урамшуулал өгч хүмүүсийг хөлслөхөөр цуглуулсныг хэлнэ. Хөлслөх нөхцөл нь бичгээр болон амаар тохиролцсон байж болно, **“Хууран мэхлэх”** гэж ажилд оруулна, курс сургуульд явуулна, жуучлуулна гэх зэргээр хохирогчийг төөрөгдүүлэн түүнд итгэл төрүүлснийг хэлнэ. **“Биеийг нь үнэлүүлэх зорилгоор гадаадад гаргасан”** гэж хуурч мэхлэх замаар өөр улс гүрэнд явуулж биеийг нь үнэлүүлснийг ойлгоно³⁰ хэмээн тайлбарлажээ.

1996 оны Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хүн худалдаалах гэмт хэргийг **хүнийг мөлжлөгт оруулахаас өмнөх үйл явцад хамаарах элсүүлэх үйлдэл** хийснээр төгсдөг хохирол, хор уршиг заавал учирсан байхыг шаардахгүй хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг байхаар хуульчилж байжээ.

Эрүүгийн хууль (2002)

2002 оны Эрүүгийн хуулийн “Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд нэр төрийн эсрэг гэмт хэрэг” бүлгийн 113 дугаар зүйлд “Хүн худалдах, худалдан авах” гэмт хэргийг хуульчилжээ.

113 дугаар зүйл. Хүн худалдах, худалдан авах³¹

113.1. Хүн худалдсан буюу худалдан авсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурван зуугаас таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ.

113.2. Энэ хэргийг:

- 113.2.1. хүний цус, эд, эрхтнийг ашиглах зорилгоор;
- 113.2.2. биеийг нь үнэлүүлэх зорилгоор;
- 113.2.3. давтан;
- 113.2.4. хоёр буюу түүнээс олон хүнийг;
- 113.2.5. насанд хүрээгүй хүнийг;
- 113.2.6 бүлэглэж буюу урьдчилсан үгсэж тохиролцсон бүлэг үйлдсэн бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

113.3. Энэ гэмт хэргийг байнга үйлдсэн, хүнийг хил давуулан худалдсан, эсхүл зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл уг гэмт хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Хүн худалдаалах гэмт хэргийг тусгайлан хуульчилсан боловч гэмт хэргийн шинжийг тодорхой бус тусгажээ. Тухайлбал гэмт хэргийн үндсэн шинжид үйлдлийн аргыг заагаагүй буюу үйлдлийг ерөнхийлөн “хүн худалдсан буюу худалдан авсан” байх, хүндрүүлэх бүрэлдэхүүнд мөлжих зорилгын хэлбэрүүдийг (биеийг нь үнэлүүлэх, цус, эд, эрхтнийг ашиглах) хуульчилсан байна. Хүн худалдаалах гэмт хэргийн үндсэн шинж нь гэмт хэргийн ангиллын хүндэвтэр гэмт хэрэгт багтаж байсныг зарим эрдэмтэд шүүмжлэн “Энэ төрлийн гэмт хэрэг нь зөвхөн хүнд, онц хүнд гэмт хэргийн ангилалд багтах ёстой”³² хэмээн бичсэнээс үзвэл ялын бодлогыг чангатгах шаардлагатай хэмээн үзэж байсны илрэл юм.

2002 оны Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд албан ёсны тайлбар хийгээгүй боловч албан ёсны бус тайлбар байх бөгөөд эл тайлбарт “Уг гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив тал нь хүн худалдсан буюу худалдан авсан үйлдэл байна. Энэ худалдах, худалдан авах үйлдлийн **хэлцлийн зүйл нь хүн байдаг** онцлогтойгоос өөрөөр ердийн худалдааны гэрээнээс ялгарах зүйл үгүй. Өөрөөр хэлбэл, нэг субъект худалдаж нөгөө этгээд худалдан авагчид **хүн шилжүүлэн өгөх** бөгөөд үнэ өртгийг нь тохиролцсон ёсоор авах. Нөгөө субъект нь худалдан авагч худалдагдаж байгаа хүнийг авч түүний үнэ өртгийг тохиролцсон ёсоор өгөх үйлдлүүд”³⁴ байна хэмээн тайлбарлажээ.

Эрүүгийн хуульд хүнийг худалдан авагчид шилжүүлж, улмаар тохиролцсон үнэ хөлсийг авах буюу ашиг олсныг хүн худалдаалах гэмт хэрэг хэмээн тодорхойлж байжээ. Энэ нь **үр дүнг хамруулсан үйлдлийг** хүн худалдаалах гэмт хэрэг хэмээн тодорхойлж байгааг илтгэх бол хохирогчийг худалдан авагчид шилжүүлэн өгч, ашиг олохоос өмнөх үйл явцыг хамруулсан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, орогнуулах, хүлээн авах үйлдлүүдийг орхигдуулжээ. Протоколд нэгдэн орохоос өмнө манай улсад хүн худалдаалах гэмт хэргийг зөвхөн үйл явцыг хамруулсан үйлдэл, эсхүл үр дүнг хамруулсан үйлдлийн хүрээнд тодорхойлсон байна.

2.2 НҮБ-ЫН ПАЛЕРМОГИЙН ПРОТОКОЛД НЭГДЭН ОРСНЫ ДАРАА

Монгол улс 2008 онд Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцын нэмэлт болох “Хүн ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай” протоколд нэгдэн орж, хүн худалдаалах гэмт хэргийг олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн томьёолохоор 2008 онд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (2008)³⁵

113 дугаар зүйл. Хүн худалдаалах

113.1. Ашиг олох буюу мөлжих зорилгоор **хүн худалдаалахдаа** хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, хууран мэхэлсэн, эмзэг байдлыг нь далимдуулсан, түүнчлэн бусдыг элсүүлсэн, тээвэрлэсэн, дамжуулсан, орогнуулсан, хүлээн авсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

113.2 Энэ хэргийг:

- 113.2.1. насанд хүрээгүй хүнийг,
- 113.2.2. хоёр буюу түүнээс олон хүнийг,
- 113.2.3. хулгайлах,
- 113.2.4. эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эрхшээлдээ байгаа хүнийг,
- 113.2.5. давтан,
- 113.2.6. бүлэглэж буюу урьдчилан үсгэж тохиролцсон бүлэг үйлдсэн бол

Тайлбар 1. Энэ хуулийн 113.1-д заасан “мөлжих” гэдгийг худалдсан хүний биеийг нь үнэлүүлэх зэргээр бэлгийн хүчирхийлэлд оруулах, боолчлох болон түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, албадан хөдөлмөр хийлгэх, эд эрхтнийг нь авч ашиглах гэсэн утгаар ойлгоно.

Уг нэмэлт өөрчлөлтөөр хүн худалдаалах гэмт хэрэг нь хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, хууран мэхэлсэн, эмзэг байдлыг нь далимдуулсан гэсэн үйлдлийн аргуудтай байхаар хуульчилжээ. Харин хулгайлах, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эрхшээлдээ байгаа хүнийг худалдаалах гэсэн үйлдлийн аргуудыг хүндрүүлэх бүрэлдэхүүнд тусгасан байна. Үүнээс гадна мөлжлөгийн хэлбэрийг хүндрүүлэх шинжид хуульчилж ирсэн уламжлалыг нэг мөр халжээ.

Дээрх нэмэлт өөрчлөлтөөр хууль тогтоогчоос хүн худалдаалах гэмт хэрэгт албан ёсны тайлбарын нэг төрөл болох аутентик тайлбарыг хийсэн байна. Тодруулбал, аутентик тайлбараар **"мөлжих"** гэдгийг худалдсан хүний биеийг нь үнэлүүлэх зэргээр бэлгийн хүчирхийлэлд оруулах, боолчлох болон түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, албадан хөдөлмөр хийлгэх, эд эрхтнийг нь авч ашиглах гэсэн утгаар ойлгоно гэжээ. Үүний дараа Улсын дээд шүүх /цаашид "УДШ" гэх/-ээс 2008 оны 03 дугаар сарын 26-ны өдөр "Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай" 12 дугаар тогтоолоор³⁶ хүн худалдаалах гэмт хэргийн зарим нэр томьёо (I) болон өрсөлдөх хэм хэмжээнээс ялгах шинжийг(II) тайлбарласан байна. Үүнд:

(I) Хүн худалдаалах гэмт хэргийн зарим нэр томьёоны тайлбар

"Хүн худалдаалах" гэдэгт тодорхой төлбөртэйгөөр (мөнгө авах, эд хөрөнгө болон түүнийг өмчлөх эрхээр солилцох г.м) эсхүл ямар нэгэн үүргийн гүйцэтгэлд тооцож (өрөнд өгөх г.м) хүнийг бусад хүмүүсийн мэдэлд бүр мөсөн буюу тодорхой хугацаагаар шилжүүлэхийг ойлгоно. **"Ашиг олох зорилгоор"** гэж хүн худалдаалах замаар өөртөө болон бусад этгээдэд эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус ашигтай байдал, орлого бий болсон байхыг хэлнэ.

Эндээс үзвэл хүнийг бусад хүмүүсийн мэдэлд шилжүүлж, улмаар өөртөө болон бусад этгээдэд эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус ашигтай байдал, орлого бий болгосныг хүн худалдаалах гэмт хэрэг хэмээн үзэж байжээ.

Харин уг гэмт хэргийн субъектийг гэмт үйлдлээс хамааран өөр өөр байхаар хуульчилсан байна. Тодруулбал, хууль зүйн техникийн хувьд 2002 оны Эрүүгийн хуульд "түүнчлэн" гэх холбоос үгийг ихээр ашигласан. Хүн худалдаалах гэмт хэргийн үндсэн шинжийг томьёолохдоо уг холбоо үгийг ашиглан диспозиц хэсгийг *"... түүнчлэн бусдыг элсүүлсэн, тээвэрлэсэн, дамжуулсан, орогнуулсан, хүлээн авсан бол"* гэж тусгасан байна. Энэ нь "түүнчлэн" гэх үгнээс өмнөх хэсэгт хүнийг мөлжих зорилгоор худалдаалж буй этгээдийн үйлдэл харин холбоосноос хойш **"элсүүлэх"** үйлдлээс бусад үйлдлийг хүн худалдаалж байгааг мэдсэн этгээдийн үйлдэл байхаар томьёолжээ. Мөн УДШ-ийн тайлбарт элсүүлсэн, тээвэрлэсэн, дамжуулсан, орогнуулсан, хүлээн авсан үйлдлийг **хүн худалдаалж байгааг мэдсэн этгээдийн хийж буй гэмт үйлдэл** хэмээн тайлбарласан байдаг.

"Элсүүлсэн" гэж хүнийг худалдаалах зорилгоор тухайн болон бусад этгээдийг айлган сүрдүүлэх, тулган шаардах, ятгах замаар гэмт ажиллагааны оролцогч болгох аливаа үйлдлийг хэлнэ. **Хүн худалдаалах гэмт хэргийг үйлдэхдээ бусдыг татан оролцуулахаас гадна хохирогчийн биеэ хамгаалах чадваргүй болон эрхшээлдээ байгаа байдал зэргийг далимдуулан зөвшөөрүүлэх явдал нь энэ ойлголтод нэгэн адил хамаарна.**

"Тээвэрлэсэн" гэдэгт **хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд** худалдаалагдаж буй хүнийг нэг газраас нөгөөд бүх төрлийн тээврийн хэрэгслээр ил болон далд хэлбэрээр зөөвөрлөхөөс гадна уг ажиллагаанд бүх талын дэмжлэг тусалцаа үзүүлэхийг ойлгоно. Хүн худалдаалж байгаа этгээд өөрөө тээвэрлэсэн бол энэ нь түүний гэмт үйлдлийн нэг хэсэг болно.

“Дамжуулсан” гэж **хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд** хүнийг гуравдагч улсын нутаг дэвсгэрээр дамжуулан хил нэвтрүүлэх, нэг этгээдээс нөгөөд хүнийг шилжүүлэх болон уг ажиллагаанд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэхийг хэлнэ.

“Орогнуулсан” гэдэгт **хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд** худалдаалагдаж буй хүнийг хүлээн авах этгээдэд шилжих хүртэл түр хугацаагаар өөрийн, эсхүл бусдын орон байранд хяналттай болон хяналтгүйгээр нуугдуулан байрлуулахыг ойлгоно.

“Хүлээн авсан” гэж **худалдаалагдсан хүнийг** өөрийн мэдэлд байлгаж, ашиглахаар шилжүүлэн авахыг ойлгоно гэжээ.

Зарим эрдэмтдийн бүтээлд хүн худалдаалах нь **нэгдүгээрт** хүнийг худалдах-худалдан авах ба бусад хэлцэл, **хоёрдугаарт** хүнийг мөлжихөд тус дөхөм үзүүлсэн буюу мөлжих нөхцөлийг буй болгосон үйлдэл (элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан, хүлээн авсан)-ээр илэрдэг хэмээн дурджээ. Дээрх тайлбаруудаас харвал 2008 оны Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хүн худалдаалах гэмт хэргийг **үйл явцыг хамруулсан үйлдэл** (хохирогчийг элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, орогнуулах, хүлээн авах) болон **үр дүнг хамруулсан үйлдэл** (хүн худалдаалж ашиг олсон) хоёуланг нь зэрэгцүүлэн хуульчилсан байна.

(II) Төсөөтэй гэмт хэргээс ялгах

Хүн худалдаалах гэмт хэргийг “Ашиг олох буюу мөлжих зорилгоор” үйлдэх бөгөөд мөлжих гэдэгт худалдсан хүний биеийг үнэлүүлэх зэргээр бэлгийн хүчирхийлэлд оруулах...” хэмээн аутентик тайлбар хийсэн. Иймд уг гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлд заасан “Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах” гэмт хэргээс ялган зүйлчлэх шаардлага бий болжээ.

113 дугаар зүйл. Хүн худалдаалах

113.1. Ашиг олох буюу мөлжих зорилгоор хүн худалдаалахдаа хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, хууран мэхэлсэн, эмзэг байдлыг нь далимдуулсан, түүнчлэн бусдыг элсүүлсэн, тээвэрлэсэн, дамжуулсан, орогнуулсан, хүлээн авсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар1. Энэ хуулийн 113.1-д заасан “мөлжих” гэдгийг худалдсан **хүний биеийг нь үнэлүүлэх зэргээр бэлгийн хүчирхийлэлд оруулах**, боолчлох болон түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, албадан хөдөлмөр хийлгэх, эд эрхтнийг нь авч ашиглах гэсэн утгаар ойлгоно.

124 дүгээр зүйл. Биеэ үнэлэхэд татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах

124.1. Хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж, хуурч мэхлэх замаар биеэ үнэлэхэд татан оролцуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавиас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

124.2. Биеэ үнэлэх газар байгуулсан, санхүүжүүлсэн, түүнчлэн биеэ үнэлэхэд зуучилсан, тээврийн хэрэгсэл, орон байр, бусад зүйлсээр үйлчилсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурван зуугаас дөрвөн зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

124.3. Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

УДШ-ийн тогтоолд хүн худалдаалах гэмт хэрэг нь биеэ үнэлэхэд татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргээс дараах **5** шинжээр ялгаатай хэмээн тайлбарлажээ.

1. **Хохирогчийн хүсэл зориг**- Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд заасан **"биеийг нь үнэлүүлэх"** гэдэг нь хохирогчийн хүсэл зоригоос гадуур, тулган шаардаж, хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж, түүнийг бэлгийн харьцаанд оруулдаг. Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлд заасан **"биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах"** гэмт хэрэгт хохирогчийн хүсэл зоригоос гадуур, тулган шаардаж, хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлсэн байх шинж нь заавал байх шинж биш.
2. **Хохирогчийн чөлөөт байдал**-Хүнийг худалдаалах гэмт хэргийн хохирогчийг бусад хүмүүсийн мэдэлд бүрмөсөн буюу тодорхой хугацаагаар, төлбөртэйгөөр эсхүл ямар нэгэн үүргийн гүйцэтгэлд тооцож шилжүүлдэг. Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулсан, зохион байгуулсан, зуучилсан гэмт хэргийн хувьд ийм шинж байдаггүйгээр ялгагдана.
3. **Ашгийн хуваарилалт** -Хүн худалдаалах гэмт хэрэгт хохирогчийн биеийг нь үнэлүүлсэн болон бусад хэлбэрээр бэлгийн хүчирхийлэлд оруулсны орлого **бүхэлдээ гэмт этгээдийн ашиг болдог**. Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулсан, зохион байгуулсан гэмт хэргийн хувьд, орлогын **тодорхой хэсэг нь гэмт этгээдийн мэдэлд шилжинэ**.
4. **Эрх чөлөөг нь хязгаарласан эсэх**-Хүн худалдаалах гэмт хэргийн хувьд **хохирогчийн эрх, эрх чөлөө гэмт этгээдээс бүрэн хамааралтай, боолчлогдох шинжтэй** байна. Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулсан, зохион байгуулсан гэмт хэргийн хувьд биеэ үнэлж байгаа этгээд нь гэмт этгээдээс ямар нэгэн байдлаар хараат байх боловч эрх, эрх чөлөө нь бүрэн хязгаарлагдсан шинжгүй байна.
5. **Биеийг нь үнэлүүлэхийг урьдчилан мэдсэн байх**-Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч **"биеийг нь үнэлүүлэх"-ийг урьдчилан мэдээгүй байдаг**. Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулсан, зохион байгуулсан гэмт хэргийн хувьд биеэ үнэлж байгаа этгээд үүнийг урьдчилан мэдсэн байдаг.

Хүн худалдаалах гэмт хэрэг нь хохирогчид албадлага хэрэглэсэн эсвэл хэрэглэхээр заналхийлж бусадтай хүчээр бэлгийн харьцаанд оруулдаг, түүнээс бий болсон ашгийг бүхэлд нь өөртөө авдаг, мөн **хохирогчийн эрх, эрх чөлөө гэмт этгээдээс бүрэн хамааралтай байх** зэрэг шинжээрээ биеэ үнэлэхэд татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргээс ялгаатай байна.

Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хууль (2012)

УДШ “Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай” тогтоол гаргаснаас хойш 4 жилийн дараа буюу 2012 онд Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг баталж, Эрүүгийн хуулийн холбогдох заалтад дахин нэмэлт өөрчлөлт оруулсан.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012)³⁸ 3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт 3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно: 3.1.1.“хүн худалдаалах” гэж хүнийг биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, хууль бусаар албадан хөдөлмөрлүүлэх, эс, эд эрхтнийг нь авч ашиглан мөлжих зорилгоор хүнд хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, түүнчлэн өөр хүнийг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан, дамжуулсан, хүлээн авсан хууль бус үйлдлийг;	Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хууль (2012)³⁹ 1 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай: 113 дугаар зүйл. Хүн худалдаалах 113.1.Хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, түүнчлэн өөр хүнийг эрхшээлдээ байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, ашиг олгон хахуульдах аргаар хүнийг хүн худалдаалах гэмт үйлдэлд элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан, дамжуулсан, хүлээн авсан бол эд хөрөнгийг хурааж, гурваас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
--	--

Уг нэмэлт, өөрчлөлтөөр хүн худалдаалах гэмт хэргийн үйлдлийн аргад эрх мэдлээ урвуулан ашиглах, хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, түүнчлэн өөр хүнийг эрхшээлдээ байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, ашиг олгон хахуульдах үйлдлийн аргуудыг нэмсэн нь протоколд заасан үйлдлийн аргуудыг бүрэн хамруулах, аль болох өргөн хүрээнд хуульчлах бодлого баримталжээ.

Өмнөх эрүүгийн хуулиудад хүн худалдаалах гэмт хэргийн диспозицод хүн худалдаалсан буюу хүнийг хэлцлийн зүйл байхаар тусгаж ирсэн. Тухайлбал 2002 оны Эрүүгийн хуульд “хүн худалдсан буюу худалдан авсан бол”, 2008 оны нэмэлт, өөрчлөлтөөр “...хүн худалдаалахдаа” гэж зааж байсныг 2012 оны нэмэлт өөрчлөлтөөр “хүнийг мөлжих зорилгоорхүнийг хүн худалдаалах гэмт үйлдэлд элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан, дамжуулсан, хүлээн авсан бол.” гэж заажээ. Энэ нь **хүнийг янз бүрийн хэлбэрээр мөлжиж ашиг олохоос өмнөх үйл явцад хамаарах үйлдлүүд нь хүн худалдаалах гэмт хэрэг байхаар томьёолсон байна.**

Үүнээс гадна дээрх нэмэлт өөрчлөлтийн аутентик тайлбарт **“113.1-д заасан аргыг хэрэглээгүй байсан ч арван найман насанд хүрээгүй хүнийг хүн худалдаалах гэмт**

хэргийн зорилгоор элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун дарагдуулсан, дамжуулсан, хүлээн авсан бол хүн худалдаалсан гэж үзнэ" гэжээ. Өмнөх хуулиудад үйлдлийг аргыг хохирогчийн насанд хамаатуулсан зохицуулалт байгаагүй ч 2012 оны нэмэлт, өөрчлөлтөөр хохирогч 18 насанд хүрээгүй тохиолдолд хуульд заасан үйлдлийн аргаар уг гэмт хэргийг үйлдсэн байхыг шаардахгүй байхаар хуульчилсан нь протоколын зорилгод нийсэн байна.

1986 оны Эрүүгийн хуулиас эхлэн хуульчилж ирсэн хүн худалдаах гэмт хэргийг 2012 оны Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Палермогийн протоколын тодорхойлолттой нийцүүлэн мөлжлөгийн хэлбэр, үйлдэл, үйлдлийн аргыг өргөн хүрээнд хамруулан хуульчилсан байна. Түүнчлэн хүн худалдаалах гэмт хэргийн үйлдлийн арга болох хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж, хуурч мэхлэх аргуудыг биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэгт заасан байсныг хассанаар⁴⁰ хүн худалдаалах гэмт хэргийн шинжтэй давхардал үүссэн байсныг арилгажээ.

Энэ өөрчлөлтийн гол томъёолол нь хүн худалдаалах гэмт хэрэг нь хүнийг аливаа хэлбэрээр мөлжиж ашиг олохоос өмнөх үйл явцыг хамруулсан үйлдлүүд байхаар тодорхойлсноос гадна өрсөлдөх хэм хэмжээний үйлдлийн аргыг хассан. Дээрхээс дүгнэвэл 2002 оны Эрүүгийн хууль болон Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулиар хүн худалдаалах гэмт хэргийг үр дүнд хамруулсан үйлдэл хэмээн тайлбарлаж байсан албан ёсны тайлбарыг цаашид ашиглах боломжгүй болжээ.

Эрүүгийн хууль (2015)

2015 оны Эрүүгийн хуулийн шинэтгэл нь Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний суурь эрх, халдашгүй байдлыг илүү баталгаажуулж, шинээр хамгаалах шаардлагатай харилцаа, хүний эрх, эрх чөлөө, халдашгүй байдлыг хамгаалах хууль эрх зүйн баталгаатай орчныг бүрдүүлэхэд чиглэжээ. Шинээр орчин үед гарч байгаа гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тодорхойлж зарим гэмт хэргийг хуулийн төсөлд тусгаснаас гадна практикт хэрэглэхэд төвөгтэй, ялын бодлогын хувьд үр нөлөө багатай олон зүйл, заалтын диспозиц шинж, оногдуулах санкцыг төрийн бодлого, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэхээр тодорхойлсон.⁴¹ Эрүүгийн хуулийн тусгай ангид хийх өөрчлөлтөд хүүхдийн эсрэг гэмт хэрэг, **бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг** гэсэн бүлгүүдийг шинээр оруулж энэ төрлийн гэмт хэргийн ялын бодлогыг чангатгахаар хуулийн төсөлд заасан байна.

2015 оны Эрүүгийн хуулийг хүчин төгөлдөр дагаж мөрдөх хүртэл хэд хэдэн удаагийн төсөл, нэмэлт өөрчлөлтийг дамжсан тул эрүүгийн хуулийн үзэл баримтлал, мөн чанарыг нээн илрүүлэхэд 2013 оны Гэмт хэргийн тухай хуулийн төсөл буюу анхны хувилбараас эхлэн судлах нь зүйтэй.

Хүн худалдаалах гэмт хэргийн шинжийг 2013 оны Гэмт хэргийн тухай хуулийн төсөл болон 2015 оны Эрүүгийн хуулиас харьцуулан үзвэл:

Гэмт хэргийн тухай хуулийн төсөл ⁴²	Эрүүгийн хууль
13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах 1. Хүнийг биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, хууль бусаар албадан хөдөлмөрлүүлэх, эд эрхтнийг нь авч ашиглах мөлжих зорилгоор хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, түүнчлэн өөр хүнийг хяналтдаа байлгаж байгаа хүний зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан, дамжуулсан, хүлээн авсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2. Энэ гэмт хэргийг: 1.1 хүүхэд, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж; 1.2 хоёр, эсхүл түүнээс дээш хүнийг; 1.3 Монгол Улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3. Энэ гэмт хэргийг: 1.1 тогтмол үйлдэж орлогын эх үүсвэр болгосон 1.2 зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн 1.3 хохилогч сэтгэцийн эдгэршгүй өвчтэй болсон, эсхүл бие махбодод хүнд хохирол учруулсан, эсхүл хохирогч нас барсан бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ. Тайлбар. -хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэн тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.	13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах 1.Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2.Энэ гэмт хэргийг: 2.1.хүүхэд, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж; 2.2.хоёр, түүнээс олон хүнийг худалдаалж; 2.3.Монгол Улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3.Энэ гэмт хэргийг: 3.1.байнга тогтвортой; 3.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ. Тайлбар: -Хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй. -Энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход хохирогч өөрийг нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар хохироож байгааг өөрөө зөвшөөрсөн эсэх нь гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй.

Хүн худалдаалах гэмт хэргийг 2015 оны Эрүүгийн хуульд ч мөн өмнөх эрүүгийн хуультай адил хүн худалдаалах гэмт хэргээс өмнөх үйл явцыг хамруулсан үйлдлийг эрүүжүүлсэн.

2015 оны Эрүүгийн хуулийн хүн худалдаалах гэмт хэргийн шинжид зарим найруулгын шинжтэй өөрчлөлтүүд оруулж нуун далдлах үйлдэл, материаллаг бүрэлдэхүүнтэй хүндрүүлэх шинжийг хассан бол итгэл эвдэх үйлдлийн арга, эрхшээлдээ оруулахыг нэмж хуульчилсан байна. Харин Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд тусгасан хүн худалдаалах гэмт хэргийн бусад концепцыг хэвээр хуульчилжээ.⁴³

Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг энэ гэмт хэргийг томьёолохдоо протоколын тодорхойлолтыг голлон баримталж, агуулгыг бүрэн хамруулахаар зорьж өргөн хүрээнд хуульчилсан байна.⁴⁴ Энэ үүднээсээ хүн худалдаалах гэмт хэргийн шинж нь олон улсын эрх зүйн эх сурвалжтай нийцсэн гэж дүгнэж болох юм.

2015 оны Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсанаар бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг бүлгийг шинээр нэмж 12.3 дугаар зүйлд бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг хуульчилжээ. Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн шинжийг Гэмт хэргийн тухай хуулийн төсөл болон 2015 оны Эрүүгийн хуулиас харьцуулан үзвэл:

2013 оны Гэмт хэргийн тухай хуулийн төсөл ⁴⁵	2015 оны Эрүүгийн хууль
12.3 дугаар зүйл. Бэлгийн мөлжлөгт албадах 1. Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан бусадтай бэлгийн харьцаанд ороход албадсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2. Энэ гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор:	12.3 дугаар зүйл. Бэлгийн мөлжлөг 1. Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2. Энэ гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор:

Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн шинжийг эцэслэн батлагдсан эрүүгийн хуулиас үзвэл үйлдлийн арга, үйлдэлд төдийлөн өөрчлөлт оруулаагүй боловч “зорчих эрхийг хязгаарлахгүйгээр” гэх шинжийг нэмж хуульчилснаас гадна ялын бодлогын хувьд өөрчлөлт оруулсан буюу 2-8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр тусгасан байсныг 1-5 жил болгожээ. Өөрөөр хэлбэл, хүчин төгөлдөр мөрдөж буй эрүүгийн хуулийн гэмт хэргийн ангиллаар бол хүнд гэмт хэрэг байсныг хөнгөн гэмт хэрэгт хамруулсан байна.

Хуулийн төсөлд тус гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнийг хохирогчийн тоо, нас, эрүүл мэндийн үр дагаврыг харгалзан “Энэ гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор” гэж хүн худалдаалах гэмт хэргийн мөлжлөгийн нэг хэлбэрийг хамруулснаас гадна зарим үйлдэл, үйлдлийг аргыг хуульчилж өрсөлдөх хэм хэмжээ бий болгосон нь өдгөө хууль хэрэглэхэд эргэлзээ үүсгэсэн нөхцөл байдалд оруулжээ. Үүнийг дотоодын бусад судалгааны бүтээлүүдэд хэдийн хөндсөн⁴⁶ байх тул дэлгэрүүлэлгүй үлдээе.

Судалгааны баг хууль тогтоогчийн үзэл баримтлал, хүсэл зоригийг тодруулах үүднээс 2015 оны Эрүүгийн хуулийн хувийн хэргийг судлахад Хууль зүйн байнгын хороо, Улсын Их Хурал /цаашид “УИХ” гэх/-ын чуулганы хуралдаанаар хүнийг худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн талаар тодорхой зүйл дурдаагүй байна. Хуулийн төсөлд өгсөн саналд доорх **хоёр** асуудлыг хөнджээ. Үүнд:

- **Эрүүгийн хуулийн төслийн талаар экспертийн албанаас гаргасан зөвлөмжид:** "...Төслийн 12.3 дугаар зүйлийн бэлгийн мөлжлөг, 13.1 дүгээр зүйлийн эд эрхтнийг нь авч мөлжих зорилгоор..., үг хэллэгийг оновчгүй сонгосон байгаа нь хууль хэрэглэхэд хүндрэл учруулахаар байна"⁴⁷
- **Улсын ерөнхий прокурорын газраас өгсөн саналд:** "... Энэ хуулийн 12.3 дугаар зүйл, 13.1 дүгээр зүйлийг хооронд нь хэрхэн ялгах, боломжтой бол нэгтгэж нэг зүйл болгох"⁴⁸-оор санал оруулж байжээ.

Улмаар УИХ-ын 2015 оны хаврын ээлжит чуулганаар Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж төслийн 12.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "далимдуулан" гэсний дараа **"зорчих эрхийг хязгаарлахгүйгээр"** гэж, 13.1 дүгээр зүйлийн 1 хэсгийн "хууль бусаар албадан хөдөлмөрлүүлэх, эд эрхтнийг нь авч мөлжих" гэснийг "эд эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж, мөлжих" гэж өөрчлөх саналыг тус тус дэмжсэн байна.⁴⁹ Энэхүү хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлээс үзэхэд гишүүд холбогдох асуулт асуугаагүй, хэлэлцүүлэг хийгээгүй байна.

Хуулийн хувийн хэргийг судлаад тодорхой үр дүнд хүрээгүй тул 2015 оны Эрүүгийн хуулийн төслийг боловсруулсан ажлын хэсгийн гишүүдээс ганцаарчилсан ярилцлагын аргаар бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг тусгах болсон үзэл баримтлалыг тодруулахаар зорьсон.⁵⁰ Судалгаанд хамрагдсан ажлын хэсгийн гишүүд бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг хуульчлах болсон шалтгаан нөхцөлийг дараах байдлаар тайлбарлаж байв.

Шигтгээ №.1 Ярилцлагын судалгааны хэсгээс

Г.Эрдэнэбат: Анхны бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн томъёололд зорчих эрхийг хязгаарлах гэдэг шинж байгаагүй. Практикт ямар байна вэ гэвэл хүний биеийг нь үнэлүүлж ашиг олохгүйгээр дуудаж авчраад хүнтэй бэлгийн харьцаанд оруулах, хэрвээ үгүй бол чамайг тэгнэ ингэнэ гэж заналхийлдэг. Бэлгийн харьцаанд оруулахыг албадаад байгааг бэлгийн мөлжлөг гэсэн болохоос биш хүн авчраад айлгаад, хэдэн төгрөг гэж унтуулаад мөнгийг нь авч байгааг хүний наймаа гэж хуульчлах байтал зорчих эрхийг хязгаарлахгүйгээр хүн зарсныг бэлгийн мөлжлөг гэж хуульчилсандаа асуудал байгаа.

Ямар асуудал гарсан бэ гэхээр хүн худалдаалах гэмт хэргийн шинжийг хангаагүй буюу айлгаж, эрхшээлдээ оруулж бизнес болгоогүй буюу найз охиноо дуудаад, архи уулгаад суулгаж байснаа чи энэнтэй унт гэсэн үйлдлийг бэлгийн мөлжлөг байна гээд энэ гэмт хэргийг хуульчилсан.

Хуулийн төслийг боловсруулах харьцуулсан судалгаанд АНУ-ын хэд хэдэн муж, Герман улс зэрэг гол арван улсын эрүүгийн хууль, эрүүгийн загвар хуулийг харсан. Бэлгийн мөлжлөг болон хүн худалдаалах гэмт хэрэг хосолсон хуультай улс нэлээн олон байсан. Бэлгийн мөлжлөгийг хасаад хүн худалдаалах гэмт хэргийг дангаар нь үлдээвэл хийдэл үүснэ. Хүнийг биеийг нь үнэлүүлэхийн тулд дарамтлаад айлгаад өөртөө мөнгө авах үгүй нь хамаагүй буюу ашиг олохгүйгээр унтуулахыг гэмт хэрэгт тооцох ёстой. Үүнийг бэлгийн мөлжлөг гэдэг. Хэрэв огт хуульчлахгүйгээр орхигдуулбал ашиг олохгүйгээр бэлгийн харьцаанд албадсан үйлдэл үлдчихнэ.

Шигтгээ №.2 Ярилцлагын судалгааны хэсгээс

Б.Гантуяа: Human trafficking гэдгийг монгол хэлэнд хүн худалдаалах эсхүл мөлжлөг гэж буулгах гэх мэт өгсөн нэр томъёоноос үл хамааран конвенцод заасан үйлдлүүд манай улсын эрүүгийн хуулийн аль аль зүйл анги дээр байгааг хайж байгаад тэр зүйл ангиуд практик дээр зөв байна уу гэдгийг олон улсын үнэлгээний баг хардаг. Энэ талаасаа харвал бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг болон хүн худалдаалах гэмт хэргүүд аль аль нь протоколд заасан хүн худалдаалах гэмт хэрэг.

Ажлын хэсэг бэлгийн мөлжлөг болон хүн худалдаалах гэмт хэргийг ялгах болсон гол шалтгаан нь манай практиктай холбоотой. Хүн худалдаалах гэмт хэргийг ерөнхийд нь томъёолбол хохирогчийг ямар нэгэн байдлаар эрхшээлдээ оруулдаг буюу чөлөөтэй цагдаад гомдол гаргах зэрэг эрхээ хамгаалах боломжгүй нөхцөл байдалд оруулдаг. Хууль сахиулах, мөрдөн шалгах чиг үүрэг бүхий байгууллагын ажилтнууд “манайд гардаг тохиолдол нь хадмууд нь бэрийнхээ биеийг нь үнэлүүлж ашиг олдог, бэр бол чөлөөтэй гадуур явж байдаг”. Энэ тохиолдолд хохирогч бусдаас тусламж хүсэх, цагдаад хандах боломжтой байдаг бөгөөд 2002 оны Эрүүгийн хуульд заасан хүн худалдаалах гэмт хэргийн шинжтэй таардаггүй байсан. Иймд дээрх тохиолдолд тусдаа гэмт хэрэг гаргая гэснээр бэлгийн мөлжлөгийг хуульчилсан. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчтой адилтгаж үзэх боломжгүй буюу харьцангуй чөлөөтэй байдаг.⁵¹

Шигтгээ №.3 Ярилцлагын судалгааны хэсгээс

Г.Оюунболд: Бэлгийн мөлжлөг гэж тусдаа гэмт хэрэг байх шаардлагатай. Үйлдлийн хувьд зарим нэг шинж нь хүн худалдаалахтай төстэй. Гэхдээ Олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенц, насанд хүрээгүй хүүхдийг бэлгийн мөлжлөгөөс хамгаалахтай холбоотой конвенц байдаг. Үүнд нэгдэн орсны хувьд бэлгийн мөлжлөгийг гэмт хэрэгт тооцно.

Бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг хоорондоо ялгагдахгүй байна гэдэг саналууд мөрдөн шалгах байгууллага, прокуророос ирсэн. Ажлын хэсэг конвенцын агуулгыг хэд хэдэн удаа судалж хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч бол бусдын эрхшээлд байгаа хүн юм байна. Ямар нэг үйлдлийн аргаар эрхшээлдээ оруулж мөлжлөг хийж байгаа явдал бол худалдаалах болж байна. Энэ ялгааг бэлгийн мөлжлөг гэмт хэрэг дээр оруулсан. Бусдын эрхшээлд байгаа шинжийн хамгийн гол зүйл бол зорчин явах эрх хязгаарлагдсан хүн. Ийм л агуулгатай гэж конвенцын агуулгыг олон дахин уншиж байж тодруулсан.

Дээрхээс ярилцлагуудаас дүгнэвэл бэлгийн мөлжлөг болон хүн худалдаалах гэмт хэргүүдийг олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн хуульчлахын сацуу, дотоодын гэмт явдлын хэв маяг, онцлогийг харгалзан ялгаатай гэмт үйлдлүүдийг хуульчлахыг зорьсон нь харагдаж байна. Ингэхдээ хүн худалдаалах гэмт хэргийн үйл явцад хамаарах үйлдлүүдийг тусгаж, харин бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн ердийн болон хүндрүүлэх бүрэлдэхүүнд хүн худалдаалах ба мөлжих зорилгогүйгээр бусадтай бэлгийн харилцаанд оруулах үйлдлүүдийг хольж тодорхойлсон нь хууль хэрэглээний хувьд гол бэрхшээл дагуулсан асуудал болжээ гэж дүгнэхээр байна.

Эрүүгийн хэргийн шүүхүүдээс ирүүлсэн 2021-2023 оны шийдвэр мөн 2017-2023 оныг хүртэлх хугацаанд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгээр шүүхийн шийдвэрийн цахим сангаас хайлт хийхэд 2 шийдвэрийн илэрц байх боловч эхнийх нь хүчиндэх гэмт хэргийн тогтоол, удаах тогтоол нь нууцлалтай байна. Иймд хүчин төгөлдөр үйлчилж буй эрүүгийн хуулийг дагаж мөрдсөнөөс эхлэн одоог хүртэл энэ төрлийн гэмт хэрэг шүүхээр хянан шийдвэрлэсэн эсэхэд дүгнэлт хийх боломжгүй байна.

Нөгөөтээгүүр 2015 оны Эрүүгийн хуулийн төсөлд биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийг хуульчлаагүй тул шинээр оруулсан бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн хүндрүүлэх шинжийг ашиг олох зорилгоор хэмээн томъёолж дээрх практикт гарсан тохиолдолтой дүйж оруулсан боловч 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр бие даасан гэмт хэрэгт тооцсоноор хуулийн давхардлыг улам бүр лавшруулжээ.

Ажлын хэсгийн гишүүн “бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг хуульчлах болсон нь практикт үйлдэгдэж буй гэмт явдлаас гадна Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцтой холбоотой” гэжээ. 2000 оны 05 дугаар сарын 25-ны өдөр батлагдсан *Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протоколд*⁵² Монгол Улс 2003 онд нэгдэн орсон. Тус протоколын 2 дугаар зүйлд “хүүхдийг худалдах” гэж аливаа этгээд буюу бүлэг этгээд шан харамж буюу бусад аливаа төлбөр авч хүүхдийг бусад этгээд буюу бүлэг этгээдэд шилжүүлэн өгөх аливаа үйлдэл буюу хэлцлийг хэлнэ хэмээн тодорхойлсон байна. Мөн хүүхэд худалдаалах гэмт хэрэг нь үйлдэл болон зорилго гэсэн 2 элементийг агуулна гээд хүүхэд худалдаалах гэмт үйлдэл нь хүүхдийг мөлжих зорилгоор санал болгох, шилжүүлэх, хүлээн авах үйлдэл байна гэжээ.

Энэхүү олон улсын эрх зүйн эх сурвалжид нэгдэн орсны хувьд манай улс эрүүгийн хуулийн тусгай ангид арван зургаа дугаар бүлэг (хүүхдийн эсрэг гэмт хэргүүд)-ийг шинээр нэмж, ялангуяа мөн хуулийн тусгай ангийн 16.6 дугаар зүйл Хүүхэд худалдах, 16.8 дугаар зүйл Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах гэмт хэрэг мөн хүн худалдаалах гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдсэнийг хүндрүүлэх шинжид хуульчилсан. Иймд Монгол Улс Хүүхдийн эрхийн конвенцод оруулах нэмэлт протоколд нэгдэн орсон хүрээнд бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг заавал хуульчлах шаардлагагүй байна.

Ийнхүү үйл явцыг хамруулсан үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлд, үр дүнг хамруулсан үйлдлийг мөн хуулийн 12.3 дугаар зүйлд тусгасан бол эдгээр гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд оногдуулах эрүүгийн хариуцлагын асуудал хөндөгдөнө. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг болон 13.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг ижил хэмжээний санкцтай. Гэвч доорх хэсэгт заасан зарим хүндрүүлэх шинжийн хорих ялын хугацааг харьцуулбал:

13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах	12.3 дугаар зүйл. Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн хүндрүүлэх шинж
1.Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг., бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	2.Энэ гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор:
2.Энэ гэмт хэргийг: 2.1.хүүхэд, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж; 2.2.хоёр, түүнээс олон хүнийг худалдаалж; 2.3.Монгол Улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3.Энэ гэмт хэргийг: 3.1.байнга тогтвортой; 3.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.	2.1.арван дөрвөөс арван найман насанд хүрээгүй хүнийг албадан оруулж;/Энэ заалтад 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/ 2.2.урьд энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн; 2.3.хохирогчид мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглүүлж; 2.4.хохирогчийг жирэмсэн болгож; 2.5.хоёр, түүнээс олон хүний эсрэг; 2.6.байнга тогтвортой үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3.Энэ гэмт хэргийн улмаас: 3.1.ураг зулбасан; 3.2.арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 4.Энэ гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор: 4.1.бага насны хүүхдийн эсрэг; /Энэ заалтад 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар "хүүхдийг албадан оруулж" гэснийг "хүүхдийн эсрэг" гэж өөрчлөлт оруулсан./; 4.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.

Хүн худалдаалах гэмт хэргийг байнга тогтвортой үйлдсэн бол 12-20 жил хүртэл хугацаагаар, бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэргийг байнга тогтвортой үйлдсэн бол 2-8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр байна. Түүнчлэн хүн худалдаалах гэмт хэргийг хоёр, түүнээс олон хүнийг худалдаалж үйлдсэн бол 5-12 жил, бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэргийг мөн хүндрүүлэх шинжээр үйлдсэн бол 2-8 жил хүртэлх хугацаагаар хорих ял оногдуулахаар байна. Үүнээс үзвэл хүн худалдаалах гэмт хэргийн эцсийн зорилго буюу мөлжлөгт оруулсан, мөлжлөгт оруулах хүртэл үргэлжилсэн үйл явцад хамруулсан үйлдлүүдэд оногдуулах хорих ялын интервал хоорондын зөрүү их байна. Иймд дээрх гэмт хэргүүдийн ялын бодлогыг эргэн харах шаардлага тулгарчээ.

Хүн худалдаалах гэмт хэргийн үйл явц, үр дүнд хамруулсан үйлдлийг салгаж хуульчлах нь нээлттэй боловч тэдгээрийн хүндрүүлэх шинж, ялын интервалыг харилцан уялдаатай тодорхойлох нь зохистой. Ярилцлагын судалгаанд хамрагдсан ажлын хэсгийн гишүүд бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн бүрэлдэхүүн, ялын

бодлогыг тодорхой хэмжээнд өөрчлөх, засаж сайжруулах шаардлагатай гэдгийг онцолж байсныг дурдах нь зүйтэй.

II) Гэмт хэргийн бүрэлдүүн

Гэмт хэргийн бүрэлдүүн гэдэг нь эрүүгийн хуульд хуульчилсан тодорхой үйлийн объектив болон субъектив шижүүдийг тодорхойлсон хэм хэмжээний цогц бөгөөд объектив талд субъект, үйлдэл, үр дагавар гэсэн шинжүүд хамаарах бол субъектив талд гэмт санаа хамаарна.⁵³ Хүн худалдаалах гэмт хэрэг нь үйлдэл, үйлдлийн арга, зорилго гэсэн 3 элементийг агуулдаг бөгөөд эдгээрийг объектив болон субъектив талд хуваан авч үзвэл:

Объектив тал:

Хүн худалдаалах гэмт хэрэг нь бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгтэй харьцуулахад илүү олон үйлдлийн аргатай.

Хүн худалдаалах гэмт хэргийн үйлдлийн арга	Бэлгийн мөлжлөг гэмт хэргийн үйлдлийн арга
• Хүч хэрэглэж; • хүч хэрэглэхээр заналхийлж; • хулгайлж; • хууран мэхэлж; • итгэл эвдэж; • эрх мэдлээ урвуулан ашиглаж; • эмзэг байдлыг нь далимдуулж; • эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан,	• Хүч хэрэглэж; • хүч хэрэглэхээр заналхийлж; • эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулж.

Хүн худалдаалах болон бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн үйлдлийн аргууд:

Хүн худалдаалах гэмт хэрэг	Бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг
"Хүч хэрэглэх" гэж бие махбодын хүчирхийлэл хийхэд чиглэгдсэн аливаа идэвхтэй үйлдлийг ойлгоно.⁵⁴ "Хүч хэрэглэхээр заналхийлэх" гэдэгт бусдыг айлган сүрдүүлэх зорилгоор хийсэн сэтгэл санааны хүчирхийллийг ойлгоно. Энэхүү хүчирхийлэл нь идэвхтэй үйлдлээр илрэх бөгөөд гэмт этгээд үүнийг үгээр илэрхийлэхээс гадна биет байдлаар үзүүлсэн байж болно.⁵⁵ "Хууран мэхэлсэн" гэж үгээр буюу үйлдлээр, бодит байдлыг нуун дарагдуулах, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох замаар бусдыг төөрөгдүүлэхийг хэлнэ. Энэ нь гадаад улсад ажиллах, суралцах, аялах, гэрлэхэд зуучлах зэргээр худал амлах хэлбэрээр илэрнэ.⁵⁶	Эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулах: Уг үйлдлийн арга нь 2008 оны Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хүн худалдаалах гэмт хэргийн хүндрүүлэх шинжид хамаарч байсан бөгөөд 2008 оны Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийг тайлбарлах тухай 12 дугаар тогтоолд "Эрхшээлдээ байгаа" гэдэгт эд хөрөнгийн болон бусад нөхцөл байдлын улмаас тухайн этгээдээс хараат байхыг ойлгоно⁶² хэмээн тайлбарласан байна. Гэвч Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад уг үйлдлийн аргыг хүн худалдаалах гэмт хэргээс хасаж, бэлгийн мөлжлөг гэмт хэргийн үйлдлийн арга байхаар хуульчилсан байна. Харин "эршээлд байгаа хүн" гэдэгт эдийн засаг, албан тушаал, эрүүл мэнд хөгжлийн бэрхшээлтэй байдал гэр бүлийн таагүй орчин зэргээс шалтгаалан гэмт этгээдийн бие махбодын болон сэтгэл санааны албадлагад өртсөн этгээдийг ойлгоно.⁶³

“Хулгайлсан” гэж хүнийг худалдаалах зорилгоор Эрүүгийн хуулийн 13.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдэл хийхийг ойлгоно.⁵⁷ “Итгэл эвдсэн” гэж хоёр талын итгэлцэлд үндэслэх бөгөөд хохирогчид ашигтай нөхцөл бий болгон гэж хуурамч гэрээ бичиг баримт ашиглан итгүүлэх, дараа нь итгэлийг нь хөсөрдүүлснийг ойлгоно.⁵⁸ “Эрх мэдлээ урвуулан ашиглах” гэдэгт хууль тогтоомж буюу эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэрийн дагуу өөрт нь олгогдсон албаны болон бусад бүрэн эрхийг санаатайгаар харш ашигласан явдлыг хамааруулж үзнэ.⁵⁹ “Эмзэг байдлыг нь далимдуулсан” гэдэгт хохирогчийн эдийн засаг, эрүүл мэнд болон хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, түүнчлэн амьдрал ахуйн бусад хүнд байдал зэргийг ашигласан байхыг ойлгоно.⁶⁰ “Хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулсан” гэж хохирогчийг бүх хэлбэрээр хяналтдаа байлгаж буй этгээд өөртөө эдийн болон эдийн засгийн бус ашигтай байдлыг бий болгох болзолтойгоор бусдад хүнийг шилжүүлж буй үйлдлийг ойлгоно. Тухайлбал өөрийн асрамжид байдаг бага насны хүүхдийг бусдаас мөнгө авч, шилжүүлсэн гэх мэт.⁶¹	Эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг нь хязгаарлахгүйгээр субъект эд хөрөнгө, албан тушаалын хувьд өөрөөс нь шууд хамаарал бүхий нөхцөл байдлыг ашиглаж хохирогчийн хүсэл зоригоос гадуур бусадтай бэлгийн харилцаанд оруулсан үйлдэл байна.⁶⁴ Зорчих эрхийг хязгаарлахгүйгээр гэдгийг тайлбарласан албан ёсны болон албан ёсны бус тайлбар алга байна. Зорчих эрхийг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 18 дахь хэсэгт⁶⁵ “улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих...эрхтэй” хэмээн заасан байна. Тухайн үгийг тайлбарласан онолын тайлбарт: “Зорчих” гэдэг нь хүн нэг зүгийг чиглэн зорчих, ийш тийш зорчин явах, “эрхийг хязгаарлах” гэдэг нь эрхийг нь багасгах, хэмжээ тогтоох гэсэн утга илэрхийлж байгаагаас дүгнэвэл хүний чөлөөтэй зорчих хөдөлгөөнийг хязгаарлах гэж үзэж болно,⁶⁶ “Улсын нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих” нь өөрийн орны нутаг дэвсгэрийн аль ч хэсэгт зорилгоос үл хамааран, өөрийн хүсэлтээр очих, явах эрх юм⁶⁷ гэжээ. Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх нь хэд хэдэн эрхийг хамруулдаг өргөн хүрээний ойлголт болно. Уг эрх нь: (1) Эрх чөлөөтэй байх (чөлөөтэй байх халдашгүй эрх ч гэдэг); (2) Бие, махбодын халдашгүй эрх; (3) Орон байрны халдашгүй байдал; (4) Нууцын халдашгүй эрх; (5) Нэр төрийн халдашгүй байдал; (6) Өмчийн халдашгүй байдал гэсэн 6 хүрээг хамарна гэж үзсэн байдаг.⁶⁸ Эрх чөлөөтэй байх эрхийн агуулга нь хүн бүр адил эрх чөлөөтэй байх агуулгаар олон улсын эрх зүйн хэм хэмжээнүүдэд тусгагдсан. Хүн ямар ч үед хувийн болон гэр бүл, ахуй амьдралын хүрээн дэх өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа нь хөндлөнгийн аливаа хяналтаас ангид байна. Хүний эрх чөлөөнд хэн ч дур мэдэн халдаж, хүсэл зоригийг нь алдагдуулж, эрхшээлдээ оруулж болохгүй бөгөөд хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглодог.⁶⁹
--	---

Дээрхээс харвал бэлгийн мөлжлөг гэмт хэргийн шинжид заасан хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх үйлдлийн аргуудыг хүн худалдаалах гэмт хэрэгт мөн заажээ. Харин эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулах үйлдлийн аргыг өмнө нь хүн худалдаалах гэмт хэргийн

хүндрүүлэх шинж байхаар хуульчилж байсныг хасаж бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн үйлдлийн аргад хамруулсан байна. Энэ хоёр гэмт хэргийг ялгах “зорчих эрхийг хязгаарлах” шинжийг олон улсын эрх зүйн хэм хэмжээ, эрдэмтдийн бүтээлд тайлбарлаагүй ойлголт юм.

Хүн худалдаалах болон бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн үйлдэл:

Хүн худалдаалах гэмт хэрэгт хүнийг бэлгийн харьцаанд албадан оруулахаас өмнөх үйлдлүүд болох элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, орогнуулах, хүлээн авах үйлдлүүдийг заасан бол бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгт тодорхой үйлдлийн аргуудыг ашиглан хохирогчийг бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан байна. **Бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан гэж** Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйлд заасан арга хэрэглэж, хохирогчийн хүсэл зоригийн эсрэг бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулах, бэлгийн харилцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийлгэхийг ойлгоно⁷⁰ хэмээн тайлбарласнаас харвал дээрх гэмт хэргүүд нь гэмт үйлдлээрээ ялгаатай байна.

Субъектив тал:

Дээрх 2 гэмт хэрэг нь санаатай гэмт хэрэгт хамаарах бөгөөд хууль тогтоогч зорилгыг мөн хуульчилжээ. Гэмт хэргийн зорилго бол тухайн этгээдийн гэмт хэрэг үйлдэх явцад хүрэхийг эрмэлзсэн үр дүн мөн бөгөөд гэмт хэргийн зорилгыг хуульд үндсэн шинж эсхүл хүндрүүлэх шинж болгон тогтоосон байдаг.⁷¹ Хүн худалдаалах гэмт хэргийн **үндсэн шинжид** “биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж **мөлжих зорилгоор...**”, харин бэлгийн мөлжлөг гэмт хэргийн **хүндрүүлэх шинжид** “**хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор**” хэмээн тус тус хуульчилжээ. Хууль тогтоогч дээрх гэмт хэргүүдэд “мөлжих” болон “ашиг олох” хэмээн төсөөтэй утгатай хоёр өөр үг ашиглан гэмт хэргийн зорилгыг хуульчилсан байна.

Бүлгийн дүгнэлт: Хүн худалдаалах гэмт хэргийг тодорхойлох үйлдэл, үйлдлийн арга, зорилго гэсэн 3 элементийг манай улсын үе үеийн эрүүгийн хуулиудад тусгаж ирсэн ч утга агуулгын хувьд өөр өөрөөр тайлбарлан хэрэглэж иржээ. Жишээлбэл,

1. Үйлдэл: хүн худалдаалах гэмт хэргийн объектив талд хамаарах үйлдлүүдийг **үйл явцыг хамруулсан үйлдэл, үр дүнг хамруулсан үйлдэл** хэмээн ялган үздэг. Үйл явцыг хамруулсан үйлдэл гэдэгт мөлжлөгт оруулах хүртэл үргэлжилсэн үйлдлүүд (элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, орогнуулах, хүлээн авах) хамаарах бөгөөд манай улсын 1996, 2012 оны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудад хүн худалдаалах гэмт хэргийг дээрх үйл явцыг хамруулсан үйлдэл хийснээр гэмт хэргийн бүрэлдэхүүн хангагдах байдлаар хуульчилж иржээ. Харин үр дүнг хамруулсан үйлдэл гэдэгт дээрх үйлдлүүдийн үр дүнд хохирогчийг мөлжлөгт оруулсан байхыг хэлэх бөгөөд манай улсын хувьд 2002 оны Эрүүгийн хууль, 2008 оны Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудад хүн худалдаалах гэмт хэргийн үйлдлийг худалдах, худалдан авах хэлцэл хийгдэж улмаар үүний дүнд гэмт этгээд ашиг олсон байхаар хуульчилж байсан түүхэн уламжлалтай ажээ.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуульд хүнийг мөлжлөгт оруулахаас өмнөх үйл явцыг хамруулсан үйлдлүүд нь хүн худалдаалах гэмт хэрэг байхаар хуульчилсан бөгөөд энэ нь олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцсэн зохицуулалт болжээ. Учир нь протоколыг дагаж мөрдөх удирдамжид энэ төрлийн гэмт хэрэгт заавал мөлжих зорилго хангагдсан байхыг шаардахгүй, мөлжих зорилгоор үргэлжилсэн процесст хамаарах аль нэг үйлдлийг хийснээр гэмт хэрэг төгсөж болно хэмээн тусгасан байдаг.

Өмнө нь дурдсанчлан бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг хуульчлах болсон үзэл баримтлал нь манай улсын практикт гарч буй гэмт явдлаас улбаатай ажээ. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйлд бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгт тусдаа хоёр гэмт үйлдлийг хуульчилсан байна. Өөрөөр хэлбэл, 12.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт бэлгийн мөлжлөг гэхээс илүүтэй **албадан бэлгийн харьцаанд оруулах** үйлдлийг буюу ашиг олох зорилгүйгээр хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх зэрэг аргаар бусадтай бэлгийн харилцаанд оруулах гэмт үйлдлийг эрүүжүүлсэн. Харин уг зүйлийн 2 дахь хэсэгт хүн худалдаалах гэмт хэргийн үр дүнд хамаарах буюу **бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах** гэмт хэргийг хуульчилжээ.

Хүн худалдаалах гэмт хэргийн үйл явцад хамаарах үйлдлүүдийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлд тусгаж, үүний үр дүнд хамаарах **гэмт хэргийн зорилгын хэлбэрүүдийг тусад нь бие даасан гэмт хэрэг байхаар хуульчилсныг** мөн хуулийн тусгай ангийн системчлэлээс харж болно. Тухайлбал, эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйлд Бэлгийн мөлжлөг, 13.13 дугаар зүйл Албадан хөдөлмөрлүүлэх, 15.3 дугаар зүйл Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах гэмт хэргийг төрлийн объектоор ялган тусгажээ.

Протоколд мөлжлөгийн хэлбэрийг бие даасан гэмт хэрэгт хуульчлах боломжийг хязгаарлаагүй. Хүн худалдаалах гэмт хэрэг нь ээдрээ төвөгтэй, нотлоход нарийн төвөгтэй байдаг тул гэмт этгээдэд ял завшуулахаас сэргийлэх үүднээс бие даасан гэмт хэрэгт хуульчлахыг зөвлөдөг. Гэвч аль нэг гэмт үйлдлийг хүнд эсхүл хөнгөн хэмээн тодорхойлох шалгуур болгоогүй юм.

2. Үйлдлийн арга: Эрүүгийн хуулийн түүхэн уламжлалаас үзвэл хүн худалдаалах гэмт хэргийг анх хуульчилсан 1986 оны Эрүүгийн хуульд зөвхөн хууран мэхлэх аргыг хуульчилж байсан ч одоо хүчин төгөлдөр үйлчилж буй эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хүн худалдаалах гэмт хэргийг олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэх үүднээс аль болох өргөн хүрээнд тусгажээ.

3. Зорилго: Хүн худалдаалах гэмт хэрэг нь хүнийг мөлжих зорилгоор үйлдэгддэг. Протоколд мөлжих гэдгийг гэмт этгээд хохирогчид тодорхой аргуудыг хэрэглэн мөлжих гэсэн утгаар илэрхийлсэн бөгөөд уг гэмт хэрэгт хохирогчийг мөлжих зорилго заавал хангагдсан байхыг шаардахгүй. Манай улсын түүхэн уламжлалд мөлжих зорилгыг хүн худалдаалах гэмт хэргийн үйлдэлтэй холбон өөр өөрөөр тайлбарлаж ирсэн гэж үзэж болох юм.

Үйл явцыг хамруулсан үйлдэл нь хүн худалдаалах гэмт хэрэг хэмээн үзэж байсан 1996, 2012 оны Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудад мөлжих

зорилгыг гэмт хэргийн бүрэлдүүний субъектив талд хамруулан "гэмт этгээд ашиг олох гэмт санаатайгаар" үйлдэл хийсэн байх хэмээн тайлбарлаж байжээ.

Үр дүнг хамруулсан үйлдэл нь хүн худалдаалах гэмт хэрэг хэмээн үзэж байсан 2002 оны Эрүүгийн хууль, 2008 оны Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр "ашиг олох зорилгоор" гэж хүн худалдаалах замаар өөртөө болон бусад этгээдэд эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус **ашигтай байдал, орлого бий болсон байхыг хэлнэ** хэмээн тайлбарласан байна.

Дээрх 2 тайлбарын эхний тайлбар буюу гэмт этгээдийн гэмт санаанд тулгуурлан мөлжих зорилгыг тайлбарлах нь одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуульд заасан хүн худалдаалах гэмт хэргийн концепцод нийцнэ.

3

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

3.1 Шүүхээр шийдвэрлэсэн байдал	40
---------------------------------	----

3.2 Эрүүгийн хариуцлага	43
-------------------------	----

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

3.1 ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

Монгол Улсын хэмжээнд 2021-2023 онд нийт 47 хүнд холбогдох бэлгийн мөлжлөг болон хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой 20 хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байна.⁷² Үүнээс 1 хэргийг анхан шатны шүүхээр, 16 хэргийг давж заалдах шатны шүүхээр, 3 хэргийг хяналтын шатны шүүхээр эцэслэн шийдвэрлэжээ. Нийт хэргээс 2021 онд 9 хэрэг, 2022 онд 9 хэрэг, 2023 онд 2 хэрэг шийдвэрлэгдсэн байна.

а. Анхан шатны шүүх:

Нийслэлийн прокурорын газар нийт 20 хэргээс 18 хэргийг хүн худалдаалах гэмт хэрэгт, 2 хэргийг бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгт холбогдуулж яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлжээ. Үүнээс хүн худалдаалах гэмт хэргийн 6 хэрэг нь зүйлчлэл хэвээр, 11 хэрэг нь бэлгийн мөлжлөгөөр, 1 хэрэг нь биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргээр зүйлчлэл өөрчлөгдөн эцэслэн шийдвэрлэгдсэн байна. Тодруулбал, хүн худалдаалах гэмт хэргээр яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн 18 хэргийн 6 хэрэг буюу 33 хувь нь зүйлчлэл хэвээр байгаа бол 12 хэрэг буюу 67 хувь нь бэлгийн мөлжлөг, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргээр зүйлчлэл өөрчлөгдөж шийдвэрлэгджээ. Харин бэлгийн мөлжлөгийн 2 хэрэг зүйлчлэл өөрчлөгдөлгүйгээр эцэслэн шийдвэрлэгдсэн байна. Дээрхээс үзэхэд сүүлийн гурван жилийн хугацаанд 6 хүн худалдаалах гэмт хэрэг, 13 бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг, 1 биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэжээ.

График №1: Шүүхээр шийдвэрлэсэн байдал



Хүн худалдаалах гэмт хэргийн талаас илүү хувь нь шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэхдээ зүйлчлэл өөрчлөгдсөн байна. Прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлд зааснаар яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн 18

хэргээс 8 хэрэг буюу 44.4 хувь нь **анхан шатны журмаар шийдвэрлэхэд** зүйлчлэл хэвээр, 9 хэрэг буюу 50 хувь нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйлд зааснаар, 1 хэрэг буюу 5.6 хувь нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.6 дугаар зүйлд зааснаар зүйлчлэл өөрчлөгджээ. Үүнээс үзэхэд хүн худалдаалах гэмт хэрэгт холбогдуулж яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлсэн нийт хэргийн **55.6 буюу тал хувь нь анхан шатны журмаар шийдвэрлэхэд зүйлчлэл өөрчлөгдсөн** байна.

б. Давж заалдах шатны шүүх:

Нийт судалсан хэргээс 19 хэрэг буюу 95 хувьд нь давж заалдах журмаар гомдол, эсэргүүцэл гаргаснаас прокурорын эсэргүүцэл 5; шүүгдэгч, түүний өмгөөлөгчийн гомдол 17; хохирогч, түүний өмгөөлөгчийн гомдол 5-ыг тус тус эзэлж байна. Давж заалдах шатны шүүхийн 25 магадлалд шийтгэх тогтоолыг хэвээр үлдээсэн 12, дахин хэлэлцүүлэхээр буцааж шийдвэрлэсэн 7, өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн 6 магадлал тус тус байна.

Хүснэгт №1: Давж заалдах шатны Шүүхийн шийдвэрлэсэн байдал

№	Давж заалдах шатны шүүхийн шийдвэр	Тоо	Эзлэх хувь
1.	Гомдол, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн	12	48%
2.	Анхан шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон	-	-
3.	Хэргийн зүйлчлэл, ялыг хүндрүүлэхгүйгээр анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан	6	24%
4.	Дахин хэлэлцүүлэхээр шүүхэд буцаасан	7	28%

Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн нь дийлэнх хувийг эзэлж байгаа бол хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн тохиолдол байхгүй байна. Шийдвэрлэсэн байдлыг үзвэл:

- “Таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилсөн 1; хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээ авсан нэмэлт заалт оруулсан 1; Өршөөл үзүүлэх тухай хуулийг буруу хэрэглэсэн 1; гэмт хэрэгт хамтран оролцсон хэлбэрийг тодорхойлсон 1; хохирол нөхөн төлсөн, эрүүл мэнд болон хувийн байдлыг харгалзан үзэж хорих ялаас нэг жилийн хугацаа хассан 2” үндэслэлээр **хэргийн зүйлчлэл, ялыг хүндрүүлэхгүйгээр 6 шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан;**
- “Урьд шийтгүүлсэн ялыг нэмж нэгтгэх эсэх талаар дүгнэлт хийгээгүй 1; **анхан шатны шүүх хэргийг дахин хэлэлцэхдээ зүйлчлэлийг үндэслэлгүйгээр хөнгөрүүлсэн 1⁷³;** хууль бус бүрэлдэхүүнээр тогтоол гаргасан 1; шүүгдэгчийн хувийн байдлыг тодруулахад шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжтой тул прокурорт буцаасан тогтоолыг хүчингүй болгосон 2; бусад гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулах шаардлагагүй буюу прокурорт буцаасан

тогтоолыг хүчингүй болгосон 1; хорих ялыг буруу нэмж нэгтгэсэн буюу ялын дээд хэмжээнээс хэтэрсэн 1" үндэслэлээр дахин хэлэлцүүлэхээр 7 шийдвэрийг анхан шатны шүүхэд буцаасан;

- "Анхан шатны шүүхийн шийдвэр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчөөгүй, эрүүгийн хуулийг зөв тайлбарлан хэрэглэсэн, шүүхийн тогтоолд заасан үндэслэл нь хэргийн бодит байдалд нийцсэн үндэслэлээр 12" гомдол, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийн зүйчлэлийг хөнгөрүүлэн өөрчилсөн тохиолдол байхгүй байна. Тухайлбал яллах дүгнэлтийн зүйл, хэсэг өөрчлөгдөлгүй хүн худалдаалах гэмт хэргээр шийдвэрлэсэн 6 хэргийг 1 хэргийг анхан шатны шүүхээр, 5 хэргийг давж заалдах шатны шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн. Анхан шатны шүүх хүн худалдаалах гэмт хэрэг, эсхүл бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож шийдвэрлэсэн бол давж заалдах шатны шүүх зүйлчлэлд өөрчлөлт оруулаагүй байна.

в. Хяналтын шатны шүүх:

Давж заалдах журмаар шийдвэрлэсэн 19 хэргээс 3 хэрэг буюу 15.8 хувьд хяналтын журмаар гомдол, эсэргүүцэл гаргасан бол 16 хэрэг буюу 84.2 хувьд нь гомдол, эсэргүүцэл гаргаагүй байна. Үүнийг нийт 20 хэрэгтэй харьцуулбал 3 хэрэг буюу нийт хэргийн 15 хувийг хяналтын журмаар шийдвэрлэжээ. Хяналтын журмаар прокурорын эсэргүүцэл 2; шүүгдэгч, түүний өмгөөлөгчөөс 2 гомдол гаргасан байна.

Улсын дээд шүүх Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлээр 2 хэрэг, мөн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйлээр шийдвэрлэсэн 1 хэргийг хяналтын журмаар хянан хэлэлцсэнээс бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг шийдвэрлэсэн шийтгэх, тогтоол магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэжээ. Хүн худалдаалах гэмт хэргээр шийдвэрлэсэн 2 шийтгэх тогтоол, магадлалд зүйчлэлийг хөнгөрүүлэн өөрчилж, бэлгийн мөлжлөг гэмт хэрэгт гэм буруутай хэмээн шийдвэрлэсэн байна.

г. Шүүхийн шийдвэрийн үндэслэл

Эрүүгийн хэргийн шүүхээс Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан бэлгийн мөлжлөг болон хүн худалдаалах гэмт хэргээр зүйлчлэн шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийж үзэхэд шүүхээс тогтоосон хэргийн үйл баримт нь нийтлэг "хохилогчийн санхүүгийн боломж муу, гэр бүлийн харилцаа тогтворгүй буюу гэр бүлийн гишүүдтэй таарамжгүй харилцаатай, асран хамгаалах, харгалзан дэмжих хүнгүй зэрэг эмзэг байдлыг нь далимдуулан "их мөнгө олох хялбар ажил" санал болгох нэрийдлээр хохирогчийн зөвшөөрлийг авч элсүүлэн бусдад биеийг нь үнэлүүлэх" хэлбэрээр үйлдэгддэг байна. Энэ байдал нь даамжран хохирогчид хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлж хохирогчийн байгаа газрыг хянах, нийтийн байр, өөрийн гэрт хамтран амьдруулах улмаар бусдад биеийг нь үнэлүүлж авсан хариу төлбөрийн дийлэнхийг, эсхүл бүгдийг нь гэмт этгээд өөртөө авах зэргээр бэлгийн мөлжлөгийн шинжтэй үйлдэлд шилжсэн байна.

Хүн худалдаалах гэмт хэргээр эцэслэн шийдвэрлэсэн эсхүл зүйлчлэл өөрчилж бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээр шийдвэрлэсэн эсэхээс үл хамааран шүүхийн шийдвэрийн үндэслэл төстэй байна. Тухайлбал "хүн худалдаалах гэмт хэргийн үндсэн шинж нь хохирогч нарыг худалдаалах зорилгоор айлган сүрдүүлэх, тулган шаардах, ятгах замаар гэмт ажиллагааны оролцогч болгохоор элсүүлсэн, **оршин суугаа газраас нь өөр газарт зөөвөрлөн чөлөөтэй зорчих эрхийг нь хязгаарлаж** тээвэрлэсэн, өөр хүний эрхшээлд оруулж дамжуулсан эсхүл өөр хүний эрхшээлд оруулах хүртэл тодорхой орон байранд нууцаар орогнуулсан, бусдын эрхшээлд байсан хүнийг мөлжих зорилгоор хүлээн авсан байна. Хохирогчийн **эрх, эрх чөлөө гэм буруутай этгээдээс бүрэн хамааралтай**, мөн хохирогчийн биеийг үнэлүүлсэн болон бусад хэлбэрээр хүчирхийлэлд оруулсны орлого бүхэлдээ, эсхүл дийлэнх хэсэг нь гэмт хэрэгтний ашиг, орлого болдог төдийгүй уг хэрэг нь **ихэвчлэн зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй** үйлдэгддэгээрээ бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээс ялгагдана" гэж тайлбарлан хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч хохирогчийн зорчих эрхийг хязгаарласан нөхцөл байдал тогтоогдоогүй тул Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг баримтлан шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэж бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээр хөнгөрүүлэн зүйчилжээ.

Дээрхээс үзэхэд шүүхүүд хүн худалдаалах гэмт хэргийг УДШ-ийн 2008 оны тайлбар буюу хүн худалдаалах гэмт хэргийг үр дүнг хамруулсан үйлдэл байхаар тодорхойлсон ойлголтоор хэрэглэж байна. Мөн хүн худалдаалах гэмт хэрэгт хохирогчийг бүрэн эрхшээлдээ оруулж зорчих эрхийг нь хязгаарласан, зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй байна гэж тодорхойлжээ.

Манай улсад дийлэнх хүн худалдаалах болон бэлгийн мөлжлөгийн гэмт хэргүүдийн үйлдэгдэх арга, үйлдэл ойролцоо байх бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотолсон хэмжээ хязгаарын хүрээнд хохирогчийн зорчих эрхийг хязгаарласан эсэхийг тогтоосон эсэхээс хамааран аль гэмт хэргээр эцэслэн шийдвэрлэгдэх нь хамаарч байна.

3.2 ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА

Хүснэгт №2: Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээдүүдийн зүйл, хэсэг

Бэлгийн мөлжлөг	Тоо	Хүн худалдаалах	Тоо
12.3-1	-	13.1-1	-
12.3-2.1	30	13.1-2.1	10
12.3-2.2	3	13.1-2.2	7
12.3-2.3	-	13.1-2.3	2
12.3-2.4	-	13.1-3.1	2
12.3-2.5	25	13.1-3.2	-
12.3-2.6	16	-	-

Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг зөвхөн ашиг олох зорилгоор үйлдэж байгаа бөгөөд арван дөрвөөс арван найман насанд хүрээгүй хүнийг албадан оруулж; урьд энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн; хоёр, түүнээс олон хүний эсрэг; байнга тогтвортой үйлдсэн зэрэг хүндрүүлэх шинжүүд тогтоогджээ. Энэ нь манай улсад бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг ашиг олох зорилгоор **хоёр түүнээс дээш; 14-18 насанд хүрээгүй хүний эсрэг; байнга тогтвортой** үйлдэх тохиолдол их байгааг харуулж байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн хувьд хүүхэд, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж; хоёр, түүнээс олон хүнийг худалдаалж; Монгол Улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн; байнга тогтвортой үйлдсэн зэрэг хүндрүүлэх шинжүүд тогтоогджээ. Энэ нь хүн худалдаалах гэмт хэргийг **хүүхэд, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж; хоёр түүнээс олон хүнийг; байнга тогтвортой** худалдаалж үйлдэх тохиолдол их байгааг илтгэж байна.

Хүн худалдаалах гэмт хэргээр эрүүгийн хариуцлага хүлээсэн 12 хүний хорих ялын хугацааг авч үзэхэд 4 хүнд 4-5 жил хүртэлх хугацаагаар, 5 хүнд 6-7 жил хүртэлх хугацаагаар, 1 хүнд 18 жилийн хугацаатай хорих ял оногдуулж шийдвэрлэсэн байна. Үүнээс 7 хүнийг нээлттэй хорих байгууллагад, 5 хүнийг хаалттай хорих байгууллагад ял эдлүүлэхээр шийдвэрлэжээ.

Хүснэгт №3: Хүн худалдаалах гэмт хэрэгт хорих ял шийтгүүлсэн этгээдүүдийн хугацаа

№	Хорих ялын хугацаа	Хүн	Хувь
1.	4-5 жил	4	33.3%
2.	6-7 жил	5	41.7%
3.	12 жил	2	16.7%
4.	18 жил	1	8.3%

Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээр эрүүгийн хариуцлага хүлээсэн 31 хүний хорих ялын хугацааг авч үзэхэд 18 хүнд 2-3 жил хүртэлх хугацаагаар, 9 хүнд 4-5 жил хүртэлх хугацаагаар, 4 хүнд 6-7 жил хүртэлх хугацаатай хорих ял оногдуулж шийдвэрлэсэн байна. Үүнээс 20 хүнийг нээлттэй хорих байгууллагад, 11 хүнийг хаалттай хорих байгууллагад ял эдлүүлэхээр шийдвэрлэжээ.

Хүснэгт №4: Бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгт хорих ял шийтгүүлсэн этгээдүүдийн хугацаа

№	Хорих ялын хугацаа	Хүн	Хувь
1.	2-3 жил	18	58%
2.	4-5 жил	9	29%
3.	6-7 жил	4	13%

Биеэ үнэлэхийг зохион байгуулах эрүүгийн хариуцлага хүлээсэн 4 хүний хорих ялын хугацааг авч үзэхэд 2 хүнд 2 жилийн хугацаанд нээлттэй хорих байгууллагад ял эдлүүлэхээр шийдвэрлэсэн бол 2 хүнийг 3 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж шийдвэрлэжээ.

Хүснэгт №5: Биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэгт хорих ял шийтгүүлсэн этгээдүүдийн хугацаа

№	Хорих ялын хугацаа	Хүн	Хувь
1.	2 жил	2	50%
2.	3 жил	2	50%

Бүлгийн дүгнэлт: Сүүлийн гурван жилийн хугацаанд шүүхээр 6 хүн худалдаалах гэмт хэрэг, 13 бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг, 1 биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийг шийдвэрлэжээ. Прокурорын газраас нийт 20 хэргийн 18 хэргийг хүн худалдаалах гэмт хэргээр, 2 хэргийг бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээр яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлснийг анхан шатны журмаар шийдвэрлэхэд тал хувь нь зүйлчлэл өөрчлөгдөн бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээр шийдвэрлэгджээ. Ийнхүү зүйлчлэл өөрчлөхдөө дийлэнх тохиолдолд “зорчих эрхийг хязгаарласан” эсэх шинжийг гол үндэслэлээ болгож байна. Давж заалдах, хяналтын шатны шүүх ч мөн дээрх байдлаар дүгнэж анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх, эсхүл хүн худалдаалах гэмт хэргийг бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээр эцэслэн шийдвэрлэжээ.

Гэвч хүн худалдаалах гэмт хэргийг үндэстэн дамнасан шинжтэй гэж үзэх нь нэг талаасаа дутагдалтай. Тухайлбал манай улсад энэ төрлийн гэмт хэргийг хуульчлахдаа үндэстэн дамнасан болон дотоодын хүн худалдаалах гэмт хэрэг гэж ялгаагүй, олон улсын эрх зүйн хэм хэмжээнд ч мөн нэгдэн орсон улс орнуудыг ялгаж хуульчлах зөвлөмж гаргаагүй байдаг.

Практикт бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг болон хүн худалдаалах гэмт хэргийг үйлдэхдээ хоёр түүнээс дээш хүнийг, байнга тогтвортой үйлдсэн гэх хүндрүүлэх шинж адилхан тогтоогдож байгаа атлаа бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн хорих ялын хугацааг хүн худалдаалах гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээдүүдийн хугацаатай харьцуулан үзвэл харьцангуй бага байна. Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээр ял шийтгүүлсэн 18 хүн буюу (58%) нь 2-3 жилийн хугацаатай хорих ялаар шийтгүүлсэн бол хүн худалдаалах гэмт хэрэгт ял шийтгүүлсэн 5 хүн буюу дийлэнх (41.7%) нь 4-5 жилийн хугацаатай хорих ял шийтгүүлжээ.



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.

ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

4.1 Америкийн Нэгдсэн Улс	48
4.2 Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	51
4.3 Тайвань Улс	61
4.4 Бүгд Найрамдах Солонгос Улс	64
4.5 Канад Улс	66

ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

4.1 АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

Америкийн Нэгдсэн Улс /цаашид "АНУ" гэх/-д хүн худалдаалах гэмт хэрэг нь Холбооны Эрүүгийн кодод⁷⁴ заасан гэмт хэрэг бөгөөд уг гэмт явдлын эсрэг тэмцэх, хохирогчийн эрхийг хамгаалах чиглэлээр тусгайлан зохицуулсан [Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хууль](#) (2000)⁷⁵ үйлчилдэг. Энэ хуульд анх хүн худалдаалах гэмт хэргийг бэлгийн болон боолчлолын зорилгоор хүн худалдаалах хэмээн хоёр төрөлд тодорхойлсон.⁷⁶

Хүн худалдаалах гэмт хэргийн ноцтой хэлбэрүүд:

(А) Бэлгийн зорилгоор худалдаалах буюу хүнийг хүч хэрэглэж, хуурч, заналхийлж арилжааны шинжтэй бэлгийн үйлдэл хийлгэсэн, эсхүл 18 насанд хүрээгүй хүнээр тийм үйлдэл хийлгэсэн;

(Б) Хүсэл зоригийнх нь эсрэг сервитутаг оруулах, зарцлах, өрөнд оруулж боолчлох, боолчлох зорилгоор хүч хэрэглэж, хуурч, заналхийлж хүнийг элсүүлсэн, орогнуулсан, тээвэрлэсэн, хангасан, эсхүл олж авсан.

Уг хууль батлагдсан үеэс хойш хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг эрх зүйн орчинд хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт хийсэн бөгөөд 2015 онд гэмт хэргийн объектив талын шинжид зарим үйлдлийн хэлбэрүүдийг нэмжээ. АНУ-ын Холбооны Эрүүгийн кодын 1591 дүгээр зүйлд ["Бэлгийн зорилгоор хүүхэд худалдаалах; болон хүч хэрэглэж, хуурч, заналхийлж хүн худалдаалах"](#) гэмт хэргийн шинжийг дараах агуулгаар хуульчилсан байна:

Субъектив тал: Энэ гэмт хэрэг нь ["Мэдсээр байж хохирогчийг арилжааны шинжтэй бэлгийн үйлдэл хийлгэх зорилгоор"](#) үйлдэгдэнэ. *Commercial sexual act* буюу арилжааны шинжтэй бэлгийн үйлдэл гэдэгт хариу төлбөртэйгөөр бэлгийн харьцаанд оруулах, бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийлгэх болон бусад үйлдлүүд багтах бөгөөд үүний хариуд гэмт этгээд мөнгө, бараа, дэмжлэг болон бусад ямар ч хэлбэрийн хариу төлбөр, ашиг олсон байж болно.⁷⁷

Объектив тал:

(а) АНУ-ын мужийн нутаг дэвсгэрт, муж хооронд, эсхүл хил дамнуулан хүнийг ["хүч хэрэглэх, хуурах, заналхийлэх"](#) аргаар хохирогчийг ["элсүүлсэн, татан оруулсан, орогнуулсан, тээвэрлэсэн, хангасан, олж авсан, сурталчилсан, ивээлд оруулсан, эсхүл санал тавьсан"](#).

(б) Дээрх гэмт хэргийг үйлдсэн [гэмт бүлэглэлийн үйл ажиллагаанд оролцож санхүүгийн болон бусад хэлбэрийн ашиг хүртсэн](#) бол гэмт хэргийн объектив талын шинж хангагдана.

Заналхийлэх гэдэг нь 1) хохирогчид болон бусдад ноцтой хохирол⁷⁸ учруулах, зорчих эрх чөлөөг нь хязгаарлахаар /англ.*physical restraint*/ айлган сүрдүүлэх; 2) тухайн үйлдлийг хийгээгүй тохиолдолд хохирогчид болон бусдад ноцтой хохирол учруулах, эсхүл зорчих эрх чөлөөг нь хязгаарлахад хүргэнэ хэмээн итгүүлэхүйц хуйвалдаан, төлөвлөгөө буюу схем загвар ашиглах; 3) хуулийн зохицуулалтыг урвуулан ашиглаж заналхийлэх зэрэг үйлдлүүдийг хамааруулахаар тайлбарлажээ. Эндээс харахад хохирогчийн хүсэл зоригийн эсрэг бэлгийн мөлжлөгт оруулахад хохирогчийн зорчих эрхийг хязгаарлах хэлбэрээр үйлдэгдэх боломжтой. Гэхдээ энэ нь уг гэмт хэргийг үйлдэгдэх зөвхөн нэг төрлийн арга юм.

Протоколын тодорхойлолттой харьцуулахад хохирогчийн хүсэл зоригийн эсрэг бусадтай хариу төлбөртэйгөөр бэлгийн харьцаанд оруулах буюу зөвхөн биеийг нь үнэлүүлэн мөлжих зорилгоор үйлдсэнийг уг гэмт хэрэгт хамааруулжээ. Харин объектив талын үйлдлийн шинжид харьцангуй өргөн хүрээнд хуульчилсан байна. Татан оруулах, хангах, олж авах, сурталчлах, санал тавих зэрэг үйлдлүүд нь олон улсын гэрээнд тусгаснаас өргөн хүрээг хамрах бөгөөд хүчээр хүний биеийг үнэлүүлсэн нөхцөлд хүн худалдаалах гэмт хэрэгт тооцохоор байна.

Шүүхийн практикт эдгээр шинжүүдийг үгийн ерөнхий утгыг баримталж өргөн агуулгаар тайлбарлан хэрэглэдэг.

Кейс №1: *United States v. Jungers*, 702 F.3d 1066 (8th Cir. 2013)

Үйл баримт: 2011 оны 02 дугаар сард АНУ-ын Өмнөд Дакота мужийн мөрдөн шалгах байгууллагын албан хаагчид хүүхдийн биеийг үнэлж бэлгийн харьцаанд ордог хүмүүсийг барих зорилгоор нууц мөрдөн шалгах ажиллагаа явуулж насанд хүрээгүй охидын биеийг үнэлүүлэх гэж буй мэтээр цахим орчинд зар байршуулжээ. Шүүгдэгч Jungers болон Bonestroo нар зарын дагуу холбогдож охидын нас, үнэлгээ, зургуудыг (мөрдөн шалгах байгууллагын ажилчид хуурамчаар хийсэн) үзэж тус тус 11 настай, 14 настай охидыг сонгосон. Мөрдөн шалгах байгууллагын ажилчид шүүгдэгч нарыг нууц мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар бэлтгэсэн байшинд дуудаж тэднийг ирмэгц баривчилсан байна.

Яллагдагч талаас шүүх хуралдаанд ямар нэгэн нотлох баримт шинжлэн судлуулаагүй бөгөөд “хүн худалдаалах гэмт хэргийг үйлдээгүй, зөвхөн хэрэглэгч буюу арилжааны шинжтэй бэлгийн үйлдлийг худалдан авах” зорилготой байсан хэмээн маргажээ. Тангарагтны шүүгчид шүүгдэгч нарыг хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэхээр завдсан гэм буруутай талаар дүгнэлт гаргасан.

Анхан шатны шүүх шүүгдэгч тус бүрд холбогдох хэргийг “Эрүүгийн кодын 1591 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг нь хүн худалдаалагч нарыг ял шийтгэх зорилготой бөгөөд арилжааны шинжтэй бэлгийн үйлдлийг худалдан авагч нарт хамаарахгүй” хэмээн тайлбарлаж цагаатгаж шийдвэрлэжээ.

Шүүхийн шийдвэрийн үндэслэл: Давж заалдах шатны шүүх “Эрүүгийн кодын 1591 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг нь хүүхэд худалдаалах гэмт хэрэгт хамаарах өргөн хүрээний үйлдлүүдийг эрүүжүүлсэн... Уг гэмт хэргийн шинжид хамаарах үйлдлүүдийг хууль тогтоогч хуульд тусгайлан тайлбарлаагүй. Энэ тохиолдолд хуульд заасан үгийн ерөнхий утгаар өргөн хүрээнд тайлбарлан хэрэглэх бөгөөд шүүгдэгч нарын маргаж буй “олж авах” үйлдэл нь үгийн ерөнхий утгаас арилжааны шинжтэй бэлгийн үйлдлийг нийлүүлэх, худалдан авах аль аль тохиолдлыг хамруулна” хэмээн шийдвэрийнхээ үндэслэлийг тайлбарлажээ.

Шүүхийн шийдвэр: Шүүгдэгч нарыг цагаатгасан анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон.

Дээрх шүүхийн жишгээс харахад биеийг нь үнэлүүлэх зорилгоор хүн худалдаалахад хүчээр биеийг нь үнэлүүлсэн этгээдээс гадна ялангуяа насанд хүрээгүй хүүхдийг мэдсээр байж төлбөр төлж авсан хүнийг хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн гэж үзэж байна. 18 насанд хүрээгүй хүний эсрэг уг гэмт хэргийг үйлдэхэд дээрх аргуудыг хэрэглэсэн байхыг шаардахгүй.

Жишээлбэл,⁷⁹ гэмт этгээд гэр оронгүй хүмүүс цуглардаг гудамж дахь хоол хүнс, орон байр шаардлагатай өсвөр насны охидыг бай болгон “ажилд оруулж туслах” нэрийдлээр биеэ үнэлэх санал тавьжээ. Гэмт этгээд охидын эсрэг ямар нэгэн хүч хэрэглээгүй бөгөөд хүссэн үедээ татгалзах, орхиж явах боломжтой байсан. Гэсэн хэдий ч түүний үйлдэл нь насанд хүрээгүй хүнийг бэлгийн арилжаанд “татан оруулсан”⁸⁰ тул хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ.

АНУ-д биеэ үнэлэлтийг гэмт хэрэгт тооцдоггүй. Хохирогчийг хүчээр биеийг нь үнэлүүлсэн буюу хариу төлбөртэйгөөр бусадтай бэлгийн харьцаанд оруулсан, насанд хүрээгүй хүний биеийг үнэлүүлсэн тохиолдолд хүн худалдаалах гэмт хэрэгт ял шийтгэдэг. Манай улсын эрх зүйн зохицуулалтаас ялгаатай нь бэлгийн мөлжлөг буюу хүчээр биеийг нь үнэлүүлэх ойлголтуудыг нэгтгэж үздэг бөгөөд энэ нь хүн худалдаалах гэмт хэргийн шинж болно.

Оногдуулах ял шийтгэл: Хэрэв дээр дурдсан аргуудыг хэрэглэж, эсхүл 14 насанд хүрээгүй хүүхдийн эсрэг уг гэмт хэргийг үйлдсэн бол торгох, эсхүл 15 жилээс бүх насаар хорих ял шийтгэнэ. Харин хохирогч 14 насанд хүрсэн боловч 18 насанд хүрээгүй, тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын хэр хэмжээ харьцангуй бага бол 10 жилээс бүх насаар хорих ял шийтгэнэ.

Түүнчлэн гэмт этгээдээр гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан хохирол, хор уршгийг бүрэн нөхөн төлүүлнэ. Хохирол, хор уршгийг нөхөн төлөх хэмжээг тогтооход дараах зардлууд дээр гэмт этгээд хохирогчийг мөлжлөгт оруулсны үр дүнд олсон ашгийг нэмсэн дүнгээр тооцно.

- Бие махбодын болон сэтгэцийн эмчилгээ, сэтгэл зүйн үйлчилгээ авахтай холбоотой зардал;
- Физик болон хөдөлмөр засал, нөхөн сэргээх эмчилгээ
- Тээвэр, орон байр, хүүхэд асран хамгаалахтай холбоотой зардал;
- Алдсан орлого;
- Хууль зүйн туслалцаа авахад шаардагдах хөлс;
- Хохирогчид учирсан бусад зардал зэрэг орно.⁸¹

Хүн худалдаалах, ялангуяа бэлгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэрэг нь интернэт орчинд үйлдэгдэж болно.⁸² 2017 онд АНУ-ын конгрессоос цахим цахим хуудас ашиглан хүн худалдаалах явдлыг зогсоох зорилгоор “Мужууд болон хохирогч нарыг бэлгийн зорилготой цахим хүн худалдаалахтай тэмцэхийг зөвшөөрөх”⁸³ болон “Бэлгийн зорилгоор хүн худалдаалагчдад боломж гаргахыг таслан зогсоох”⁸⁴ хуулиудыг баталжээ.

Эдгээр хуулиудыг дагаж Холбооны Эрүүгийн кодын 2421А зүйлд “муж хооронд, эсхүл муж хоорондын худалдааны арга хэрэгсэл ашиглаж АНУ-ын мужид, муж хооронд, эсхүл хил дамнуулан биеэ үнэлэлтийг сурталчлах, хялбарчлах зорилгоор интерактив компьютерын үйлчилгээг⁸⁵ эзэмшсэн, удирдсан, ажиллуулсан; эдгээрт бэлтгэсэн, завдсан” бол гэмт хэрэгт тооцсон. Тав болон түүнээс дээш хүний биеийг үнэлүүлэхэд сурталчилсан, хялбарчилсан; эсхүл тухайн үйлдэл нь бэлгийн шинжтэй хүн худалдаалах гэмт хэрэгт хөтөлж болохыг мэдсээр байж хайхрамжгүй хандаж гэмт хэрэг үйлдсэн бол хүндрүүлэх бүрэлдэхүүнд тооцно. Ердийн бүрэлдэхүүнд торгох ял болон 10 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ. Хүндрүүлэх бүрэлдэхүүнд торгох ял болон 25 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Мөн Холбооны Эрүүгийн хуулийн 2251, 2252 дугаар зүйлүүдэд “Хүүхдийг бэлгийн мөлжлөгт оруулах” /англ. *Sexual exploitation of children*/ гэмт хэргийг хуульчилжээ. Уг гэмт хэрэгт муж хооронд болон АНУ-ын хил давуулан 18 насанд хүрээгүй хүүхдийг илтэд бэлгийн шинжтэй үйлдэл хийлгэж хүүхдийн порнограф⁸⁶ бэлдэх, тараах, авах, хадгалах, мөн үүний тулд хүүхдийг хөлслөх, ятгах зэргээр хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах үйлдлүүдийг багтаажээ. Илтэд бэлгийн шинжтэй үйлдэлд заавал хүүхдийг бэлгийн харьцаанд оруулах, бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийлгэхээс гадна хүүхдийн нүцгэн зургийг авах зэргээр илтэд сэдэл төрүүлсэн ямар ч дүрслэл байж болно.

Хэрэв Эрүүгийн кодын 2251 дүгээр зүйлд заасан хүүхдийг порнограф бэлдэх зорилгоор хөлслөх, ятгах гэмт хэргийг анх удаа үйлдсэн этгээдэд торгох болон 10-аас 20 жил хүртэлх хугацаагаар хорих ял, өмнө төсөөтэй гэмт хэргүүдэд ял шийтгүүлж байсан бол торгох болон 15-аас 30 жил хүртэлх хугацаагаар хорих ял, өмнө 2 болон түүнээс дээш удаа төсөөтэй гэмт хэрэг үйлдэж байсан бол 30 жилээс бүх насаар хорих ял оногдуулна.

Харин хүүхдийн порнографыг тээвэрлэсэн, хүлээн авсан, тараах гэмт хэргийг анх удаа үйлдсэн бол торгох болон 10 жил хүртэлх хугацаагаар хорих ял, хэрэв 12 насанд хүрээгүй хүүхдийн эсрэг уг гэмт хэргийг үйлдсэн бол торгох болон 12 жил хүртэлх хугацаагаар хорих ял, төсөөтэй төрлийн гэмт хэргүүдэд өмнө ял шийтгүүлж байсан бол торгох болон 10-аас 20 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.2 ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС

Герман Улс нь хүн худалдаалах гэмт хэргийг үр дүнг хамруулсан үйлдэл байхаар хуульчилж ирсэн түүхэн уламжлалтай боловч 2016 оноос эхлэн үйл явцад хамруулсан үйлдлийг хүн худалдаалах гэмт хэрэг хэмээн үзсэн байна. Иймд судалгааны багийн зүгээс тус улсын Эрүүгийн хуулийн зохицуулалтыг судлахдаа Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс өмнөх зохицуулалт (I) болон Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлт буюу одоо хүчин төгөлдөр үйлчилж буй зохицуулалт гэсэн хэсгүүдэд хуваан авч үзэв.

I. Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс өмнөх зохицуулалт

2002 оны 07 дугаар сарын 09-ний өдөр Европын Зөвлөлөөс хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай шийдвэр⁸⁷-ийг баталсан ба уг шийдвэрт *Палермогийн протоколын 3а дахь хэсэгт заасан хүн худалдаалах гэмт хэргийн тодорхойлолтод тулгуурлан хүн худалдаалах гэмт хэрэг нь үйлдэл, үйлдлийн арга, зорилго гэсэн 3 элементтэй байхаар тодорхойлжээ*.⁸⁸ Өөрөөр хэлбэл, хүн худалдаалах гэмт хэргийг протоколд тусгасан ухагдахуунтай ижил байдлаар ойлгоно. Палермогийн протокол болон Европын Зөвлөлийн 2002 оны шийдвэрт *хүн худалдаалах гэмт хэргийг хүнийг худалдаалж ашиг олохын өмнөх үе шат* буюу хүн худалдаалж ашиг олохын өмнөх үйлдлүүд болох элсүүлэх, тээвэрлэх зэрэг үйлдлийг хамруулах ёстой хэмээн тусгасан байдаг.

Герман Улс нь Европын Холбоо /цаашид "ЕХ" гэх/-ны гишүүн орны хувьд хүн худалдаалах гэмт хэргийн ойлголт, шинжийг ЕХ-ноос гаргасан эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн томъёолох үүрэгтэй боловч 2016 оныг хүртэл дээрх олон улсын эрх зүйн хэм хэмжээнд тусгаснаас өөр агуулгаар томъёолж иржээ. Тодруулбал, хүн худалдаалах гэмт хэргийн объектив талд үйл явцыг хамруулсан үйлдэл бус, үр дүнг хамруулан ашиг олсон байхаар хуульчилж байсныг доорх зохицуулалтаас харж болох юм.

Эрүүгийн хуулийн 232 дугаар зүйл. Бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах⁸⁹

1. Бусад хүнийг гарцаагүй байдал, гадаад улсад байгаа улмаас тусламж авах боломжгүй байгааг далимдуулан биеэ үнэлэхэд татан оролцуулах, цаашид биеэ үнэлүүлэхийг үргэлжлүүлэн хийлгэх, эсвэл гэмт этгээд болон гуравдагч этгээдийн өмнө эсвэл гэмт этгээд болон гуравдагч этгээдтэй бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийлгүүлж мөлжсөн бол 6 сараас 10 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд хүн худалдаалах гэмт хэрэг нь мөлжих зорилго биелэгдээгүй байсан ч гэмт хэргийн бүрэлдэхүүн хангагдах боломжтой гэж үздэг. Хүн худалдаалах гэмт хэргийг худалдах, худалдан авснаар бус харин гэмт хэргийн бэлтгэл үе шатанд буюу ашиг олоход чиглэсэн үйлдэл хийснээр гэмт хэргийн бүрэлдэхүүн хангагдана хэмээн ЕХ-ны зарим нэг улс үздэг байна. Эдгээр улсуудаас Бүгд Найрамдах Австри Улс /цаашид "Австри улс" гэх/-ыг нэрлэж болно.

Хүн худалдаалах гэмт хэргийн бэлтгэл үе шатанд эрүүгийн хариуцлага хүлээлгэх жишиг (Австри улсын жишээн дээр)

Эрүүгийн эрх зүйн чухал судлагдахуун болох гэмт хэрэг үйлдэх үе шат нь зөвхөн санаатай гэмт хэрэгт яригдах ойлголт бөгөөд энэ нь *гэмт хэрэг үйлдэхээр шийдэх-гэмт хэрэгт бэлтгэх-гэмт хэрэг үйлдэхээр завдах-төгссөн гэмт хэрэг* гэсэн үе шатыг дамждаг.⁹⁰ Хүн гэмт хэрэг үйлдэхээр оюун бодолдоо шийдвэрлэж буй шийдвэрт эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй. Харин гэмт хэрэгт бэлтгэх үе шат нь гэмт хэрэг бодит байдлаар илэрч эхлэх анхдагч үе бөгөөд субъектийн үйлдэл нь энэ үеэс

нийгэмд аюултай шинжийг агуулж эхэлдэг⁹¹ ч уг үе шатанд зарчмын хувьд ял шийтгэл хүлээлгэдэггүй.⁹² Гэхдээ зарим онцгой тохиолдолд хууль тогтоогч гэмт хэрэгт бэлтгэх үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байдаг.⁹³ Тухайлбал Австри улс нь хүн худалдаалах гэмт хэрэгт хохирогчийг мөлжихийн өмнөх шатанд хийгддэг хүнийг элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, орогнуулах, хүлээн авах үйлдлийг хүн худалдаалах гэмт хэрэгт бэлтгэх үе шат хэмээн үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 104а дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан байна.⁹⁴ Уг хэм хэмжээ нь үндсэндээ хүн бүрийг мөлжлөгт хүргэх үйлдлээс хамгаалах зорилготой бөгөөд бодитоор мөлжлөгт оруулахаас өмнөх үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байна.⁹⁵ Харин Герман улсад хүн худалдаалах гэмт хэргийн бэлтгэл үе шатанд бус төгссөн гэмт хэрэг буюу хохирогчийн гарцаагүй байдал, тусламж авах боломжгүйг далимдуулан биеийг нь үнэлүүлж, бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийлгүүлж ашиг олсон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр нэг мөр хуульчилсныг харуулах зорилгоор Австри улсын жишээг оруулав.

Ийнхүү Австри улсад хүнийг мөлжих зорилгоор элсүүлсэн, тээвэрлэсэн, дамжуулсан орогнуулсан үйлдлийг хүн худалдаалах гэмт хэрэгт бэлтгэх үе шат хэмээн үзэж уг үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан бол Герман улсад дээрх үйлдлүүдийг хүн худалдаалах гэмт хэрэг бус харин **хүн худалдаалах гэмт хэрэгт дэмжлэг үзүүлэх гэмт хэрэг** хэмээн тодорхойлж байсан нь анхаарал татав. Учир нь манай улс хүн худалдаалах гэмт хэрэгт тээвэрлэсэн, дамжуулсан, орогнуулсан, хүлээн авсан үйлдлийг хүн худалдаалж байгааг мэдсэн этгээдэд хамааралтай үйлдэл хэмээн Улсын дээд шүүхээс гаргасан 2008 оны абстракт тайлбарт тусгасан байдаг.

Эрүүгийн хуулийн 233а дугаар зүйл. Хүн худалдаалах гэмт хэрэгт дэмжлэг үзүүлэх⁹⁶

1.Энэ хуулийн 232 эсвэл 233 дугаар зүйлд заасан хүн худалдаалах гэмт хэрэгт дэмжлэг үзүүлэхээр бусад хүнийг элсүүлсэн, тээвэрлэсэн, дамжуулсан, орогнуулсан, хүлээн авсан бол 3 сараас 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Хүн худалдаалах гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүн болох мөлжих зорилгоор хүнийг элсүүлсэн, тээвэрлэсэн, дамжуулсан, орогнуулсан, хүлээн авсан үйлдлийг хүн худалдаалах гэмт хэрэгт дэмжлэг үзүүлж буй этгээдэд хамруулахаар хуульчилсныг эрдэмтэд шүүмжилсээр иржээ. Иймд эрүүгийн хуульд заасан хүн худалдаалах гэмт хэргийг олон эрх зүйн хэм хэмжээнд тохируулах шаардлага бий болсон байна.

II. Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлт буюу одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хэм хэмжээ

Герман улсын Эрүүгийн хууль (1871)⁹⁷-ийн **хүний эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг бүлэгт** хүн худалдаалах гэмт хэргийг хуульчилсан бөгөөд уг заалтад 2016 оны 10 дугаар сарын 11-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулжээ.⁹⁸ Өөрчлөлт оруулахдаа ЕХ-ны парламентаас 2011 онд баталсан Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх болон

хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах удирдамж⁹⁹-д нийцүүлэхийг зорьж, Эрүүгийн хуулийн 233а дугаар зүйлд заасан “Хүн худалдаалах гэмт хэрэгт дэмжлэг үзүүлэх”-гэмт хэргийг өөрчлөн хүн худалдаалах гэмт хэргийн үндсэн шинж байхаар Эрүүгийн хуулийн 232 дугаар зүйлд хуульчилжээ.

I). Хүн худалдаалах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 232 дугаар зүйл)

Олон улсын эрх зүйн хэм хэмжээнд хүн худалдаалах гэмт хэрэгт хохирогчийг заавал мөлжих зорилго хангагдсан байхыг шаардахгүй, хохирогчийг мөлжих зорилгоор үргэлжилсэн процесст хамаарах аль нэг үйлдлийг гүйцэтгэснээр гэмт хэрэг төгсөж болно гэх зөвлөмжийн дагуу тус улсад хүн худалдаалах гэмт хэрэгт хүнийг мөлжлөгт оруулахаас өмнөх процесст хамаарах үйлдлүүдийг хамруулжээ. Ийнхүү хуульчлахдаа үйлдлийн аргаар нь:

- “энгийн үйлдлийн аргаар үйлдэгдэх хүн худалдаалах гэмт хэрэг” болон
- “хүнд үйлдлийн аргаар үйлдэгдэх хүн худалдаалах гэмт хэрэг” хэмээн 2 хэсэгт хуваасан байна.

Гэмт этгээд хохирогчийн гарцаагүй байдал, тусламж авах боломжгүй байдлыг ашиглан хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэнийг энгийн аргаар үйлдэгдэх хүн худалдаалах гэмт хэрэг, харин албадлага хэрэглэх, хулгайлах, эрхшээлдээ оруулах аргаар үйлдсэнийг хүнд үйлдлийн аргаар үйлдэгдэх хүн худалдаалах гэмт хэрэг гэнэ.¹⁰⁰ Энгийн эсвэл хүнд үйлдлийн аргаар хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэнээс хамааран ялын бодлого ялгаатай байдаг. Дээрх гэмт хэргүүдийг доор дэлгэрүүлэн авч үзвэл:

а. Энгийн үйлдлийн аргаар үйлдэгдэх хүн худалдаалах гэмт хэрэг

Эрүүгийн хуулийн 232 дугаар зүйлийн 1 дэх хэсэг нь энгийн үйлдлийн аргаар үйлдэгдэх хүн худалдаалах гэмт хэрэгт хамаарна.

Эрүүгийн хуулийн 232 дугаар зүйл. Хүн худалдаалах гэмт хэрэг

1) Хүний хувийн болон эдийн засгийн гарцаагүй байдал эсвэл гадаад улсад байгаа улмаас тусламж авах боломжгүй байдлыг ашиглан эсвэл 21 насанд хүрээгүй хүнийг

- a) Биеийг нь үнэлүүлэх болон гэмт этгээд эсвэл гуравдагч этгээдийн өмнө эсвэл гэмт этгээд болон гуравдагч этгээдтэй бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийлгүүлэх;
- b) Хөдөлмөр эрхлүүлэх;
- c) Гуйлга гуйлгах;
- d) Гэмт хэрэг үйлдүүлэх;

2) Боолчлох, хамжлагат хөдөлмөр эрхлүүлэх;

3) Эд, эрхтнийг нь хууль бусаар авах зорилгоор элсүүлсэн, тээвэрлэсэн, дамжуулсан, орогнуулсан, хүлээн авсан бол 6 сараас 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Хуульд заасан **гарцаагүй байдал** гэдэгт хохирогчид хувийн болон эдийн засгийн хүнд байдал үүссэн буюу мөнгө болон эд материалын зайлшгүй хэрэгцээ шаардлага үүссэнийг ойлгоно.¹⁰¹ **Орогнуулсан гэдэгт** хохирогчид орон байр гаргаж өгөх, эсвэл байр, зочид буудал, чиргүүлэн сууцанд байлгах, мөн богино хугацаанд байр түрээслэх замаар орон байраар хангах зэрэг ямар ч хэлбэрээр орогнуулж болно.¹⁰² Харин **хүлээн авсан** гэх ухагдахууныг эрдэмтэд өөр өөр байдлаар тайлбарладаг байна. *Эхнийх нь* "хүлээн авсан" гэдэг нь хохирогчийг тодорхой хугацаанд байрлуулахаар орон байр гаргаж өгөхийг хэлнэ хэмээн тайлбарладаг бөгөөд уг тайлбарт зарим эрдэмтэд орогнуулах гэсэн ойлголтод хамаарах учраас бие даасан утга илэрхийлэхгүй хэмээн шүүмжилдэг. *Удаах тайлбарт* "хүлээн авсан" гэдэг нь хохирогчийг завсрын байршилд хүлээн авч, гэмт хэрэгтэн хохирогчийг хяналтдаа байлгадаг гэж тайлбарладаг байна. Тус тайлбарт хүлээн авах үйлдэл нь орогнуулах үйлдэлд хамаарахгүй, бие даасан үйлдэл хэмээн тайлбарлахын сацуу ЕХ-ны конвенцод нийцүүлэх үүднээс ингэж тайлбарлах нь зүйтэй гэж зарим эрдэмтэд үздэг.¹⁰³ Хохирогч 21 насанд хүрээгүй тохиолдолд гарцаагүй байдал болон тусламж авах боломжгүй байдлыг ашиглан үйлдсэн байхыг шаарддаггүй.

Хүн худалдаалах гэмт хэргийг энгийн үйлдлийн аргаар үйлдсэн бол хүнд үйлдлийн аргаар үйлдсэнээс хөнгөн ял шийтгэл оногдуулах буюу 6 сараас 5 жилийн хугацаагаар хорих ял шийтгэнэ. Тус улсад өмнө нь хүн худалдаалах гэмт хэрэгт дэмжлэг үзүүлэх хэмээн хуульчилж ирсэн зохицуулалтыг хүн худалдаалах гэмт хэрэг хэмээн зааж хүнийг янз бүрийн хэлбэрээр мөлжлөгт оруулж ашиг олохоос өмнөх үйл явцыг хамруулсан байна.

6. Хүнд үйлдлийн аргаар үйлдэгдэх хүн худалдаалах гэмт хэрэг

Эрүүгийн хуулийн 232 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хүнд үйлдлийн аргаар үйлдэгддэг хүн худалдаалах гэмт хэргийг хуульчилсан.

Эрүүгийн хуулийн 232 дугаар зүйл. Хүн худалдаалах гэмт хэрэг

2) Хүнийг энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх өгүүлбэрийн 1-3 -т заасан аргаар мөлжих зорилгоор

1. Хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн эсвэл хууран мэхэлж элсүүлсэн, тээвэрлэсэн, дамжуулсан, орогнуулсан, эсвэл хүлээн авсан эсвэл
2. Хохирогчийг хулгайлж, эрхшээлдээ оруулж эсвэл гуравдагч этгээдийн эрхшээлд оруулсан бол 6 сараас 10 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Хүнд үйлдлийн аргад хохирогчийн гарцаагүй байдал болон тусламж авах боломжгүй байдлыг гэмт этгээд ашиглаагүй байдаг тул уг заалт нь хүн худалдаалах гэмт хэргийн хүндрүүлэх шинж биш юм.¹⁰⁴ Хүнд үйлдлийн аргад дараах үйлдлийн аргуудыг хамруулжээ:

- Хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн эсвэл хууран мэхэлж элсүүлсэн, тээвэрлэсэн, дамжуулсан, орогнуулсан, хүлээн авсан эсвэл,

- Хохирогчийг хулгайлж, эршээлдээ оруулж эсвэл гуравдагч этгээдийн эршээлд оруулсан.

Хууль тогтоогч хүн худалдаалах гэмт хэргийг хүнд үйлдлийн аргаар үйлдсэн тохиолдолд ялын бодлогыг чангатгах бодлого баримтлан 6 сараас 10 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар хуульчилжээ.

в. Хүн худалдаалах гэмт хэргийн хүндрүүлэх шинж

Хууль тогтоогч Эрүүгийн хуулийн 232 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт хүн худалдаалах гэмт хэргийн үндсэн шинжийг үйлдлийн аргаар нь 2 хэсэгт хуваан тусгасан бол 3 дахь хэсэгт хүн худалдаалах гэмт хэргийн хүндрүүлэх шинжийг дараах байдлаар хуульчилсан.

- Гэмт хэрэг үйлдэгдэх үед хохирогч 18 насанд хүрээгүй;
- Хохирогчид сөрөг үр дагавар бий болгосон;
- Бизнесийн зорилгоор болон зохион байгуулалттай гэмт бүлэглэл үйлдсэн.

Хүндрүүлэх шинжид дурдсан **сөрөг үр дагавар гэдэгт** хохирогчийн бие махбодод хүнд гэмтэл учруулсны улмаас хохирогч амь насаа алдсаныг хамруулдаг. Гэхдээ санаатайгаар бие махбодод нь хүнд гэмтэл учруулж улмаар хохирогч нас барсан тохиолдлыг хамруулахгүй, зөвхөн болгоомжгүйгээр хохирогчийн амь насыг хохироосон тохиолдлыг хамруулжээ.¹⁰⁵

Энгийн үйлдлийн аргаар хүн худалдаалах гэмт хэргийг дээрх хүндрүүлэх шинжээр үйлдсэн тохиолдолд 6 сараас 10 жил хүртэлх хугацаагаар хорих ял оногдуулна. Харин хүнд үйлдлийн аргаар хүн худалдаалах гэмт хэргийг дээрх хүндрүүлэх шинжээр үйлдсэн тохиолдолд 1 жилээс 10 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар тус тус заажээ.

Кейс №2 : Бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэрэг

Үйл баримт: Румын улсын иргэн А нь амьжиргааны түвшин доогуур гэр бүлд төрсөн хэдий ч сургуулиа амжилттай төгсөж, их сургуульд элсэн орохоор шаргуу зүтгэсээр иржээ. Тэрээр Герман улсад хэдэн жилийн өмнөөс амьдарч эхэлсэн Б-тэй танилцсан бөгөөд Б түүнд боломжийн цалинтай ажил санал болгож, улмаар А нь Б-д итгэн түүнийг дагаж Герман улсад ирсэн байна. А тус улсад ирсний дараа Б нь түүнд биеэ үнэлэх ажил санал болгожээ. А уг саналаас татгалзсан хэдий ч Б түүнийг зодож, заналхийлсний улмаас саналыг зөвшөөрч биеэ үнэлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг зуучлалын газар очжээ. Уулзалтын үеэр байгууллагын ажилтан А-г хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч байж магадгүй хэмээн таамаглаж, бүсгүйг хамгаалах байгууллагад хүлээлгэн өгчээ. А цагдаад гомдол гаргаж, мөрдөн шалгах ажиллагаа явуулжээ.

Шүүхийн шийдвэр: шүүх Б-г бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож гурван жил, гурван сарын хугацаагаар хорих ял оногдуулсан байна.

Герман улсад хүн худалдаалах гэмт хэргийг үйлдлийн аргаар нь салган ялгаатай байдлаар хуульчилснаас гадна гэмт этгээд хүнийг мөлжиж ашиг олохоос өмнө хийгддэг үргэлжилсэн процесс үйлдлийг хүн худалдаалах гэмт хэрэг хэмээн хуульчилснаараа онцлог байна. Харин хүн худалдаалах гэмт хэргийн үйлдлийн аргуудыг ашиглан үр дүнд хүрсэн буюу бэлгийн мөлжлөгт оруулсан, албадан хөдөлмөрлүүлснийг тусдаа гэмт хэрэг байхаар хуульчилсныг Эрүүгийн хуулийн 232а дугаар зүйлд хүчээр биеийг нь үнэлүүлэх, 232b дугаар зүйлд албадан хөдөлмөрлүүлэх зэрэг гэмт хэргүүдийг зааснаас харж болохоор байна. Эдгээрээс албадан биеийг нь үнэлүүлэх гэмт хэргийг II дэд хэсэгт дэлгэрүүлэн авч үзэв.

II) Албадан биеийг нь үнэлүүлэх (Эрүүгийн хуулийн 232а дугаар зүйл)

Тус улсад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хэд хэдэн хэлбэрээр мөлжих зорилгоор үйлдэгддэг бөгөөд үүний нэг нь бэлгийн мөлжлөгийн зорилгоор хуульд заасан хөнгөн болон хүнд үйлдлийн аргуудыг ашиглан элсүүлсэн, тээвэрлэсэн, дамжуулсан, орогнуулсан, хүлээн авсан үйлдэл хийснээр гэмт хэргийн бүрэлдүүн хангагддаг хэмээн үздэг. Харин уг процесс ажиллагааны үр дүнд хүнийг бэлгийн харьцаанд албадан оруулсан, бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийлгэсэн бол албадан биеийг нь үнэлүүлэх гэмт хэрэг¹⁰⁶ үйлдсэнд тооцож хүн худалдаалах гэмт хэргээс илүү хүнд ял шийтгэл оногдуулахаар тусад нь хуульчилжээ.

2016 оны Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс өмнө уг гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 232 дугаар зүйлд “бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах” гэмт хэрэг хэмээн хуульчилж байсан ч одоо албадан биеийг нь үнэлүүлэх гэмт хэрэг болгон өөрчилсөн байна. Уг гэмт хэргийг эрүүгийн хуульд тусгахдаа хүн худалдаалах гэмт хэргийн адил үйлдлийн аргаар нь хуваан ялгамжтай ял шийтгэл оногдуулдаг.

а. Энгийн үйлдлийн аргаар албадан биеийг нь үнэлүүлэх гэмт хэрэг

Эрүүгийн хуулийн 232а дугаар зүйл. Албадан биеийг нь үнэлүүлэх¹⁰⁷

1). Хүний хувийн болон эдийн засгийн гарцаагүй байдал эсвэл гадаад улсад байгаа улмаас тусламж авах боломжгүйг ашиглан эсвэл 21 насанд хүрээгүй байгаа хүнийг

1. биеэ үнэлэхэд татан оролцуулсан, цаашид биеэ үнэлэхийг үргэлжлүүлэн хийлгэсэн эсвэл
2. мөлжих замаар гэмт этгээд болон гуравдагч этгээдийн өмнө бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийлгэсэн, эсвэл гэмт этгээд болон гуравдагч этгээдтэй бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийлгэсэн бол 6 сараас 10 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2). Уг гэмт хэрэгт завдах тохиолдолд ял шийтгэл хүлээлгэнэ.

Албадан биеийг нь үнэлүүлэх гэмт хэрэгт гэмт этгээд нь хохирогчийн хувийн болон эдийн засгийн гарцаагүй байдал, тусламж гуйх боломжгүй байдлыг ашиглах үйлдлийн аргаар гүйцэтгэсэн байх бөгөөд хохирогч 21 насанд хүрээгүй тохиолдолд дээрх аргаар үйлдэгдсэн байхыг шаардахгүй. Гарцаагүй байдал болон тусламж авах бололцоогүй байдлыг ашигласан гэдэг нь Эрүүгийн хуулийн 232 дугаар зүйлд заасан хүн худалдаалах гэмт хэрэгтэй харьцуулахад мөлжих зорилго агуулаад зогсохгүй бэлгийн мөлжлөгт бодитоор оруулсан байдаг.

Оногдуулах ял шийтгэлийн хувьд гарцаагүй байдал эсвэл тусламж авах боломжгүй байдлыг ашиглан биеийг нь үнэлүүлсэн, цаашид уг үйлдлээ үргэлжлүүлсэн, бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийлгүүлсэн бол 6 сараас 10 жил хүртэлх хугацаагаар хорих ял оногдуулна.

б. Хүнд үйлдлийн аргаар албадан биеийг нь үнэлүүлэх гэмт хэрэг

Эрүүгийн хуулийн 232а дугаар зүйл. Албадан биеийг нь үнэлүүлэх¹⁰⁸

3) Хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хууран мэхлэх замаар хүнийг биеэ үнэлэхэд татан оролцуулсан эсвэл цаашид биеэ үнэлэхийг үргэлжлүүлэн хийлгэсэн, эсвэл гэмт этгээд болон гуравдагч этгээдийн өмнө бэлгийн харилцааны шинжтэй үйлдэл хийлгүүлсэн эсвэл гэмт этгээд болон гуравдагч этгээдтэй бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийлгүүлсэн бол 1-10 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Дээрх хүнд үйлдлийн аргуудыг ашиглан албадан биеийг нь үнэлүүлэх гэмт хэрэг үйлдсэн бол энгийн үйлдлийн арга ашигласантай харьцуулахад хүнд ял шийтгэл оногдуулахаар байна.

в. Албадан биеийг нь үнэлүүлэх гэмт хэргийн хүндрүүлэх шинж

Албадан биеийг нь үнэлүүлэхдээ энгийн үйлдлийн арга болох хохирогчийн хувийн болон эдийн засгийн гарцаагүй байдал, гадаад улсад байгаа улмаас тусламж авах боломжгүй байдлыг далимдуулан:

- Гэмт хэрэг үйлдэгдэх үед хохирогч 18 насанд хүрээгүй;
- Хохирогчид сөрөг үр дагавар бий болгосон;
- Бизнесийн зорилгоор болон зохион байгуулалттай гэмт бүлэглэл үйлдсэн тохиолдолд 1-10 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Харин албадан биеийг нь үнэлүүлэх гэмт хэргийг хүнд үйлдлийн аргаар буюу хохирогчид хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хууран мэхлэх замаар:

- Гэмт хэрэг үйлдэгдэх үед хохирогч 18 насанд хүрээгүй;
- Хохирогчид сөрөг үр дагавар бий болгосон;
- Бизнесийн зорилгоор болон зохион байгуулалттай гэмт бүлэглэл үйлдсэн тохиолдлын хувьд 1 жилээс доошгүй хугацаагаар хорих ял шийтгэхээр тус тус хуульчилжээ.

Албадан биеийг нь үнэлүүлэх гэмт хэргийн хүндрүүлэх шинж нь хүн худалдаалах гэмт хэргийн хүндрүүлэх шинжтэй адил бөгөөд хохирогчийн гарцаагүй байдлыг далимдуулах аргыг хэрэглэсэн тохиолдлын хувьд 1-10 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар, харин хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хууран мэхлэх үйлдлийн аргыг ашиглан хүндрүүлэх шинжтэйгээр үйлдсэн тохиолдолд 1 жилээс доошгүй хугацаагаар хорих ял шийтгэхээр тус тус хуульчилсан байна. Сүүлийн тохиолдлын хувьд хууль тогтоогч хорих ялын доод хэмжээг 1 жил хэмээн заасан

ч хорих ялын дээд хэмжээг нээлттэй үлдээжээ. Энэ нь шүүхээс дээрх тохиолдолд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийг журамлан¹⁰⁹ 15 жил хүртэлх хугацаагаар хорих ял оногдуулах боломжтой.

Тус улсад 1999 онд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, хохирогчид туслах зорилгоор **КОК** e.V (*Bundesweiter Koordinierungskreis gegen Menschenhandel*) холбоог байгуулжээ. Холбооноос хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчдын хувийн байдлыг тодруулахад туслах үүднээс шалгуур үзүүлэлт бүхий жагсаалтыг боловсруулсан. Хохирогч хүн худалдаалах гэмт хэргийн хэлбэрүүд болох бэлгийн мөлжлөг, гуйлга гуйлгах, гэмт хэрэг үйлдүүлэх зэрэг хэлбэрийн алинд өртсөн болохыг тодорхойлоход дээрх жагсаалтыг ашигладаг. Албадан биеийг нь үнэлүүлэх гэмт хэргийн шинжийг харуулсан жагсаалтыг доор оруулав. Үүнд:¹¹⁰

Албадан биеийг нь үнэлүүлэх (Ажиллах нөхцөл)

- Хохирогчийг гудамжинд, биеэ үнэлэх газарт, хувийн орон сууцанд, зочид буудалд биеийг нь үнэлүүлдэг;
- Хохирогчийг гуравдагч этгээдээр байнга хянуулдаг. Тухайлбал биеэ үнэлдэг өөр хүнээр, гэр бүлийн гишүүнээр, эсвэл хамт ажиллаж буй хүнээр;
- Хохирогч маш бага цалин хөлс авдаг, эсвэл огт цалин хөлс авдаггүй;
- Хохирогч аль нэг үйлчлүүлэгчээс татгалзах эрхгүй эвсэл ямар нэгэн үйлдэл хийхээс татгалзах эрхгүй. Жишээлбэл, хамгаалалтгүйгээр бэлгийн харьцаанд орохоос татгалзах эрхгүй;
- Хохирогч өдөрт үйлчлүүлэх үйлчлүүлэгчдийн тоонд хязгаар тавих эрхгүй;
- Хохирогч аль ч цагт бэлэн байх буюу 24 цаг бэлэн байхыг шаарддаг, тусгайлсан амралтын өдөр гаргаж өгддөггүй;
- Хохирогч хүссэн үедээ биеэ үнэлэхээ болих эсвэл эх орон руугаа буцах шийдвэр гаргах эрхгүй;
- Осол гэмтэл, өвчин эмгэг, жирэмслэлтийн үед шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлдэггүй;

Амьдрах нөхцөл

- Хохирогч биеэ үнэлэхээ урьдчилан мэдээгүй байдаг;
- Хохирогч биеэ үнэлэхээ мэдсэн ч ямар нөхцөлд ажиллахаа мэдээгүй байдаг;
- Хохирогчийн зөвшөөрөлгүйгээр түүний нүцгэн дүрсний/дуу-дүрсний бичлэгийг авч сүрдүүлдэг;
- Биеэ үнэлдэг талаар гэр бүл, ойр дотнын хүмүүст хэлнэ гэж сүрдүүлдэг;
- Соёлын болон шашны итгэл үнэмшлийг ашигладаг.

Бэлгийн мөлжлөгийн хэлбэрийг хуульчилсан бас нэг тусдаа зохицуулалт нь эрх чөлөөг нь хасах замаар бэлгийн мөлжлөгт оруулах гэмт хэрэг юм.

III. Эрх чөлөөг нь хасах замаар мөлжих гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 233а дугаар зүйл)**Эрүүгийн хуулийн 233а дугаар зүйл. Эрх чөлөөг нь хасах замаар мөлжлөгт оруулах**

1) Бусад хүнийг хорих эсвэл бусад аргаар эрх чөлөөг нь хязгаарлах замаар

1. биеийг нь үнэлүүлэх,
2. энэ хуулийн 232 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэрт зааснаар хөдөлмөр эрхлүүлэх,
3. гуйлга гуйлгах,
4. ял шийтгэл оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдүүлж мөлжлөгт оруулсан бол 1- 10 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Уг гэмт үйлдлийг хоёр хэсэгт хуваан авч үздэг:¹¹¹ Нэг талаас гэмт хэрэгтэн хохирогчийн эрх чөлөөг хасдаг. Нөгөө талаас эрх чөлөөгөө хасуулсан хохирогчийг янз бүрийн хэлбэрээр мөлжлөгт оруулдаг байна.

Хүснэгт 1. Дээрх гэмт хэргүүдийг зорилго, үйлдэл, үйлдлийн аргаар нь доорх хүснэгтэд харьцуулан харуулав.

Гэмт хэрэг	Үйлдэл	Үйлдлийн арга	Зорилго	Үндсэн шинжид оногдуулах ял шийтгэл
Хүн худалдаалах гэмт хэрэг (§ 232 StGB)	Элсүүлэх, Тээвэрлэх, Дамжуулах, Орогнуулах, Хүлээн авах	Энгийн үйлдлийн арга: Хувийн болон эдийн засгийн гарцаагүй байдлыг ашиглах, Гадаад оронд байгаа улмаас тусламж авах боломжгүй байдлыг ашиглах	Биеийг нь үнэлүүлэх/ бэлгийн харилцааны шинжтэй үйлдэл хийлгэх, Хөдөлмөр эрхлүүлэх,	Энгийн үйлдлийн арга ашигласан тохиолдолд : 6 сараас 5 жил хорих ял
		Хүнд үйлдлийн арга: Хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, хууран мэхэлж, хулгайлж, эрхшээлдээ оруулж эсвэл гуравдагч этгээдийн эрхшээлд оруулсан,	гуйлга гуйлгах, Гэмт хэрэг үйлдүүлэх, Боолчлох, хамжлагат хөдөлмөр эрхлүүлэх, Эд, эрхтнийг хууль бусаар авах,	Хүнд үйлдлийн арга ашигласан тохиолдолд: 6 сараас 10 жил хорих ял
Албадан биеийг нь үнэлүүлэх (§232a StGB)	Хүний хүсэл зоригийн эсрэг тулган шаардах тухайлбал, ятгах, шахаанд оруулах, эрх мэдлээ ашиглах.	Энгийн үйлдлийн арга: Хувийн болон эдийн засгийн гарцаагүй байдлыг ашиглах, гадаад оронд байгаа улмаас тусламж авах боломжгүй байдлыг ашиглаж	Бие үнэлэхэд татан оролцуулах буюу тухайн үйлдлээ үргэлжлүүлэх, мөлжих зорилгоор бэлгийн	Энгийн үйлдлийн арга ашигласан тохиолдолд : 6 сараас 10 жил хорих ял
		Хүнд үйлдлийн арга: Хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хууран мэхлэх	харилцааны шинжтэй үйлдэл хийлгэх,	Хүнд үйлдлийн арга ашигласан тохиолдолд : 1-10 жил хорих ял

Эрх чөлөөг нь хасах замаар мөлжих (§233a StGB)	Мөлжих	бусдын эрх чөлөөг хасах замаар	Биеийг нь үнэлүүлэх, албадан биеийг нь үнэлүүлэх, албадан хөдөлмөр эрхлүүлэх, гуйлга гуйлгах, гэмт хэрэг үйлдүүлсэн	1-10 жил хорих ял
--	--------	--------------------------------	---	-------------------

4.3 ТАЙВАНЬ УЛС

Азийн орнуудад хүн худалдаалах гэмт хэргийн түгээмэл үйлдэгддэг хэлбэрүүдийн нэг нь эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор худалдах байдаг. Тайвань улсын 2008-2023 оны 04 дүгээр сар хүртэлх хугацаанд шүүхээр шийдвэрлэгдсэн хүн худалдаалах гэмт хэргийн статистикт бэлгийн мөлжлөгийн хэлбэр хамгийн их буюу 68.4 хувийг эзэлж байна.¹¹²

Тайвань улсын хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх "4P" тогтолцоо нь яллах, хамгаалах, урьдчилан сэргийлэх, хамтран ажиллах гэсэн үндсэн дөрвөн хэсгээс бүрддэг. Энэ цогц тогтолцооны эрх зүйн үндэслэлийг 2009 онд баталсан Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд баталгаажуулжээ. Уг хуулийн зорилго нь хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогчийн эрхийг хамгаалахад орших бөгөөд гэмт хэргийн шинж, оногдуулах эрүүгийн хариуцлага, төрийн байгууллагуудын чиг үүрэг, эрх хэмжээг зохицуулсан байна. 2023 онд тус хуульд хүн худалдаалах гэмт хэргийн шинэ хэлбэр буюу хохирогчоор гэмт хэрэг үйлдүүлэх, ялын бодлогыг чангатгах, хохирогчид тусламж үзүүлэхтэй холбоотой журам батлах зэрэг томоохон нэмэлт өөрчлөлт хийжээ.¹¹³

1) Эрүүгийн хууль (1935)¹¹⁴

Хүн худалдаалах гэмт хэрэг

296. Хүнийг боолчилсон, боолтой адилтгах эрх чөлөөгүй байдалд байрлуулсан бол 1-7 жил хүртэлх хугацаатай хорих ял шийтгэнэ.

296-1 дүгээр зүйлийн 1. Хүнийг худалдсан, барьцаалсан бол 5 жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэж, торгоно.

2. Бэлгийн харьцаанд оруулах эсхүл, садар самуун үйлдэлд оруулах зорилгоор энэ гэмт хэргийг үйлдсэн бол 7 жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэж, торгоно.

3. 296-1, 2-т заасан гэмт хэргийг хүчирхийлэх, заналхийлэх, сүрдүүлэх, хорих, хяналт тавих, мансууруулах, гипноз эсхүл бусад өөрийнх нь хүсэл зоригийн эсрэг аргаар үйлдсэн бол тухайн зүйл хэсэгт заасан ялын хэмжээг тал хүртэлх хувиар нэмж оногдуулна.

4. 1, 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийн хохирогчийг хүлээн авсан, орогнуулсан, зохион байгуулсан бол 7 жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэж, торгоно.

5. Төрийн албан хаагч дээрх дөрвөн хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нуун дарагдуулсан бол тухайн зүйл хэсэгт заасан ялын хэмжээг тал хүртэлх хувиар нэмж оногдуулна.

Тайвань улсын эрүүгийн хуульд хүнийг боолчлох, үүнтэй адилтгах эрх чөлөөгүй байдал байрлуулах, хүнийг худалдах, барьцаалах зэрэг үр дүнг хамруулсан үйлдэл болон гэмт хэргийн хохирогчийг хүлээн авсан, орогнуулсан, зохион байгуулсан зэрэг үйл явцыг хамруулсан үйлдлийг нэгтгэж хүн худалдаалах гэмт хэрэгт хуульчилжээ. Уг гэмт хэргийн хүндрүүлэх шинжийг зорилго, үйлдлийн арга, субъектэд тулгуурлан ангилсан байна. Тус улсын эрүүгийн хуульд заасан хүн худалдаалах гэмт хэргийн шинжийг протоколын тодорхойлолт, зорилготой харьцуулахад явцуу хүрээнд тогтоожээ.

II) Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль (2009)

Тайвань улсад энэ төрлийн гэмт үйлдэлтэй тэмцэхэд эрүүгийн хуулиас гадна тусгайлсан зохицуулалттай хууль буюу Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргийг тусад нь хуульчилсан байна. Ийнхүү эрүүгийн хуулиас гадна тусгай хуульд давхар зохицуулах нь харилцан нэг нэгнээ нөхөж үйлчлэх, гэмт хэрэгтэй тэмцэх цогц тогтолцоог бүрдүүлэх зорилготой ажээ.¹¹⁵ Энэ хуульд хүн худалдаалах гэмт хэргийн шинжийг доорх байдлаар тодорхойлсон байна. Үүнд:¹¹⁶

Субъектив тал: санаатай, мөлжих зорилготой байх бөгөөд дараах арга, үйлдлээр хэрэгжинэ.

Хууль бус үйлдлийн арга: хүчирхийлэх, заналхийлэх, сүрдүүлэх, хорих, хяналт тавих, мансууруулах, гипноз, хууран мэхлэх, чухал мэдээллийг санаатайгаар нуух, өрийн дарамтад оруулах, чухал бичиг баримт /паспорт, иргэний эрх зүйн байдлыг гэрчилсэн баримт/-ыг хураах, хохирогчийн мэдлэггүй, биеэ хамгаалах чадваргүй эсхүл тусламж авахад хүндрэлтэй байдлыг ашиглах, эсхүл бусад төстэй аргыг ашиглах. Харин 18 насанд хүрээгүй хүний эсрэг үйлдсэн бол дээрх аргаар үйлдэгдсэн байхыг шаардахгүй.

Хууль бус үйлдэл: элсүүлэх, худалдах, барьцаалах, тээвэрлэх, шилжүүлэх, хүлээн авах, орогнуулах, нуух, зуучлах, дотоодын болон гадаадын иргэнийг орон байраар хангах; Бусдыг төлбөртэй бэлгийн харьцаанд оруулах, эсхүл садар самуун үйлдэл хийлгэх; Хүнийг боолчлох болон боолтой адилтгах, албадан хөдөлмөрлүүлэх, хөдөлмөрийн мөлжлөгт оруулах, тус улсын хууль тогтоомжид заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх үйлдэл хийлгэх; Эд эрхтнийг авах зэрэг үйлдлүүд орно.

Хүн худалдаалах гэмт үйлдэлд Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Хөдөлмөрийн стандартын тухай хууль, Хүүхэд, өсвөр насныхныг бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх тухай журам, Хүний эд эрхтэн шилжүүлэн суулгах тухай журам болон бусад холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн үйлдлийг ойлгоно.¹¹⁷

а. Бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг

Өрийн дарамтад оруулах эсхүл хохирогчийн мэдлэггүй, биеэ хамгаалах чадваргүй эсхүл тусламж авахад хүндрэлтэй байдлыг ашиглаж төлбөртэй бэлгийн харьцаанд оруулах, эсхүл садар самуун үйлдэлд оруулсан бол 6 сараас 5 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэж, торгоно.¹¹⁸

Энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол бүх насаар нь хорих ял шийтгэх эсхүл 7 жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэж, торгоно. Харин гэмт хэргийн улмаас хохирогчийн эрүүл мэндэд хүнд гэмтэл учирсан бол 3-10 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэж, торгоно.¹¹⁹

Энэ гэмт хэргийн ердийн бүрэлдэхүүнийг ашиг олох зорилгоор үйлдсэн бол 1-7 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэж, торгоно. Хохирогч нас барсан бол бүх насаар нь хорих ял шийтгэх эсхүл 10 жилээс дээш хугацаагаар хорих ялаар шийтгэж, торгоно. Харин хохирогчийн эрүүл мэндэд хүнд гэмтэл учирсан бол 5-12 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэж, торгохоор хуульчилжээ.¹²⁰

Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн шинжийг дараах байдлаар тайлбарлажээ. Үүнд:

Субъектив тал: Ашиг олох зорилготой байх бөгөөд бодитоор ашиг олсон эсэхийг харгалзан үзэхгүй.

Объектив тал: Төлбөртэй бэлгийн харьцаанд оруулах, эсхүл садар самуун үйлдэлд оруулсан байна.

Өрийн дарамтад оруулах гэдэг нь өр төлбөрийг барагдуулах, төлөх баталгааг хангахын тулд эргэн төлөх арга хэрэгсэл, агуулга тодорхойгүй, эсхүл үндэслэлгүй өр төлбөрийг ашиглана. Түүнчлэн хууль бусаар хил нэвтрүүлэх төлбөр, хуурамч гэрлэлтийн төлбөр, тэдгээрийн хүү зэрэг төрөл бүрийн хэлбэрээр хохирогчийн өрийг нэмэгдүүлэх буюу өрийн дарамтаар хохирогчийн сэтгэл санаанд нөлөөлж, өрөө төлөх аргагүй болсны улмаас бэлгийн мөлжлөгт өртөхийг ойлгоно.

Хохирогчийн мэдлэггүй, биеэ хамгаалах чадваргүй эсхүл тусламж авахад хүндрэлтэй байдлыг ашиглах гэдэг нь хохирогчийг хууль бусаар хил нэвтэрсэн, хууль бусаар оршин суудаг, хэлний бэрхшээлийн улмаас мэдлэггүй, биеэ хамгаалах чадваргүй эсхүл тусламж авахад хүндрэлтэй эмзэг байдлыг ашиглан өөрийн хүсэл зоригийн эсрэг бэлгийн харьцаанд оруулах, үйлчилгээ үзүүлэхийг албадсан байхыг ойлгоно.¹²¹

б. Хүн худалдаалах гэмт хэрэг

Энэ гэмт хэргийн шинжийг дээр дурдсан Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн тодорхойлолт агуулгын хүрээнд ойлгоно.

Хүнийг мөлжих зорилгоор хүчирхийлэх, заналхийлэх, сүрдүүлэх, хорих, хяналт тавих, мансууруулах, гипноз, хууран мэхлэх, хохирогчийн мэдлэггүй, биеэ хамгаалах чадваргүй эсхүл тусламж авахад хүндрэлтэй байдлыг ашиглаж, эсхүл бусад төстэй аргаар элсүүлсэн, худалдсан, барьцаалсан, тээвэрлэсэн, шилжүүлсэн, хүлээн авсан, орогнуулсан, нуусан, зуучилсан, орон байраар хангасан бол 5 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэж, торгоно.¹²² Энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол бүх насаар нь хорих ял шийтгэх эсхүл 7 жилээс дээш хугацаагаар хорих ялаар шийтгэж, торгоно. Харин хохирогчийн эрүүл мэндэд хүнд гэмтэл учирсан бол 3-10 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэж, торгоно.¹²³

Дээрх гэмт хэргийг мөлжих зорилгоор 18 насанд хүрээгүй хүний эсрэг үйлдсэн бол 7 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэж, торгоно. Энэ гэмт хэргийн улмаас

хохирогчийн эрүүл мэндэд хүнд гэмтэл учирсан бол 5-12 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэж, торгоно.¹²⁴

4.4 БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

Бүгд Найрамдах Солонгос Улс /цаашид “БНСУ” гэх/-ын гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчинд эрүүгийн хуулиас гадна гэмт хэрэг, ял шийтгэлийг зохицуулсан бусад тусгай хууль үйлчилдэг бөгөөд эрүүгийн хуульд заагаагүй гэмт үйлдэл, хүндрүүлэх шинж, хэрэг хянан шийдвэрлэх онцгой журам зэргийг хуульчилдаг байна.¹²⁵ Энэ нь эрүүгийн хуульд шууд нэмэлт, өөрчлөлт оруулахаас сэргийлдэг хэмээн хууль тогтоогчид үздэг. Иймд тус улсад хүн худалдаалах гэмт хэргийг Эрүүгийн хууль (1953), Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогчдыг хамгаалах тухай хууль (2021) болон бусад тусгай хуулиар¹²⁶ өргөн хүрээнд зохицуулсан байдаг.

2013 онд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан 31 дүгээр бүлэгт “хүн худалдаалах” гэмт хэргүүдийг нэгтгэн тусгасан бөгөөд хүн худалдаалах үндсэн гэмт хэргийг **зорилго ба үйлдлийн нэгдэлд** томъёолон 289 дүгээр зүйлд хуульчилсан байна.

289 дүгээр зүйл. Хүн худалдаалах¹²⁷

- (1) Бусдыг худалдсан, худалдан авсан бол 7 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- (2) Бусдыг зүй бус үйлдэлд татан оролцуулах, **бэлгийн харьцаанд оруулах**, гэрлүүлэх, эсхүл ашиг олох зорилгоор худалдсан, худалдан авсан бол 1-10 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- (3) Бусдыг хөдөлмөрийн мөлжлөгт оруулах, **бэлгийн зорилгоор хүнийг худалдаалах, бэлгийн мөлжлөг**, эсхүл эд эрхтнийг нь авах зорилгоор худалдсан, худалдан авсан бол 2-15 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- (4) Бусдыг БНСУ-аас гадагш тээвэрлэх зорилгоор худалдсан, худалдан авсан эсхүл БНСУ-аас гадна худалдан авсан хүнийг тээвэрлэсэн этгээдэд дээрх заалт адил үйлчилнэ.

292 дугаар зүйл. Хулгайлагдсан (англ. Kidnapped, Abducted), худалдаалагдсан эсхүл тээвэрлэгдсэн хүнийг хүлээж авах, орогнуулах

- (1) 287-289 дүгээр зүйлд заасан аль нэг гэмт хэргийн хохирогчийг **хүлээн авсан эсхүл орогнуулсан** бол 7 жил хүртэлх хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.
- (2) 287-289 дүгээр зүйлд заасан аль нэг гэмт хэргийг үйлдэх зорилгоор бусдыг **элсүүлсэн, шилжүүлсэн эсхүл хүлээлгэн өгсөн** бол энэ зүйл үйлчилнэ.

289 дүгээр зүйлд заасан хүн худалдаалах үндсэн гэмт хэргийг хүнийг **худалдсан, худалдан авсан**; бэлгийн зорилгоор хүнийг худалдаалах; бусдыг зүй бус үйлдэлд татан оролцуулах; бэлгийн харьцаанд оруулах, гэрлүүлэх, бэлгийн мөлжлөг, хөдөлмөрийн мөлжлөгт оруулах, эд эрхтнийг нь авах, гадагш тээвэрлэх зорилгоор худалдсан худалдан авсан буюу уг гэмт хэргийн мөлжлөгийн хэлбэрийн үр дүнг хамруулсан үйлдлийг хуульчилсан байна.¹²⁸ 292 дугаар зүйлд хүн худалдаалах гэмт хэргийг үйлдэхээс өмнөх буюу хүлээн авсан, орогнуулсан, элсүүлсэн, тээвэрлэсэн, хүлээлгэсэн өгсөн зэрэг үйл явцыг хамруулсан үйлдлийг хуульчилжээ.

Хүн худалдаалах гэмт хэрэг нь “бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөг, зүй бус үйлдэлд татан оролцуулах, бэлгийн харьцаанд оруулах, гэрлүүлэх, эсхүл ашиг олох, эд эрхтнийг нь авах” зорилгоор үйлдэгдэх бөгөөд гэмт хэргийн үйлдлийн шинжид “худалдах, худалдан авах, тээвэрлэх” үйлдлүүд хамаарна. Уг гэмт хэргийн шинжийг дараах агуулгаар хуульчилсан байна. Үүнд:

Субъектив тал: гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдсэн байна.

Объектив тал:

- Бусдыг санаатай “худалдах, худалдан авах” үйлдэл хийсэн;
- Бусдыг “зүй бус үйлдэлд татан оролцуулах, бэлгийн харьцаанд оруулах, гэрлүүлэх, эсхүл ашиг олох” зорилгоор “худалдах, худалдан авах” үйлдэл хийсэн.
- Бусдыг “хөдөлмөрийн мөлжлөгт оруулах, бэлгийн” зорилгоор “худалдаалсан” эсхүл “бэлгийн мөлжлөг”, эсхүл “эд эрхтнийг нь авах” зорилгоор худалдсан, худалдан авсан.
- Бусдыг “БНСУ-аас гадагш тээвэрлэх” зорилгоор “худалдсан, худалдан авсан” эсхүл БНСУ-аас гадна худалдан авсан хүнийг тээвэрлэсэн.

287 дугаар зүйл. (Хүүхэд хулгайлах (англ. Kidnapping or abduction))

Насанд хүрээгүй хүнийг заналхийлэх, хүч хэрэглэх, албадлагын бусад хэлбэрээр, эсхүл залилан мэхлэх, хууран мэхлэх, эсхүл уруу татах замаар өөрийн болон гуравдагч этгээдийн эрхшээлд оруулж, эрхшээлдээ байлгасан бол 10 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ.

288 дугаар зүйл. Зүй бус үйлдэл хийлгэх зорилгоор хүн хулгайлах (англ. Kidnapping, abduction)¹²⁹

- (3) Хүнийг бэлгийн харьцаанд оруулах, гэрлүүлэх, ашиг олох, зүй бус үйлдэлд татан оролцуулах зорилгоор заналхийлэх, хүч хэрэглэх болон албадлагын бусад хэлбэрээр, эсхүл залилах, хууран мэхлэх, уруу татах замаар өөрийн болон гуравдагч этгээдийн эрхшээлд оруулж, эрхшээлдээ байлгасан бол 1-10 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- (4) Хүнийг хөдөлмөрийн мөлжлөгт оруулах, бэлгийн зорилгоор худалдаалах, бэлгийн мөлжлөг эсхүл эд эрхтнийг нь авах зорилгоор заналхийлэх, хүч хэрэглэх болон албадлагын бусад хэлбэрээр, эсхүл залилах, хууран мэхлэх, уруу татах замаар өөрийн болон гуравдагч этгээдийн эрхшээлд оруулсан, эрхшээлдээ байлгасан бол 2-15 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- (5) Бусдыг БНСУ-аас гадагш тээвэрлэх зорилгоор заналхийлэх, хүч хэрэглэх болон албадлагын бусад хэлбэрээр, эсхүл залилах, хууран мэхлэх, уруу татах замаар өөрийн болон гуравдагч этгээдийн эрхшээлд оруулсан, эрхшээлдээ байлгасан эсхүл БНСУ-аас гадна худалдаалагдсан хүнийг тээвэрлэсэн этгээдэд дээрх заалт нэгэн адил үйлчилнэ.

Хүн худалдаалах үндсэн гэмт хэрэгт мөлжлөгийн зорилгоор худалдах, худалдан авах үйлдлийг хуульчилсан бол Эрүүгийн хуулийн 287, 288 дугаар зүйлд гэмт хэргийн хохирогчид тулгуурлан мөлжлөгийн зорилгоор тодорхой үйлдлийн арга

буюу заналхийлэх, хүч хэрэглэх болон албадлагын бусад хэлбэрээр, эсхүл залилах, хууран мэхлэх, уруу татах замаар өөрийн болон гуравдагч этгээдийн эрхшээлд оруулж, эрхшээлдээ байлгасан үйлдлийг хувааж тусгасан байна.

Түүнчлэн янз бүрийн хэлбэрээр мөлжих зорилгоор хүн худалдах, худалдан авах гэмт хэргийн шинжийг зорилго, үйлдлийн нэгдлээр томъёолсон бол мөн дээрх зорилгоор эрхшээлдээ оруулж, эрхшээлдээ байлгах гэмт хэргийн шинжийг үйлдэл, арга, зорилго гурван элементийн нэгдлээр тодорхойлсон байна.

Ийнхүү дээрх хүн худалдаалах, худалдан авах болон эрхшээлдээ оруулж, эрхшээлдээ байлгах гэмт хэргийн улмаас хохирогчийн эрүүл мэнд, биед гэмтэл учирсан бол 3-25 жил, гэмтэл учруулахад хүргэсэн бол 2-20 жил, хохирогчийг алсан бол цаазаар авах эсхүл тодорхой бус хугацаагаар буюу 7 жилээс доошгүй хугацаагаар, үхэлд хүргэсэн бол цаазаар авах эсхүл тодорхой бус хугацаагаар буюу 5 жилээс доошгүй хугацаагаар хорих ял шийтгэнэ.¹³⁰

Хүн худалдаалах гэмт хэргийг эрүүгийн хуулийн нэг бүлэгт цогц байдлаар тусгахдаа бэлгийн харьцаанд оруулах, бэлгийн мөлжлөг, бэлгийн зорилгоор хүнийг худалдаалахдаа тодорхой үйлдэл, үйлдлийн арга ашиглаж эрхшээлдээ оруулсан, байлгасан эсхүл дээрх зорилгод хүрсэн эсэхээр ангилж хуульчилсан байна.

4.5 КАНАД УЛС

Канад Улс 2002 онд Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцын нэмэлт болох “Хүн ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай” протоколд нэгдэн орж хил дамнуулан хүн худалдаалах гэмт хэргийг Цагаачлал, дүрвэгсдийг хамгаалах тухай хууль (2001)-д тусгажээ.¹³¹ Улмаар 2005 онд Эрүүгийн хууль (1892)-д нэмэлт, өөрчлөлт оруулж хүн худалдаалахад хамаарах бусад гэмт хэргийг хуульчилснаар уг гэмт хэргийг улс дотор үйлдэгдэж болохыг хүлээн зөвшөөрсөн байдаг.¹³²

1) Цагаачлал, дүрвэгсдийг хамгаалах тухай хууль /цаашид “ЦДХтХ” гэх/

118 дугаар зүйл. Хүн худалдаалах гэмт хэрэг

(1) Мэдсээр байж хулгайлах, залилан мэхлэх, хууран мэхлэх, хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, албадах аргаар нэг ба түүнээс дээш хүнийг Канад улсад нэвтрүүлэхээр зохион байгуулахыг хориглоно.

(2) “Зохион байгуулах” гэж энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зорилгоор хохирогчийг элсүүлэх, тээвэрлэх, Канад улсад нэвтэрсний дараа хүлээн авах, орогнуулах үйл ажиллагааг ойлгоно.

Ял шийтгэл:

120 дугаар зүйл. Энэ хуулийн 118 дугаар заалтад заасныг зөрчсөн бол хүнд гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож торгох эсхүл бүх насаар хорих эсхүл эдгээр ялыг хамтад нь оногдуулна.

Хүндрүүлэх үндэслэл:

121 дүгээр зүйл. Шүүх дараах нөхцөл байдлыг харгалзаж 120 дугаар зүйлд заасны дагуу ял шийтгэнэ. Үүнд:

- а) Гэмт хэргийн улмаас хүний биед гэмтэл учруулсан, үхэлд хүргэсэн эсхүл хүний амь нас, аюулгүй байдалд хохирол учруулсан;
- б) Гэмт бүлэгт давуу байдал, ашиг олгох зорилгоор, бүлэглэлийн заавраар эсхүл бүлэглэлтэй холбоотойгоор үйлдсэн;
- в) Ашиг олсон эсэхээс үл хамааран гэмт хэргийг ашгийн төлөө үйлдсэн; болон
- д) Гэмт хэрэг үйлдсэний улмаас ажил, эрүүл мэндийн байдал, бэлгийн мөлжлөг үйлдэх замаар хүнийг хүндээр гутаан доромжилсон.¹³³

“Олон улсын хүн худалдаалах гэмт хэрэг” гэж хохирогчийг цагаачлалын статусаас үл хамааран олон улсын хилээр дамжуулан худалдаалах үйл явцад оруулахыг хэлэх ба хууль ёсны эсхүл хууль бусаар хил нэвтэрсэн эсэх нь хамааралгүй.¹³⁴ Энэ гэмт хэрэг нь зөвхөн тус улсад нэвтрүүлж хүн худалдаалах шинжээр хязгаарлагдаж буй учир “үндэстэн дамнасан хүн худалдаалах” гэмт хэргийн зохицуулалт гэж үздэг.¹³⁵ Гэмт хэргийн шинж:

Субъектив тал: “тухайн гэмт үйлдлийг *мэдсээр байж хийсэн*” хийсэн байна.

Объектив тал: Хохирогчийг “хулгайлах, залилан мэхлэх, хууран мэхлэх, хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, албадах” аргаар Канад улсад нэвтрүүлэхээр “зохион байгуулсан буюу элсүүлсэн, тээвэрлэсэн, хүлээн авсан, орогнуулсан” үйлдэл хийснээр объектив талын шинж хангагдана.¹³⁶ Мөн Канад Улсад ирсний дараа хүлээн авсан, орогнуулсан үйлдэл хамаарна.¹³⁷

II) Эрүүгийн хууль (1892)-ийн “Хувь хүний болон нэр хүндийн эсрэг гэмт хэрэг” бүлгийн хүн худалдаалахад хамаарах бусад гэмт хэргүүд

а. Хүн худалдаалах гэмт хэрэг

279.01 (1) Мөлжих эсхүл мөлжлөгийг дэмжих зорилгоор хүнийг *элсүүлсэн, тээвэрлэсэн, шилжүүлсэн, хүлээн авсан, тогтоон барьсан, нуусан эсхүл орогнуулсан* эсхүл *үйл хөдлөлд нь хяналтаа тогтоосон, чиглүүлсэн, нөлөөлсөн* бол хүнд гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож дараах хариуцлагыг хүлээлгэнэ.

- е) Энэ гэмт хэргийг үйлдэх үедээ хүн хулгайлсан, хүний биед ноцтой халдсан, бэлгийн хүчирхийлэл үйлдсэн эсхүл хүнийг үхэлд хүргэсэн бол 5 жилээс бүх насаар хорих ял шийтгэнэ; эсхүл
- ф) Дээрхээс бусад тохиолдолд 4-14 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Зөвшөөрөл

(2) Хохирогч зөвшөөрөл өгсөн эсэх нь энэ зүйлийн 1 дэх хэсгийн үйлчлэлд хамаарахгүй.

Нотлох баримтаар үнэлэх таамаглал¹³⁸

(3) Хохирогчтой байнга хамт байдаг эсхүл хамтран амьдардаг мөлжлөгт өртөөгүй этгээд өөрийгөө гэм буруугүй болохыг нотолж чадахгүй бол түүнийг энэ зүйлийн 1 дэх хэсэг болон 279.01(1) дэх хэсэгт заасан мөлжих эсхүл мөлжлөгийг дэмжих зорилгоор хохирогчийн үйл хөдлөлд хяналтаа тогтоосон, чиглүүлсэн эсхүл нөлөөлсөнд тооцно.¹³⁹

Канад Улсын Эрүүгийн хуулийн 279.01 дүгээр зүйлд заасан хүн худалдаалах гэмт хэргийн үндсэн шинжийг үйлдэл ба зорилгын нэгдэлд томъёолжээ. Тодруулбал:

Үйлдэл: Хүнийг “элсүүлэх, тээвэрлэх, шилжүүлэх, хүлээн авах, тогтоон барих, нуух, орогнуулах, үйл хөдөлгөөнд хяналтаа тогтоох, чиглүүлэх, нөлөөлөх” үйлдлүүд хамаарах бөгөөд гэмт этгээд нь мөлжих эсхүл мөлжлөгийг дэмжих зорилгоор эдгээр үйлдлүүдийн аль нэгийг хийснээр хүн худалдаалах гэмт хэргийн объектив талын шинж хангагдана.¹⁴⁰

Мөн протоколд тодорхойлсон хүн худалдаалах гэмт хэргийн объектив талын шинжид заагаагүй “**үйл хөдлөлд хяналтаа тогтоох, чиглүүлэх, нөлөө үзүүлэх**” үйлдлүүдийг нэмж хуульчилсан¹⁴¹ бөгөөд эдгээр үйлдлүүд нь хүн худалдаалах гэмт хэрэг болон арилжааны бэлгийн үйлчилгээний хоорондын ялгааг бүдгэрүүлдэг гэх шүүмж байдаг ажээ.¹⁴² Учир нь тус шинжүүдийг хуульчлахдаа Эрүүгийн хуулийн 212 (1) дүгээр зүйлийн (h) хэсэгт заасан “ашиг олох зорилгоор биеэ үнэлэгчид хяналт тогтоох” гэмт хэргээс үлгэрчилсэн байдаг. Уг заалтад “ашиг олох зорилгоор тодорхой нэг этгээдтэй эсэхээс үл хамааран хохирогчийг биеэ үнэлэхэд туслах, өдөөн хатгах, албадах замаар хүний үйл хөдөлгөөнд хяналтаа тогтоосон, чиглүүлсэн эсхүл нөлөөлсөн бол биеэ үнэлэхэд татан оролцуулсан гэм буруутайд тооцно” хэмээн хуульчилсан байжээ.¹⁴³

Зорилго: “Мөлжих” эсхүл “мөлжлөгийг дэмжих” зорилготой¹⁴⁴ байх бөгөөд гэмт этгээд нь тухайн гэмт үйлдлийг хийсний үр дүнд мөлжлөг бий болно гэдгийг гарцаагүй мэдэж байдаг. Гэсэн хэдий ч хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэнд тооцоход мөлжлөг бодитоор үйлдэгдсэн байх шаардлагагүй.

Мөлжих, мөлжлөгийг дэмжих “**зорилгоор**” (англ. *for the purpose of*) гэдэг нь хүн худалдаалах гэмт хэргийн субъектив талын шинжийг илэрхийлэх бөгөөд хориглосон үр дагаварт чиглэсэн хүсэл зориг, түүнийг бий болно гэсэн мэдэх шинжийг илэрхийлнэ.¹⁴⁵

ЦДХтХ-д заасан хүн худалдаалах гэмт хэрэгтэй харьцуулан үзвэл 279.01 дүгээр зүйлд заасан хүн худалдаалах гэмт хэрэг нь объектив талын шинжээрээ ялгагдана. Тодруулбал, хүн худалдаалах гэмт хэрэгт дээрх заалтын дагуу хохирогчийг заавал нэг газраас нөгөө рүү зөөж тээвэрлэсэн байх шаардлагагүй бөгөөд үйл хөдлөлд нь хяналтаа тогтоосноор уг гэмт хэргийн үйлдлийн шинжийг хангасан гэж үзнэ.¹⁴⁶

Дотоодын хүн худалдаалах гэмт хэрэг гэдэг нь хохирогчийн эрх зүйн байдлаас үл хамааран Канад улс дотор хүн худалдаалж буй бүхий л үйл явц дахь тохиолдлыг хамааруулан ойлгоно.¹⁴⁷

Хүн худалдаалах гэмт хэрэг шинжийн зарим нэр томъёог хэрхэн тайлбарласныг дараах хэсэгт авч үзэв. Үүнд:

“**Мөлжлөгийг дэмжих зорилгоор**” гэж гэмт этгээд өөр хэн нэгэн хохирогчийг мөлжих санаатай үйлдэл хийсэн гэж үзэж байгаа тохиолдолд хэрэглэнэ. Дэмжих гэдэг нь бий болоход туслах, хялбар болгох, магадлалыг нэмэгдүүлэх, дэмжлэг үзүүлэх гэсэн утгыг илэрхийлнэ.¹⁴⁸

“Орогнуулах” гэсэн нэр томъёог Онтарио мужийн давж заалдах шатны шүүхээс “ил, далд эсэхээс үл хамааран орон байраар хангах (англ.*provision of shelter*)” гэж тайлбарлажээ.¹⁴⁹

“Хянах” гэдэгт хяналтад байгаа хүний сонголтыг ихээхэн хязгаарласан үйлдлүүдийг агуулдаг. Хяналт гэдэг нь ердийн утгаараа хэн нэгний сонголтыг хязгаарлах замаар хүссэн зүйлээ хийлгэх гэсэн үг юм.¹⁵⁰ **Хяналт нь заавал бие махбодын, бүрэн дүүрэн, байнгын, туйлын шинжтэй байх шаардлагагүй бөгөөд сэтгэл зүйн дарамтыг ч хамруулан ойлгоно.**¹⁵¹

“Чиглүүлэх” гэж дүрэм журам, байр байдлыг тогтоох замаар бусдын үйл хөдлөлийг удирдаж байвал үүнийг чиглүүлсэн гэж үзнэ.¹⁵² Өөрөөр хэлбэл, чиглүүлэх нь хохирогчид дагаж мөрдөх дүрэм журам тогтоох явдал юм.¹⁵³

“Нөлөөлөх” нь хянах болон чиглүүлэхээс хязгаарлалтын түвшин харьцангуй сул боловч тухайн хүний зан төлөвт нөлөөлөх үйлдлүүдийг агуулдаг. Үүнд хэн нэгэнд туслах, урамшуулах, ямар нэгэн зүйл хийхийг албадах зорилгоор хийсэн бүх үйл орно.¹⁵⁴ Өөр нэг эх сурвалжид тайлбарласнаар “279.01(1) дүгээр зүйлд заасан зорилгоор үйл хөдлөлд нөлөөлөх нь “хяналт тогтоох” үйлдлээс албадлагын түвшин сул байдаг бөгөөд хүний үйл хөдлөлд нөлөөлөх ямар ч зүйлсийг хамааруулж болно. Өөрөөр хэлбэл “нөлөөлөх” нь тухайн хүний чөлөөт хүсэл зоригийг хэрэгжүүлэх боломж олгохын зэрэгцээ нөлөөлөл үзүүлж болно. Үүнд хүсэл зоригийг өдөөх, өөрчлөх, нөлөөлөхийн тулд хийсэн бүх зүйл хамаарч болно. Нөлөөлөх бол санал гаргаж түүнийгээ дагахыг ятгахтай адил”¹⁵⁵ гэжээ.

Эрүүгийн хуулийн 279.04 дүгээр зүйлд “мөлжлөг”-ийн ухагдахууныг тодорхойлон хуульчилжээ.

279.04 (1) Бусдыг мөлжих гэдэг нь энэ хуулийн 279.01-ээс 279.03 дахь заалтад заасан зорилгоор хохирогч албадан хөдөлмөрлөх, үйлчилгээ үзүүлэхээс татгалзвал түүний эсхүл хамаарал бүхий хүний аюулгүй байдалд гэмт этгээд заналхийлэх эрсдэлтэй гэсэн итгэлийн үр дүнд дээрх үйлдлийг хийсэн бол бусдыг мөлжсөнд тооцно.

Хүчин зүйлс

(2) Шүүх шүүгдэгчийг (1) дахь заалтад заасны дагуу бусдыг мөлжсөн гэдгийг тогтооход дараах хүчин зүйлсийг харгалзан үзнэ. Үүнд:

Хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн эсхүл бусад албадлагын арга хэрэгсэл ашигласан;

Хууран мэхэлсэн; эсхүл

Итгэл эвдсэн, эрх мэдлээ урвуулан ашигласан.

Хүн худалдаалах гэмт хэрэг нь мөлжлөгт оруулж үйлдсэн байхыг шаарддаггүй боловч хохирогчийг үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрүүлэхийн тулд албадлага хэрэглэсэн байхыг шаарддаг.¹⁵⁶ Мөлжлөг нь гэмт хэрэг биш бөгөөд хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэх үйлдлийн аргыг хуульчилсан байна.

Кейс №.3: R. v. Gallone, 2019 ONCA 663¹⁵⁷

Үйл баримт: 18 настай А нь гэрээсээ хөөгдөж, халамж авдаг байсан бөгөөд тэрээр тайчих клубт бүжигчнээр ажилд орж Б гэх эмэгтэйтэй танилцаж хамтран амьдарч эхэлсэн. Улмаар Б нь А-д дарамт үзүүлж, түүний бэлгийн харьцаанд орсон зураг бүхий зар сурталчилгааг "васкраге" цахим хуудаст байршуулж, орон сууцандаа биеийг нь үнэлүүлэн орлогыг нь авдаг байжээ.

Б-г эрүүгийн хуульд заасан хүн худалдаалах гэмт хэрэг (279.01(1)), Ашиг сонирхлын зорилгоор бэлгийн үйлчилгээг сурталчлах (286.4-р зүйл) зэрэг бусад гэмт хэрэгт буруутгаж шүүхэд шилжүүлсэн.

Анхан шатны шүүх: "хүн худалдаалах гэмт хэрэгт заасан үйлдлүүдийг хамтад нь буюу нэгтгэж тайлбар хийх ёстой" гэж үзэж тангарагтны шүүхийг чиглүүлсэн. Түүнчлэн "хяналтаа тогтоох" шинж нь хүн худалдаалах гэмт хэргийн төв цэг бөгөөд үүнийг нотолсон байх ёстой. Хяналтаа тогтоох гэдэг нь хяналтад буй хүнийг өчүүхэн сонголттой үлдээж, түрэмгийлэх, ноёрхох байдлыг илэрхийлэх бөгөөд энэ нь хүн худалдаалах гэмт хэргийн гол шинж юм хэмээн тайлбарлаж, шүүгдэгчийг цагаатгаж шийдвэрлэсэн.

Кровны зүгээс:¹⁵⁸ Анхан шатны шүүх хуулийг буруу тайлбарлан хэрэглэж, тангарагтны шүүхийг буруу удирдан чиглүүлсэн хэмээн давж заалдах шатны шүүхээр хэлэлцүүлэхээр дараах агуулга бүхий хүсэлт гаргасан. **Хүн худалдаалах гэмт хэргийн ACTUS REUS буюу объектив талын шинж нь уг гэмт хэргийн үйлдлүүдийн аль нэгийг нь хийснээр хангагдах бөгөөд заавал хяналтаа тогтоосон байдлыг давхар нотлох шаардлагагүй юм.** Учир нь тус заалт дахь үйлдлүүд нь нэгдмэл шинжтэй биш бөгөөд сонгож тайлбарлагдана. (англ. *dis-junctive*) Тухайлбал мөлжлөгийн зорилгоор хүнийг элсүүлсэн үйлдэл хийхэд объектив талын шинж хангагдсан гэж үзнэ. Энэ нь эмзэг бүлгийн хүмүүсийг мөлжих зорилготой аливаа үйлдлийг гэмт хэрэгт тооцоход чиглэсэн хүн худалдаалах гэмт хэргийн зорилготой нийцнэ. Түүнчлэн «үйл хөдлөлд нөлөөлөх» нь «чиглүүлэх»-ээс албадлагын хэмжээ сул байна. Цаашлаад хүн худалдаалах гэмт хэрэг нь хохирогчийг бодитоор мөлжсөн байхыг шаарддаггүй бөгөөд гэмт этгээд нь хохирогчийг мөлжих зорилготой хууль бус үйлдлүүд хийснийг нотолсноор хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэнд тооцно гэх агуулга бүхий хүсэлт гаргасан.

Давж заалдах шатны шүүх: Кровны хүсэлтийг үндэслэлтэй хэмээн санал нэгдэж, давж заалдах шатны шүүхээр хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.

Канад улсын хувьд хяналтаа тогтоох нь хүн худалдаалах гэмт хэргийн үйлдлийн нэг арга бөгөөд манай улсаас ялгаатай нь заавал хяналтаа тогтоосон байх шинжийг шаардахгүй буюу үргэлжилсэн процессын үйлдэлд оролцсоноор хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэнд тооцно.

б. 18 насанд хүрээгүй хүнийг худалдаалах гэмт хэрэг

279.011 (1) Мөлжих эсхүл мөлжлөгийг дэмжих зорилгоор хүнийг элсүүлсэн, тээвэрлэсэн, шилжүүлсэн, хүлээн авсан, тогтоон барьсан, нуусан эсхүл орогнуулсан эсхүл үйл хөдлөлд нь хяналтаа тогтоосон, чиглүүлсэн, нөлөө үзүүлсэн бол хүнд гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож дараах хариуцлагыг хүлээлгэнэ.

г) Энэ гэмт хэргийг үйлдэх үедээ хүн хулгайлсан, хүний биед ноцтой халдсан, бэлгийн хүчирхийлэл үйлдсэн, хүнийг үхэлд хүргэсэн бол 6 жилээс бүх насаар хорих ял шийтгэнэ; эсхүл

h) Дээрхээс бусад тохиолдолд 5-14 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Зөвшөөрөл

(2) Хохирогч зөвшөөрөл өгсөн эсэх нь энэ зүйлийн 01 дүгээр хэсгийн үйлчлэлд хамаарахгүй.¹⁵⁹

18 насанд хүрээгүй хүнийг худалдаалах гэмт хэрэг нь 279.01 дүгээр зүйлийн (1) дэх хэсэгт заасан хүн худалдаалах үндсэн гэмт хэргээс зөвхөн субъектив талын шинжээрээ ялгагдах бөгөөд **гэмт этгээд нь хохирогчийг 18 насанд хүрээгүй хүүхэд гэдгийг мэдэж байдаг**. Хэрэв мэдэж байсан эсэхэд үндэслэл бүхий эргэлзээ байвал 279.01 дүгээр зүйлийн (1) дэх хэсэгт заасан гэмт хэргээр хөнгөрүүлэн зүйлчилж болно.¹⁶⁰

III) Бэлгийн мөлжлөг

Канад Улс 1886 онд 12 насанд хүрсэн боловч 16 насанд хүрээгүй хүнийг бэлгийн харилцааны зорилгоор уруу татах, 18 насанд хүрээгүй хүнийг гэрлэх амлалтаар уруу татах үйлдлүүдийг тус тус гэмт хэрэгт тооцож байсан бөгөөд хожмоо «уруу татах» шинжийг «бэлгийн харилцаанд орох» хэмээн өөрчилж насны доод хязгаарыг 14 нас болгосон байдаг.

Үүний дараа 1984 онд гарсан “Хүүхэд залуучуудын эсрэг бэлгийн гэмт хэрэгтэй тэмцэх хорооны тайлан” (Бадглигийн тайлан)-д хүүхдийн эсрэг бэлгийн гэмт хэрэгтэй тэмцэх зөвлөмжүүдийг өгсөн нь дээрх “уруу татах” гэмт хэргийг хасан, одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй эрүүгийн хуулийн 5 дугаар бүлэг дэх “Бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргүүд” батлагдах үндэс болжээ. Тухайлбал тайлангийн ес дүгээр зөвлөмжид итгэлцлийн холбоо хамааралд багтах этгээдийг тодорхойлохыг санал болгосон бөгөөд энэ нь хожим бэлгийн мөлжлөг зэрэг хэд хэдэн гэмт хэргийн шинжид хуульчлагдсан. Ингэснээр Канад улсад насанд хүрсэн этгээд итгэлийн харилцаагаа ашиглаж 14 насанд хүрсэн боловч 18 нас хүрээгүй хүүхэдтэй бэлгийн холбоо харьцаатай байхыг “бэлгийн мөлжлөгийн” гэмт хэрэг хэмээн томъёолсон байна.¹⁶¹

Бэлгийн мөлжлөг нь бэлгийн хүчирхийллийн хамгийн хүнд хэлбэрийн нэгт тооцогддог.¹⁶² Тиймээс тус зохицуулалт нь эмзэг бүлгийн залуучуудыг насанд хүрэгчдийн мөлжлөг, албадлагын зан үйлээс хамгаалахад чиглэдэг байна.¹⁶³

Бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг

153 (1) Итгэл эвдэж, бүрэн эрх, хамаарал бүхий харилцааг ашиглаж залуу хүнийг дараах байдлаар мөлжсөн бол бэлгийн мөлжлөг үйлдсэн гэм буруутай тооцно.

- а) Бэлгийн зорилгоор залуу хохирогчийн биеийн аль нэг хэсэгт шууд болон шууд бусаар биет зүйл ашиглан эсхүл хохирогчийн биеийн аль нэг хэсгээр өөрт нь хүрсэн; эсхүл
- б) Бэлгийн зорилгоор залуу хохирогчийг аливаа этгээдийн биед шууд болон шууд бусаар биет зүйл ашиглан эсхүл биеийн аль нэг хэсгээр хүрэхээр өдөөн хатгасан, санал тавьсан, зөвлөсөн
- (1.1) Залуу хохирогчтой харилцаа бүхий этгээдийг шүүгч дараах нөхцөл байдлыг харгалзан дүгнэж болно. Үүнд:
 - а) Хохирогчийн нас;
 - б) Гэмт этгээд болон хохирогчийн насны зөрүү;
 - в) Урьдын харилцаа; болон
 - д) Хохирогчид үзүүлсэн нөлөө, тогтоосон хяналтын хэр хэмжээ.

(2) Залуу хүн гэдэгт 16 насанд хүрсэн боловч 18 насанд хүрээгүй хүнийг ойлгоно.¹⁶⁴

Эрүүгийн хариуцлага

(1.1) дэх заалтад заасан гэмт хэргийг үйлдсэн гэм буруутай этгээдийг

- а) Хүнд гэмт хэрэг үйлдсэнд тооцож 1-14 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ; эсхүл
- б) Хөнгөн гэмт хэрэг үйлдсэнд тооцож 90 хоногоос 2 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ.

"Итгэл" гэдгийг хүлээн зөвшөөрөгдсөн бодит үнэн эсхүл хүн, эд юмсын шинж чанарт итгэх, найдах гэсэн үгийнх нь үндсэн утгын дагуу тайлбарлах ёстой.¹⁶⁵

Бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг нь гэмт этгээд залуу хохирогчтой итгэлцэл, эрх мэдэл, хамааралт байдлын холбоог далимдуулж бэлгийн шинжтэй үйл ажиллагаанд орох гэмт зан үйлээс сэргийлдэг бол хүн худалдаалах гэмт хэргийн субъект нь хохирогчийг мөлжих, мөлжлөгт дэмжлэг үзүүлэх зорилго бүхий аль ч насны хүн байж болно.¹⁶⁶ Канад Улсын бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг нь бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэрэг биш бөгөөд гэмт этгээд итгэл, бүрэн эрх, хамаарал бүхий харилцааг ашиглан бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийсэн гэмт явдлыг хуульчилсан байна. Өөрөөр хэлбэл, манай улсын бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээс ялгаатай ойлголт юм.

Бүлгийн дүгнэлт: АНУ-д бэлгийн болон боолчлолын зорилгоор үйлдэгдэх хоёр төрлийг хүн худалдаалах гэмт хэрэгт тооцон хуульчилсан. Бэлгийн зорилгоор хүн худалдаалах гэдэгт гэмт этгээд хариу төлбөртэйгөөр хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэх, хуурах, заналхийлэх аргуудыг хэрэглэж бусадтай бэлгийн харьцаанд оруулахыг ойлгодог. Хүчээр хүний биеийг үнэлүүлэх, бэлгийн мөлжлөгт оруулах нь бие даасан гэмт хэргүүд биш бөгөөд хүн худалдаалах гэмт хэргийн шинж, зорилгыг илэрхийлнэ.

Хохирогчийн зорчих эрхийг хязгаарлахаар заналхийлэл үзүүлж болох боловч энэ нь уг гэмт хэрэг үйлдэгдэх зөвхөн нэг арга бөгөөд хүч хэрэглэж, хуурч хүчээр биеийг нь үнэлүүлэхэд заавал энэ шинжийг шаардахгүй. Ялангуяа насанд хүрээгүй хүний биеийг үнэлүүлсэн бол эдгээр аргуудыг хэрэглэхийг шаардахгүй. Насанд хүрээгүй хүнтэй төлбөр төлж бэлгийн харьцаанд орох нь мөн хүн худалдаалах гэмт хэрэгт тооцогдох буюу уг гэмт хэрэгт хариу төлбөр авч хүчээр биеийг нь үнэлүүлсэн, арилжааны шинжтэй бэлгийн үйлдэл хийлгэхээр төлбөр төлсөн этгээд аль аль нь хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцогдоно.

Тус улсын хүүхдийг бэлгийн мөлжлөгт оруулах гэмт хэргийг “хүүхдийн порнограф бэлдэх, тараах, авах хадгалахын тулд хүүхдийг хөлслөх, ятгах зэргээр хүүхэд оролцуулж садар самуун явдлыг сурталчлах үйлдлүүдийн хүрээнд тусад нь хуульчилжээ. Энэ гэмт хэргийн бэлгийн мөлжлөг гэх ойлголт нь хүн худалдаадах гэмт хэргийн мөлжлөгөөс өөр бөгөөд ялын бодлогын хувьд ялгаатай байдаг.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын эрх зүйн хэм хэмжээнүүдэд “Хүн худалдаалах гэмт хэргийг зөвхөн хүнийг худалдах-худалдах авах хэлцлийн хүрээнд бус өргөн хүрээнд тодорхойлохыг буюу худалдаалахаас өмнөх үйлдлийг ч мөн хүн худалдаалах гэмт хэрэгт хамруулахыг зөвлөсөн байдаг. Уг зөвлөмжийг улс орнууд өөр өөрөөр тусгаж иржээ. Тухайлбал Австри улс хүн худалдаалж ашиг олохоос өмнө үйлдлүүд буюу хүнийг мөлжих зорилгоор элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, орогнуулах, хүлээн авахыг хүн худалдаалах гэмт хэргийн бэлтгэл үе шат хэмээн үзэж үүнийг бие даасан гэмт хэрэг байхаар хуульчилсан байдаг. Харин Герман улсад 2016 оноос өмнө хүнийг худалдаж түүнээсээ өөртөө болон гуравдагч этгээдэд ашиг олсныг хүн худалдаалах гэмт хэрэг гэж томьёолж байжээ. Мөн гэмт этгээд хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэхэд хохирогчийг элсүүлсэн, тээвэрлэсэн, дамжуулсан, орогнуулсан, хүлээн авсан этгээдийг хүн худалдаалах гэмт хэрэгт дэмжлэг үзүүлэх гэмт хэрэг байхаар тусад нь хуульчилж, хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн этгээдээс хөнгөн ял шийтгэл оногдуулах бодлоготой байжээ. Гэвч дээрх зохицуулалтууд нь олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцээгүй хэмээн эрдэмтэн, судлаачид шүүмжилж тус улсын эрүүгийн хуулийн хүн худалдаалах гэмт хэргийн хэм хэмжээнд 2016 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан байдаг.

Уг нэмэлт өөрчлөлтөөр хүнийг мөлжлөгт оруулж ашиг олохоос өмнөх үргэлжилсэн процесс үйлдлүүдийг хүн худалдаалах гэмт хэрэгт томьёолсноор олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцжээ. Харин хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэн түүнээсээ ашиг олсныг тусад нь гэмт хэрэг байхаар эрүүгийн хуулийн тусгай ангид заасан байна. Тухайлбал хохирогчийн хувийн болон эдийн засгийн гарцаагүй байдал эсвэл гадаад улсад байгаа улмаас тусламж авах боломжгүй байдлыг ашиглан бусадтай хүчээр бэлгийн харьцаанд оруулсан эсвэл бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийлгэсэн бол үүнийг тусад нь албадан биеийг нь үнэлүүлэх гэмт хэрэг хэмээн үздэг.

Тайвань улсын Эрүүгийн хуульд хүн худалдаалах гэмт хэргийг үйл явц, үр дүнг хамруулсан үйлдлийг нэг зүйл, хэсэгт хуульчлахдаа бэлгийн харилцаанд оруулахыг хамтад тусгасан байна. Эрүүгийн хуульд заасан хүн худалдаалах гэмт хэргийн шинжийг протоколын тодорхойлолттой харьцуулахад хэт явцуу хүрээнд

тодорхойлсон байх боловч Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиар өргөжүүлэн тайлбарладаг. Энэ нь зэрэгцээ эрүүгийн хуультай буюу аливаа гэм хэрэгтэй тэмцэх эрх зүйн үндсийг цогц бүрдүүлэх зорилготой холбоотой. Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг хүн худалдаалах гэмт хэрээс тусад нь хуульчилсан боловч эрүүгийн хариуцлагын хувьд ижилхэн байна. Иймд дээрх хоёр гэмт хэргийн шинжийг тусгайлсан зохицуулалттай хуулиар тайлбарлаж, ялын бодлогыг эрүүгийн хуулиар тодорхойлдог.

БНСУ-ын хүн худалдаалах гэмт хэрэгт хамааралтай хэргүүдийг нэг бүлэгт нэгтгэн хуульчилсан байна. Хүн худалдаалах гэмт хэргийн үндсэн зохицуулалт нь аливаа мөлжлөгт оруулсан буюу уг гэмт хэргийн эцсийн үр дүнг хамруулсан үйлдлийг хуульчилсан. Бусад гэмт хэрэгт үйл явцыг хамруулсан үйлдэл, эрхшээлдээ оруулах, байлгах зэрэг гэмт хэргийг хуульчилжээ.

Канад Улсад хүн худалдаалах гэмт хэргийг хил дамнуулан болон улсын хил дотор үйлдэгдэнэ гэж хоёр хуваасан байна. Тус улсад хүн худалдаалах гэмт хэргийг бэлгийн мөлжлөг болон албадан хөдөлмөрлүүлэх зорилгоор хүнийг элсүүлэх, тээвэрлэх, орогнуулах, үйл хөдлөлд нь хяналтаа тогтоох, чиглүүлэх, нөлөөлөх үйл явцад оруулахыг ойлгох бөгөөд эдгээр үйлдлийн аль нэгийг мөлжих болон мөлжлөгийг дэмжих зорилготой хийснээр объектив талын шинж хангагдана.

Гэмт этгээд нь хохирогчийн зорчих эрхийг хязгаарлаж хохирогчийн үйл хөдлөлд хяналт тогтоох нь хүн худалдаалах гэмт хэргийн үйлдлийн нэг шинжид тооцогддог боловч бусад элсүүлэх, тээвэрлэх зэрэг шинж хангагдсан тохиолдолд зорчих эрхийг хязгаарласан эсэх нь хамааралгүй байна. Өөрөөр хэлбэл, гэмт этгээд мөлжлөгийн зорилгоор хохирогчид аливаа байдлаар хяналтаа тогтоохгүйгээр элсүүлэх, тээвэрлэх зэрэг үйл явцад оролцсоноор хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ.

Канад Улсын Эрүүгийн хуульд бэлгийн мөлжлөг гэх бие даасан гэмт хэрэг байх боловч энэ нь хүн худалдаалах гэмт хэргийн зорилго болон эрүүгийн хуульд тодорхойлсон "мөлжлөг"-ийн ойлголтоос ялгаатай байна. Тодруулбал, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн зорилго нь насанд хүрсэн этгээд хохирогчтой хамаарал бүхий харилцааг ашиглан хийсэн бэлгийн харьцааны шинжтэй гэмт зан үйлийг нийгэмшүүлэхэд чиглэдэг бөгөөд үүнд хүч хэрэглэсэн эсэх нь хамааралгүй байдаг. Харин эрүүгийн хуульд тодорхойлсон мөлжлөг гэдэгт хохирогч гарцаагүй байдлын үүднээс албадан хөдөлмөрлөх, үйлчилгээ үзүүлэх, үзүүлэхээр санал тавьдаг буюу хүн худалдаалах гэмт хэргийн үйлдлийн нэг арга юм.

Нэгтгэн дүгнэхэд, энэхүү судалгаагаар авч үзсэн улс орнууд эрх зүйн тогтолцоо, үзэл баримтлалаасаа хамааран хүн худалдаалах гэмт хэргийг харилцан адилгүй байдлаар хуульчилсан байна. Гэвч (I) хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүнийг худалдаалах гэмт хэргийг хамтад нь буюу нэг зүйлд хуульчлах (АНУ, Тайвань, БНСУ, Канад), эсхүл (II) хүн худалдаалахаас өмнөх үйл явцыг хамруулсан үйлдлийг хүн худалдаалах гэмт хэрэгт тооцож, мөлжлөгт оруулсан үйлдлийг тусад нь гэмт хэрэгт тооцож хуульчилсан нийтлэг зүй тогтол байна. Харин хэрхэн хуульчилснаас

үл хамааран бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэргийн ялын бодлогыг хүн худалдаалах гэмт хэргээс хатуу байх бодлогыг баримталжээ.

Герман улсад үйл явцыг хамруулсан үйлдлийг хүн худалдаалах үндсэн гэмт хэргээр тодорхойлж, үр дүнг хамруулсан буюу албадан биеийг нь үнэлүүлэх гэмт хэрэг, эрх чөлөөг нь хасах замаар мөлжих гэмт хэргийг тусад нь хуульчилсан байдаг. Ийнхүү тусад нь хуульчлахдаа эдгээр гэмт хэргүүдийг үйлдлийн аргаар нь ангилах буюу хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлж үйлдсэн бол эмзэг байдлыг нь далимдуулж биеийг нь үнэлүүлэх, мөлжлөгт оруулж үйлдсэнээс хүнд ял шийтгэнэ. Тодруулбал, хүн худалдаалах гэмт хэргийг энгийн үйлдлийн аргаар үйлдсэн бол 6 сараас 5 жил хүртэл хугацаатай хорих ял оногдуулах бол мөн энэ үйлдлийн аргаар албадан биеийг нь үнэлүүлэх гэмт хэрэгт 6 сараас 10 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан байна.

АНУ, Тайвань, БНСУ улсад үр дүн, үйл явцыг хамруулсан үйлдлийг нэгтгэж эрүүгийн хуулийн нэг бүлэг, нэг зүйлд тусгасан байна. АНУ-ын хувьд бэлгийн болон боолчлолын зорилгоор үйлдэгдэх хоёр төрлийг хүн худалдаалах гэмт хэрэгт тооцон хуульчилсан. Тайвань, БНСУ зэрэг улсад хүн худалдаалах гэмт хэргийн шинжийг протоколын тодорхойлолттой харьцуулбал өргөн хүрээнд тогтоосон байна. Учир нь эдгээр улсууд эрүүгийн хуулиас гадна бусад тусгайлсан хууль тогтоомжоор энэ гэмт хэрэгт хамаарах бусад гэмт хэрэг, тодорхойлолтыг давхар хуульчилсан байдагтай холбоотой. Тайвань улсын Эрүүгийн хуульд хүн худалдсан гэмт хэргийг бусадтай бэлгийн харьцаанд оруулах гэмт хэрэгтэй нэг зүйлд хуульчилсан боловч ялын бодлогын хувьд бэлгийн харьцаанд оруулах нь хүнд буюу хорих ялын хугацаа 2 жилийн зөрүүтэй байна. Тайвань улс үр дүнг хамруулсан үйлдлийг үйлдлийн аргад тулгуурлан хүндрүүлэн шинжээр хуульчилжээ. Өөрөөр хэлбэл, мөлжлөгийг хүч хэрэглэсэн, мансууруулсан эсхүл бусад өөрийнх хүсэл зоригийн эсрэг аргаар үйлдсэн бол тухайн үр дүнд хүрсэн гэмт үйлдлийн хорих ялын хэмжээний тал хувийг нэмж шийтгэдэг. БНСУ-ын хувьд хүн худалдаалах гэмт хэргүүдийг эрүүгийн хуулийн нэг бүлэгт хуульчилсан байна. Тодруулбал, хүн худалдаалах үндсэн гэмт хэргийг хүнийг худалдсан, худалдан авсан, бэлгийн зорилгоор хүнийг худалдаалах, бэлгийн харьцаанд оруулах, бэлгийн мөлжлөгт оруулах хэлбэрийг тусад нь бие даасан гэмт хэрэгт хуульчлаагүй. Ялын бодлогын хувьд мөн дээрх улсуудтай адил бөгөөд хорих ялын хугацааны зөрүү 3 жил, 5 жил байна. Канад улсын хувьд зөвхөн үйл явцад хамаарах үйлдлийг хуульчилсан бөгөөд хүн худалдаалах гэмт хэргийг хохирогчийн насанд тулгуурлан ангилсан байна. Ялын бодлогын хувьд 18 насанд хүрээгүй хүний эсрэг уг гэмт хэргийг үйлдсэн бол хүндрүүлэх буюу ялын интервал 1 жилээр нэмэгдсэн байна. Тус улсад байх хяналт тогтоох, нөлөөлөх зэрэг нь хүн худалдаалах гэмт хэргийг тусад нь хуульчлах оролдлого биш буюу энэ гэмт хэргийг үйлдэх нэг төрлийн үйлдлийн арга хэмээн үздэг.

ДҮГНЭЛТ

Хүн худалдаалах гэмт хэргийн анхны нэгдмэл тодорхойлолтыг улс орнуудын харилцан зөвшилцөлд тулгуурлан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцын нэмэлт болох “Хүн ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай” протоколд тусгажээ. Конвенцыг боловсруулагчид хүнийг хүчирхийллийн шинжтэй арга ашиглан мөлжлөгийн ноцтой нөхцөл байдалд оруулах буюу тийм байдалд байлгахыг хүн худалдаалах гэмт хэрэгт хамаарахаар тодорхойлсон боловч холбогдох шинж, үйлдлийн тайлбарыг тусгаагүйгээс улс орнууд харилцан адилгүй тайлбарлах тохиолдол гардаг байна. Олон улсын эрх зүйн хэм хэмжээнд энэ гэмт хэргийн шинжийг тодорхойлох нарийн шалгуур тогтоох оролдлого нь протоколд нэгдэн орсон аливаа улсад гарах гэмт үйлдлийг хязгаарлах буюу явцууруулах сөрөг талтай байж болох юм. Иймд тодорхойлолтыг хүн худалдаалах гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх уг протоколын зорилгод нийцүүлэн тайлбарлаж хэрэглэхийг зөвлөдөг.

Протоколын тодорхойлолтод хүн худалдаалах гэмт хэргийг зорилго, үйлдэл, үйлдлийн арга буюу гурван элементийн нэгдэлд томьёолсон. Ашиг олох зорилгоор хохирогчийн эрх, эрх чөлөөг ноцтой хязгаарлаж хүсэл зоригийнх нь эсрэг мөлжлөгийн шинжтэй үйлдэл хийсэн, тийм нөхцөл байдалд оруулах үйл явцад оролцсон бол хүн худалдаалах гэмт хэрэгт тооцно. Протоколд нэгдэн орсон улс орнууд энэ гэмт хэргийн мөлжих зорилгод бэлгийн мөлжлөг, хүний биеийг үнэлүүлэх, боолчлох гэх мэт наад захын мөлжлөгийн хэлбэрүүдийг заавал тусгах үүрэг хүлээнэ.

Хүн худалдаалах гэмт хэргийн объектив талд хамаарах үйлдлүүдийг үйл явцыг хамруулсан үйлдэл, үр дүнг хамруулсан үйлдэл хэмээн ялгаж болно. Монгол Улс дээрх протоколд нэгдэн орохоос өмнө хүн худалдаалах гэмт хэргийг тодорхойлох оролдлогыг хийж байжээ. Энэ үед хүн худалдаалах гэмт хэргийг зөвхөн үр дүнг хамруулсан үйлдэл, эсхүл үйл явцыг хамруулсан үйлдлийг хүн худалдаалах гэмт хэрэгт тооцож байсан уламжлалтай. Хожмоо хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт хийсэн боловч протоколын тодорхойлолттой харьцуулахад явцуу хүрээнд тодорхойлсон байна. Хүн худалдаалах гэмт хэргийг олон улсын эх сурвалжид нийцүүлэхэд дөхөм болсон хамгийн томоохон алхам нь 2012 онд баталсан хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль бөгөөд түүнийг дагаж Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулсан явдал юм.

Ийнхүү боловсронгуй болсоор ирсэн хүн худалдаалах гэмт хэргийн зохицуулалтыг 2015 оны Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд аливаа хэлбэрээр мөлжлөгт оруулахаас өмнөх процессын үйлдлүүдийг хуульчилж, үр дүнд нь бэлгийн мөлжлөгт оруулсан үйлдлийг өөр бүлэгт 12.3 дугаар зүйлийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд хуульчилсан байна. НҮБ-аас хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах, нотлоход нарийн ээдрээ төвөгтэй элементүүдээс бүрддэг тул уг гэмт хэргийн зорилгод тодорхойлсон мөлжлөгийн хэлбэрүүдийг эрүүгийн хуульд бие даасан гэмт хэрэгт тооцохыг

зөвлөсөн байдаг. Нөгөөтээгүүр олон улсын эх сурвалжид аль нэг мөлжлөгийн шинж, оногдуулах ялын хэмжээ хязгаарыг хатуу тогтоогоогүй бөгөөд протоколд оролцогч улс оронд илрэх гэмт үйлдлийн онцлогоос шалтгаалан хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх ялын бодлогоо бие даан тодорхойлох эрхтэй. Иймд эрүүгийн хуульд мөлжлөгийн хэлбэрийг тусад нь хуульчилсныг буруутгах үндэслэлгүй юм.

Гэвч 2015 оны Эрүүгийн хуульд биеэ үнэлэхийг зохион байгуулахыг эрүүжүүлээгүйтэй холбоотойгоор бусдыг хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн эсхүл бусад байдлаар эршээлдээ байгааг ашиглан бэлгийн харьцаанд оруулахаар албадсан гэмт үйлдлийг хуульчлах шаардлага практикаас бий болжээ. Иймд хууль тогтоогч 12.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дээрх гэмт үйлдлийг хуульчлахдаа хүн худалдаалах гэмт хэргийн зарим үйлдлийн аргатай давхцуулсныг ялгах зорилгоор зорчих эрхийг хязгаарлахгүйгээр гэх шинжийг тусгасан байна.

Улмаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйлд хоёр өөр гэмт үйлдлийг бэлгийн мөлжлөг хэмээн томъёолон нэг зүйлд хуульчилсан нь хууль хэрэглээний төөрөгдөлд оруулжээ. Дэлгэрүүлбэл, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн үндсэн шинж нь “зорчих эрхийг хязгаарлахгүйгээр» хэмээн заасан тул мөн зүйл, хэсгийн 2 дахь хэсэгт заасан бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэргийн шинжийг хязгаарласан. Ийнхүү хууль хэрэглээний практикт хүн худалдаалах болон бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг зорчих эрхийг хязгаарласан шинжид тулгуурлан ялган зүйлчилж байна. Өөрөөр хэлбэл, шүүхээс өмнөх шатанд цугларсан нотлох баримтад хохирогчийн зорчих эрхийг хязгаарласан үйл баримт тогтоогдсон эсэхээс хамааран аль гэмт хэргээр эцэслэн шийдвэрлэхэд гол нөлөө үзүүлдэг.

Түүнчлэн 2015 оны Эрүүгийн хуулийг хүчин төгөлдөр дагаж мөрдсөнөөс өдгөө хүртэл 12.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгээр шийдвэрлэсэн хэрэг байхгүй тул практикт энэ төрлийн гэмт үйлдэл гарахаа больсон, эсхүл бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг бусад өрсөлдөх хэм хэмжээтэй төсөөтэй хэрэглэж байж болох юм. Иймд бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн шинжийг өөрчлөх зүй ёсны шаардлага тулгарчээ.

Манай улсад хүн худалдаалах гэмт хэрэг нь хохирогчийн эрх, эрх чөлөө гэмт этгээдээс бүрэн хамааралтай хязгаарлагдсан шинжтэй байна гэж тодорхойлж энэ төрлийн бусад гэмт хэрэгт хохирогчийн эрх, эрх чөлөөг хэр хэмжээнд хязгаарласнаар тулгуурлан салгаж хуульчилсан. Ийм байдлаар буюу зорчих эрхийг хязгаарлахтай холбож тусад нь хуульчлах арга зүйг олон улсын эрх зүйн эх сурвалжид зөвлөөгүй болохыг дурдах нь зүйтэй. Харьцуулан судалсан бусад улс оронд

Бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг болон хүн худалдаалах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүний ялын бодлогыг харилцан уялдаагүй, зөрүүтэй интервалтай хуульчилснаар бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээр ял шийтгэгдсэн дийлэнх гэмт этгээд хүн худалдаалах гэмт хэргээр ял шийтгэгдсэн гэмт этгээдээс 1 жилийн хугацаагаар бага ял шийтгэгдсэн байна.

Харьцуулсан судалгааны хүрээнд авч үзэхэд Австри, Герман зэрэг улсад үйл явцад хамруулсан үйлдлийг хүн худалдаалах гэмт хэрэгт тооцож, үр дүнг хамруулсан үйлдлийг албадан биеийг нь үнэлүүлэх, эрх чөлөөг нь хасах замаар мөлжих гэмт хэргүүдэд тусад нь хуульчилсан байна. Ялын бодлогын хувьд үйлдлийн аргад тулгуурлан ялгамжтай байхаар тодорхойлсон бөгөөд үр дүнг хамруулсан үйлдэлд илүү хүнд ял шийтгэдэг.

БНСУ, АНУ, Тайвань, Канад зэрэг улсад хүн худалдаалах гэмт хэрэг болон бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг эрүүгийн хуулийн нэг зүйлд хуульчилсан боловч хүндрүүлэх бүрэлдэхүүнийг харилцан адилгүй байдлаар хуульчилсан байна. Тайвань улсад бэлгийн харьцаанд оруулах үйлдлийг хүн худалдаалах гэмт хэргээс хүнд ялтай байхаар тодорхойлж эдгээр гэмт хэргийг үйлдэхдээ хүч хэрэглэсэн, заналхийлсэн зэрэг арга хэрэглэсэн бол хүндрүүлэх бүрэлдэхүүнд хуульчилсан байна. БНСУ-ын хувьд нэгтгэн хуульчилсан боловч АНУ, Тайвань улсаас өөр байдлаар тусгажээ. Тухайлбал хүн худалдаалах үр дүнг хамруулсан үйлдэл, үйл явцад хамруулсан үйлдэл, эрхшээлдээ оруулсан зэргээр нэг бүлэгт салгаж хуульчилсан. Ялын бодлогын хувьд бэлгийн зорилгоор хүнийг худалдаалах, бэлгийн харьцаанд оруулах гэмт хэргүүдийг хүн худалдаалах гэмт хэргээс хүнд ял шийтгэхээр хуульчилсан байна. Канад улсын хувьд хүн худалдаалах гэмт хэргийг хохирогчийн насанд тулгуурлан ангилсан ба насанд хүрээгүй хүний эсрэг үйлдсэн бол хүнд ял шийтгэдэг.

Харьцуулан судалсан улс орнуудад хүн худалдаалах болон бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг тусад нь хуульчилсан эсэхээс үл хамааран эдгээр гэмт хэргийг үйлдэх явцдаа хохирогчийн бие махбодод гэмтэл учруулсан, нас барсан тохиолдолд онц хүндрүүлж хуульчилсан нийтлэг шинж ажиглагдлаа.

НОМ ЗҮЙ

А. Монгол эх сурвалж:

1. С.Гантулга, Б.Энхболд, *Эрүүгийн эрх зүй, тусгай анги*, 2018
2. Ж.Дашдорж, "Хүн худалдаалах болон бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, тэмцэхэд хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь", *Хүний эрх сэтгүүл*, 1 (27), 2009;
3. С.Жанцан, *Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол (I боть)*, 2009;
4. Т.Золбоо, *Сургалтын Эрүүгийн хууль*, 2017;
5. Т.Золбоо, *Гэмт хэргийн бүтээц*, 2023;
6. Т.Золбоо, *Гэмт хэргийн бүрэлдүүн*, 2023;
7. Н.Лүндэндорж, *Монгол Улсын Үндсэн хууль, Шинжлэх ухааны тайлбар*, 2022;
8. Монголын Криминологичдын холбоо, *Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэглээ*, 2021
9. С.Нарангэрэл, *Монгол улсын эрүүгийн эрх зүй, Тусгай анги*, 1998;
10. С.Нарангэрэл, *Монгол Улсын Эрүүгийн эрх зүй*, 1999;
11. С.Нарангэрэл, Ж.Эрдэнэбулган, *Монгол Улсын Эрүүгийн эрх зүй, үзэл баримтлал, уламжлал, сургамж*, 2019;
12. Г.Совд, *Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар*, 2005;
13. Улсын Их Хурлын Тамгын Газар мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс, *Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх: онолын үндэслэл, бусад орнуудын туршлага*, 2018;
14. Ханнс-Зайделийн сан, "Эрх зүйн боловсрол" академи, *Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар*. 2009 он;
15. *Хууль зүйн үндэсний хүрээлэн*, *Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал, 1911-2009*, 2011;
16. *Хууль зүйн яам, Гэмт хэргийн тухай хуулийн төсөл*, 2013;
17. *Хууль зүйн яам, Гэмт хэргийн тухай хуулийн төсөл*, 2014;
18. 2015 оны Эрүүгийн хуулийн хувийн хэрэг I-VII боть.

Б. Гадаад эх сурвалж:

1. Annuradha Sikka, *Trafficking in persons and the Canadian response: Looking for a victim, Doctoral thesis*, University of Ottawa, 2014;
2. Canadian Resource Centre for Victims of Crime (CRCVC), *Bill C-2, An Act to amend the Criminal Code and to make consequential amendments to other Acts (Tackling Violent Crime Act)*, 2008;
3. Federal/Provincial/Territorial Working Group on Trafficking in Persons, *A Handbook for Criminal Justice Practitioners on Trafficking in Persons*, 2014;
4. Hayli Millar, Tamara O'Doherty, SWAN Vancouver Society, *The Palermo Protocol & Canada Ten Years On: The Evolution and Human Rights Impacts of Anti-Trafficking Laws in Canada*, 2015;
5. International Organization for Migration, *A Review of Data on Trafficking in the Republic of Korea*, (No №9, 2002);
6. International Organization for Migration, *Data and research on human trafficking: A global survey*, (Offprint of the Special Issue of International Migration Vol. 43 (1/2) 2005);
7. Jinyoung Hong, Understanding Criminal Law in Korea, *Journal of Korean Law*, Vol. 23;
8. Kaila C. Ladd, *Subjugated Innocence: Domestic Child Sexual Exploitation in Canada*, 2020;
9. Laura Barnett, Law and Government Division, *Trafficking in Persons*, 2007;
10. Library of Parliament, Legislative Summaries, Bill C-22: An Act to amend the Criminal Code (age of protection) and to make consequential amendments to the Criminal Records Act;
11. Royal Canadian Mounted Police's (RCMP), *National Strategy to Combat Human Trafficking*, 2012;
12. Royal Canadian Mounted Police's (RCMP), Human Trafficking National Coordination Centre (HTNCC), *Domestic Human Trafficking for Sexual Exploitation in Canada*, 2013;
13. Sebastian Bürger: Die Neuregelung des Menschenhandels Umsetzung unionsrechtlicher Vorgaben und Schaffung eines stimmigen Gesamtkonzepts?, 2017;
14. US Department of State, 2024 Trafficking in Persons Report: South Korea;
15. US Department of State, 2024 Trafficking in Persons Report: Canada
16. KOK, Menschenhandel;
17. KOK e. V., Datenerhebung zu menschenhandel und ausbeutung in deutschland 2022;
18. 法務部司法官學院.詐欺型組織犯罪與人口販運問題初探: 研究成果報告書, 2023.

В. Эрх зүйн эх сурвалж:Олон улсын эрх зүйн эх сурвалж

1. Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол;
2. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцын нэмэлт болох "Хүн ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай" протокол.

Хууль тогтоомж

1. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012);
2. Эрүүгийн хууль (1986);
3. Эрүүгийн хууль (2002);
4. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 2008,
5. Эрүүгийн хууль (2015);
6. Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай (2012);
1. Allow States and Victims to Fight Online Sex Trafficking Act, 2017;
2. Act on Prevention of Human Trafficking and Protection of Victims, 2021;
3. Criminal Code of Canada, 1892;
4. Communication Act, 1934;
5. Criminal act, 1953;
6. Immigration and Refugee Protection Act, 2001;
7. Stop Enabling Sex Traffickers Act, 2017;
8. Title 18 of the United States Code;
9. Trafficking Victim Protection Act, 2000;
10. Strafgesetzbuch (StGB), 1871;
11. Gesetz zur Verbesserung der Bekämpfung des Menschenhandels und zur Änderung des Bundeszentralregistergesetzes sowie des Achten Buches Sozialgesetzbuch vom 11.10.2016;
12. 中華民國人口 运防制法, 2009;
13. 中華民國刑法, 1935.

Шүүхийн шийдвэр:

1. Монгол Улсын дээд шүүхийн , 2007 оны 10 дугаар сарын 29-ны өдөр, 41 дүгээр тогтоол;
2. Монгол Улсын дээд шүүхийн 2008 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 12 дугаар тогтоол;
3. *R v Audet*, 1996
4. *R v SJB*, 2018 MBCA 62
5. *R. v. Joseph*, 2020 ONCA 733 (CanLII)
6. *R. v. Wilson*, 2022 ONCA 857 (CanLII)
7. *R v SJB*, 2018 MBCA 62 (CanLII).
8. *R. v. Audet*, 1996 CanLII 198 (SCC), [1996] 2 SCR 171
9. *United States v. Jungers*, 702 F.3d 1066 (8th Cir. 2013);

Г. Цахим эх сурвалж:

1. АНУ-ын хууль зүйн яам: <https://www.justice.gov/>;
2. АНУ-ын Засгийн Газрын цахим хуудас, <https://www.state.gov/>;
3. БНСУ-ын Жендерийн тэгш байдал, гэр бүлийн яамны цахим хуудас, <https://www.mogef.go.kr/eng/>;
4. БНСУ-ын Hankyoreh өдөр тутмын сонин, <https://english.hani.co.kr/>;
5. БНСУ-ын Хүний Эрхийн Комиссын цахим хуудас, <https://www.humanrights.go.kr/>;
6. Британика цахим толь бичиг, <https://www.britannica.com/>;
7. Канад Улсын Хууль Зүйн Яамны цахим хуудас, <https://www.justice.gc.ca/eng/>
8. Канад Улсын Парламентын цахим хуудас, <https://www.parl.ca/>;
9. Канад Улсын Олон Нийтийн Аюулгүй Байдлын Яамны цахим хуудас, <https://www.publicsafety.gc.ca/lbrr/archives/cnmcs-plcng/cn29668-eng.pdf>
10. НҮБ-ын хэвлэл мэдээллийн хуудас: <https://news.un.org/>;
11. НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC)-ны Гэмт хэргийн тухай хуулиуд, цахим эх сурвалж хуваалцах портал, <https://sherloc.unodc.org/>;
12. Тайвань Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан: <https://law.moj.gov.tw/Index.aspx>;
13. Тайвань Улсын дотоод хэргийн яамны үндэсний цагаачлалын албаны цахим хуудас: <https://www.immigration.gov.tw>.

ТАЙЛБАР

1. UN, International Agreement for the suppression of the White Slave Traffic, 1910 https://treaties.un.org/pages/ViewDetails.aspx?src=TREATY&mtdsg_no=VII-8&chapter=7&clang=_en (Сүүлд үзсэн: 2024.05.18)
2. Anne T. Gallagher, *The International Law of Human Trafficking*, (Cambridge University Press, 2010), 14.
3. Ibid.
4. 1980-аас 1990-д оны хооронд хүүхдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор худалдах гэмт явдал ихсэж НҮБ-аас тусгай илтгэгч томилон 2000 онд "Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлүүлэх болон хүүхдийн порнографын тухай" Хүүхдийн эрхийн конвенцын нэмэлт протоколыг баталж хүүхдийг хууран мэхэлж мөнгө төлөх буюу санал болгох замаар биеийг нь үнэлүүлсэн тохиолдлуудыг хүүхдийн бэлгийн мөлжлөгт тооцсон. Ингэснээр бэлгийн мөлжлөг хэмээх ойлголт нь тухайн үйл ажиллагаанаас ашиг олж буй бусад гуравдагч этгээдүүдээс гадна хохирогчид төлбөр төлөн биеийг нь үнэлүүлсэн этгээдүүдийг хамааруулжээ. Michael Dottridge, "Trafficked and Exploited: The Urgent Need for Coherence in International Law", Prabha Kotiswaran, *Revisiting the law and governance of trafficking, forced labor and modern slavery*, (Cambridge University Press, 2017), 59-83.
5. UN General Assembly, "Traffic in Women and Girls", 1994.
6. Anne T. Gallagher, *supra* note 2. 20.
7. Ibid, 24.
8. Ibid.
9. Anne T. Gallagher, "The International Legal Definition of "Trafficking in Persons": Scope and Application", Prabha Kotiswaran, *supra* note 4. 83-111.
10. Ibid.
11. Legislative Guide For The Protocol To Prevent, Suppress And Punish Trafficking In Persons, Especially Women And Children , United Nations Vienna, 2020 page 33 https://www.unodc.org/documents/human-trafficking/2020/TiP_LegislativeGuide_Final.pdf (Сүүлд үзсэн: 2024.05.13)
12. Anne T. Gallagher, *supra* note 2. 30.
13. Ibid.
14. The Concept of "Harbouring" in the Trafficking in Person Protocol Issue Paper, United Nations Office on Drugs and Crime, 2021, page 60 https://humantraffickingsearch.org/wp-content/uploads/2021/12/The_Concept_of_Harbouring_Issue_Paper.pdf, (Сүүлд үзсэн: 2024.05.13)
15. Ibid.
16. Harbouring буюу орогнуулах үйлдэл нь улс орон бүрд тухайн үгийг хэрхэн орчуулахаас буюу хэлний онцлогоос хамааран өөр өөр түвшинд тайлбарлагддаг. Тухайлбал Францад "héberger" буюу тодорхой газарт орон байраар хангах хэмээх үгээр тайлбарладаг. Үүнд хохирогчийг мөлжлөгт оруулж буй газарт хууль бусаар хөдөлмөрлүүлсэн боловч түүнийг орон байраар хангаагүй бол орогнуулсан гэж үздэггүй байна. Гэсэн хэдий ч НҮБ-ын "Хүн худалдаалах гэмт хэрэг дэх орогнуулах тухай ойлголтын талаарх судалгаа"-аар протоколын нэр томъёог протоколын зорилготой уялдуулан хүн худалдаалах гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэхийн тулд уян хатан, өргөн хүрээнд тайлбарлаж хэрэглэхийг зөвлөсөн байна. Ibid, 63.
17. Хохирогчийн зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар конвенцын төслийг боловсруулах ажлын хэсэг нэлээд нухацтай хэлэлцжээ. Энэхүү хэлэлцүүлэг нь "бие хүний автономи байдал" болон хүн худалдаалах гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх зорилгын харилцан тэнцвэрийг хангах асуудлын хүрээнд голлон өрнөсөн бөгөөд хүн худалдаалах гэмт хэрэг нь хохирогчийн зөвшөөрлөөр эхэлсэн байж болох боловч зөвшөөрлөөр халхавчлан тодорхой шатанд түүний хүсэл зоригийн эсрэг эрх, эрх чөлөөг нь хязгаарлаж мөлжлөгийн нөхцөл байдалд оруулсан, хохирогч өөрийн чөлөөт сонголтод үндэслэн бодит зөвшөөрөл өгөх боломжгүй тохиолдолд гэмт хэрэгтэнд ял завшуулахаас сэргийлэх зорилгоор хохирогчийн зөвшөөрлийг харгалзахгүй байх шийдвэрт хүрчээ.
18. UNODC, Guidance Note on 'abuse of a position of vulnerability' as a means of trafficking in persons in Article 3 of the Protocol to Prevent, Suppress and Punish Trafficking in Persons, Especially Women and Children, supplementing the United Nations Convention against Transnational Organized Crime, 2012 https://www.unodc.org/documents/human-trafficking/2012/UNODC_2012_Guidance_Note_-_Abuse_of_a_Position_of_Vulnerability_E.pdf (Сүүлд үзсэн: 2024.05.18)

19. UN Office of the High Commissioner for Human Rights, Recommended Principles and Guidelines on Human Rights and Human Trafficking, 2010 https://www.ohchr.org/sites/default/files/Documents/Publications/Commentary_Human_Trafficking_en.pdf (Сүүлд үзсэн: 2024.05.18)
20. Ibid, 188.
21. Ibid, 189.
22. V Greiman , C Bain, The Emergence of Cyber Activity as a Gateway to Human Trafficking, Journal of Information Warfare , Vol. 12, No. 2 (2013), 43. <https://www.jstor.org/stable/26486854?seq=88> (Сүүлд үзсэн: 2024.05.12)
23. United Nations Office on Drugs and Crime, Traffickers Use Of The Internet, 2020, 119. https://www.unodc.org/documents/data-and-analysis/tip/2021/GLOtIP_2020_Chapter5.pdf, (Сүүлд үзсэн: 2024.05.12)
24. Ibid.
25. С.Жанцан, Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол (I боть), 2009, 326 дахь тал.
26. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал, 1911-2009, 2011, 675 дахь тал.
27. Мөн тэнд.
28. Хуульчилсан тайлбар гэж хуулиар тусгайлан эрх олгосон байгууллага тайлбар гаргахыг, шүүхийн тайлбар гэж Монгол Улсын дээд шүүхийн тогтоолоор хуулийг зөв хэрэглэх талаар гаргасан тайлбарыг хэлэх бөгөөд албан ёсны тайлбарт хамаарна. Онолын тайлбар нь эрүүгийн хуулийн хэм хэмжээний талаар хуульч, эрдэмтдийн туурвисан судалгаа, бүтээлд тусгалаа олсон байх бөгөөд үүнийг албан ёсны бус тайлбар гэнэ.
29. С.Нарангэрэл, Монгол улсын эрүүгийн эрх зүй, Тусгай анги, 1998, 104 дэх тал.
30. Мөн тэнд.
31. Г.Совд, Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, 2005, 179 дэх тал.
32. Ж.Дашдорж, “Хүн худалдаалах болон бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, тэмцэхэд хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь”, Хүний эрх сэтгүүл, 1 (27), 2009, 27 дахь тал.
33. Г.Совд, өмнөх эшлэл 34, 179 дэх тал.
34. Мөн тэнд.
35. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 2008, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=102787&showType=1>
36. Монгол Улсын дээд шүүхийн 2008 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 12 дугаар тогтоол, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16468128314581>
37. С.Нарангэрэл, Ж.Эрдэнэбулган, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй, үзэл баримтлал, уламжлал, сургамж, 2019, 52 дахь тал.
38. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012), <https://legalinfo.mn/mn/detail/554>
39. Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хууль (2012), <https://legalinfo.mn/mn/detail?lawId=102791&showType=1>
40. Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хууль (2012), 2 дугар зүйл “124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсгийн хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж, хуурч мэхлэх замаар” гэснийг бусдын гэж өөрчилсүгэй.
41. Эрүүгийн хуулийн хувийн хэрэг /Шинэчилсэн найруулга/ Боть I, 12-13 дахь тал.
42. Хууль зүйн яам, Гэмт хэргийн тухай хуулийн төсөл, 2013, 54-55 дахь тал.
43. Хууль зүйн яам, Гэмт хэргийн тухай хуулийн төсөл, 2013, 57 дахь тал, Хууль зүйн яам, Гэмт хэргийн тухай хуулийн төсөл, Зөрчлийн тухай хуулийн төсөл, 2014, Хууль зүйн яам, Гэмт хэргийн тухай хуулийн төсөл, 2014, 50 дахь тал.
44. Б.Гантуяа: “Гэмт хэргийн үндсэн шинжийг тодорхойлоход ажлын хэсгийн гол барьсан бодлого нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцын агуулгыг баримталсан буюу конвенцын үг, үсгийг тэр чигээр нь буулгах гол бодлоготой байсан” ярилцлагын судалгааны хэсгээс 05 мин 09 сек, УБ, (2024.06.27). Г.Оюунболд: “Манай улс Палермогийн протоколд нэгдэн орсон үүргийнхээ дагуу түүнд заасан агуулгаар хүн худалдаалах гэмт хэргийн шинжийг тодорхойлох ёстой. Өмнө тулгамдаж байсан хэд хэдэн асуудлыг ярилцаад протоколд зааснаар хүн худалдаалах гэмт хэргийн шинжийг тодорхойлсон” ярилцлагын судалгааны хэсгээс 01 мин 22 сек, УБ, (2024.06.24)

45. Хууль зүйн яам, өмнөх эшлэл 44, 53-54 дэх тал.
46. Азийн сан, Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх үндэсний механизмын зураглал, судалгааны тайлан, 2021, IRIM судалгааны хүрээлэн, Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгаа, Судалгааны тайлан, 2022, Хүйсийн тэгш эрхийн төв, Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ, 2022.
47. Эрүүгийн хуулийн хувийн хэрэг /Шинэчилсэн найруулга/ Боть I, 12-13 дахь тал.
48. Мөн тэнд, 114 дэх тал.
49. Эрүүгийн хуулийн хувийн хэрэг /Шинэчилсэн найруулга/ Боть I, 13-14 дэх тал.
50. Хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн 13 гишүүнээс Б.Гантуяа, Г.Эрдэнэбат, Г.Оюунболд нар судалгаанд хамрагдахаар зөвшөөрсөн. Судалгаанд хамрагдсан ажлын хэсгийн гишүүдийн ярилцлагаас зарим сул үгийг хасаж, найруулгын өөрчлөлт хийлгүй ашигласан болно.
51. Б.Гантуяа "Хүн худалдаалах гэмт хэрэг нь зөвхөн энэ нэр томъёогоороо эрүүгийн хуульд байж байх ёстой биш. Доторх үйлдлийг нь салгаж болох буюу өөр өөр зүйлчлэлээр ялын бодлогын хувьд манайх зарим үйлдлийг хүндрүүлж эсхүл хөнгөрүүлж авч үзнэ гэж томъёолж болно. Олон улсын байгууллагаас Монгол Улсын эрүүгийн хуульд хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой хоёр зохицуулалт байна. Нэг нь хүн худалдаалах нөгөө нь бэлгийн мөлжлөг гэж дүгнэнэ. Хүн худалдаалах гэмт хэргийг зөвхөн нэг зүйл, хэсгээр зүйлчилнэ гэсэн конвенцын шаардлага байхгүй. Өөрөөр хэлбэл, энэ хоёр хоёулаа нийлж байж манай улсын хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой ялын бодлого харагдана" ярилцлагын судалгааны хэсгээс 19 минут 56 сек, УБ, (2024.06.27)
52. Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол, <https://legalinfo.mn/mn/detail/1274>
53. Т.Золбоо, Гэмт хэргийн бүрэлдүүн, 2023, 42-63 дахь тал.
54. УДШ-ийн, 2007 оны 10 дугаар сарын 29-ны өдөр, 41 дүгээр тогтоол, <http://old.supremecourt.mn/act/view/127>
55. Мөн тэнд.
56. УДШ-ийн 2008 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 12 дугаар тогтоол, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16468128314581>
57. С.Гантулга, Б.Энхболд, Эрүүгийн эрх зүй, тусгай анги, 2018, 73 дахь тал.
58. Мөн тэнд.
59. Мөн тэнд.
60. Мөн тэнд.
61. Мөн тэнд.
62. УДШ-ийн 2008 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 12 дугаар тогтоол, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16468128314581>
63. Монголын Криминологичдын холбоо, Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэглээ, 2021, 56-57 дахь тал.
64. Т.Золбоо, Сургалтын Эрүүгийн хууль, 2017, 78 дахь тал.
65. Монгол Улсын Үндсэн Хууль (1992), <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>, (Сүүлд үзсэн: 2024.07.18).
66. Нээлттэй нийгэм форум, Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт судалгааны тайлан, 2022, 20 дахь тал.
67. Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хууль, Шинжлэх ухааны тайлбар, 2022, 305 дахь тал.
68. Дам эшлэв. Ханнс-Зайделийн сан, "Эрх зүйн боловсрол" академи, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. 2009 он. 90 дэх тал,
69. Улсын Их Хурлын Тамгын Газар мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс, Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх: онолын үндэслэл, бусад орнуудын туршлага, 2018, 11 дэх тал.
70. С.Гантулга, Б.Энхболд, өмнөх эшлэл 62, 68 дахь тал.
71. С.Нарангэрэл, өмнөх эшлэл 32, 182 дахь тал.
72. Энэхүү судалгааны хүрээнд анхан, давах, хяналтын шатны шүүхийн 48 шүүхийн шийдвэрийг судаллаа. Мөн 2020 онд анхан шатны журмаар шийдвэрлэсэн боловч 2021 эцэслэн шийдвэрлэсэн 4 шүүхийн шийдвэрийг хамруулсан болно.

73. Давж заалдах шатны шүүхээс хүн худалдаалах гэмт хэргийн зүйлчлэлийг үндэслэлгүйгээр хөнгөрүүлж бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээр зүйлчилсэн талаар дүгнэж анхан шатны шүүхэд дахин хэлэлцүүлэхээр буцааж шийдвэрлэсэн 1 магадлал байна. Гэвч анхан шатны дахин хэлэлцэхдээ бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээр зүйчлэл өөрчлөлгүй ирүүлснийг давж заалдах шатны шүүх дахин шийдвэрлэхдээ хэвээр үлдээж шийдвэрлэжээ. Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 2022/ДШМ/164 магадлал; НЭХДЗШШ-ийн 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 2023/ДШМ/291 магадлал.
74. 18 U.S. Code
75. Trafficking Victim Protection Act, 2000.
76. Ibid, art. 7102 (11)
77. "Citizen's Guide to U.S. Federal Law on Child Sex Trafficking", U.S. Department of Justice, 2024.05.22 <https://www.justice.gov/criminal/criminal-ceos/citizens-guide-us-federal-law-child-sex-trafficking>
78. Ноцтой хохирол гэдэг нь хохирогчтой ижил нөхцөл байдалд байгаа бусад хүн тухайн хохирлоос сэргийлэхийн тулд арилжааны шинжтэй бэлгийн үйлдлийг хийх, эсхүл тэдгээр үйлдлийг үргэлжлүүлэхээс аргагүй нөхцөлд оруулахуйц ноцтой бие махбодын, сэтгэл зүйн, санхүүгийн болон нэр төрд нь учруулж болох хохирлыг хэлнэ. 18 U.S. Code, art. 1591 (e.5)
79. Eisner Gorin LLP, "What is Human Trafficking under Federal Law, accessed June 29, 2022 <https://www.thefederalcriminalattorneys.com/federal-human-trafficking-laws> (Сүүлд үзсэн: 2024.05.22)
80. Англ.entice АНУ-ын Эрүүгийн кодоод хүн худалдаалах гэмт хэргийн объектив талын шинжид татан оруулах үйлдлийг гэмт хэрэгт тооцдог. Энэ нь НҮБ-н хүн худалдаалахын эсрэг конвенцод тусгагдаагүй бөгөөд манай улсын хувьд Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд уг протоколын агуулгыг шууд буулгахдаа энэ үйлдлийг мөн гэмт хэрэгт тооцоогүй байна.
81. 18 U.S. Code, art. 1593
82. 2020 онд АНУ-д бэлгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэрэгт явуулсан мөрдөн шалгах ажиллагааны 80% нь цахим зар сурталчилгаа ашигласан байна. "Traffickers abusing online technology, UN crime prevention agency warns", UN News, 2024.05.22 <https://news.un.org/en/story/2021/10/1104392>
83. Allow States and Victims to Fight Online Sex Trafficking Act, 2017
84. Stop Enabling Sex Traffickers Act, 2017
85. Интерактив компьютерын үйлчилгээ гэдэг нь интернэт нэвтрэх боломж олгодог системүүд гэх мэтчилэн олон тооны хүмүүсийг компьютерын серверт нэвтрэх боломж олгодог аливаа систем, үйлчилгээ, программ хангамжийг хэлнэ. Communication Act, 1934, art. 230 (f)
86. Хүүхдийн порнограф гэдэг нь хүүхэд оролцуулан илтэд бэлгийн шинжтэй үйлдэл хийлгэж буй дүрслэлийг хэлнэ. Үүнд гэрэл зураг, бичлэг, цахим буюу компьютероор хийсэн бодит мэт зураг, хүүхдийг төрхийг танигдахуйц байдлаар өөрчилсөн зураг зэрэг гэх мэт багтана.
87. Rahmenbeschluss des Rates vom 19. Juli 2002 zur Bekämpfung des Menschenhandels, <https://eur-lex.europa.eu/legal-content/DE/ALL/?uri=CELEX%3A32002F06298>, (Сүүлд үзсэн: 2024.07.06).
88. Палермогийн протоколоос ялгаатай нь зөвлөлийн шийдвэрт хүн худалдаалах гэмт хэргийг бэлгийн мөлжлөг болон албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилготой байхаар тусгасан, харин эд, эрхтнийг нь авч мөлжих зорилгын хэлбэрийг тусгаагүй байдаг.
89. Siebenunddreißigstes Strafrechtsänderungsgesetz– §§ 180b, 181 StGB –(37. StrÄndG), 2005, https://www.bgbl.de/xaver/bgbl/start.xav?startbk=Bundesanzeiger_BGBl&start=//%5B@attr_id=%27bgbl105s0239.pdf%27%5d#__bgbl__%2F%2F%5B%40attr_id%3D%27bgbl105s0239.pdf%27%5D__1720402424842, (Сүүлд үзсэн: 2024.07.08).
90. Magdalena Warum: Die Vorbereitungsdelikte des Strafgesetzbuches, 2010, S.1.
91. Т.Золбоо, Гэмт хэргийн бүтээц, 2023, 175 дахь тал.
92. Magdalena Warum, S.3.
93. Magdalena Warum, S.4.
94. Насанд хүрсэн хүнийг мөлжих зорилгоор бусармаг аргаар элсүүлсэн, тээвэрлэсэн, хүлээн авсан орогнуулсан, эсвэл бусад хүнд санал болгосон, дамжуулсан бол зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Strafgesetzbuch, 1974, <https://www.jusline.at/gesetz/stgb>, (Сүүлд үзсэн: 2024.07.06).
95. Magdalena Warum: Die Vorbereitungsdelikte des Strafgesetzbuches, 2010, S.9.

- ТАЙЛБАР 87

120. 同上.
121. 法務部司法官學院.詐欺型組織犯罪與人口販運問題初探: 研究成果報告書[R/OL]. 2023-12/2024-05-17 www.cprc.moj.gov.tw/media/20213391/詐欺型組織犯罪與人口販運初探-期末報告_240219更新.pdf?mediaDL=true
122. 人口 运防制法第三十三條.
123. 人口 运防制法第三十四條.
124. 同上.
125. "Jinyoung Hong, Understanding Criminal Law in Korea, Journal of Korean Law, Vol. 23, February 2024, p 105 [https://jkl.snu.ac.kr/paper/2024/Vol.23%20No.1%20\(Feb\)/2.%20Featured%20Articles/04_Understanding%20Criminal%20Law%20in%20Korea.pdf](https://jkl.snu.ac.kr/paper/2024/Vol.23%20No.1%20(Feb)/2.%20Featured%20Articles/04_Understanding%20Criminal%20Law%20in%20Korea.pdf) (Сүүлд үзсэн: 2024.07.15)
126. Арилжааны бэлгийн харьцааг зохион байгуулахыг шийтгэх тухай хууль; Хүүхэд, залуучуудыг бэлгийн гэмт хэргээс хамгаалах тухай хууль; Залуучуудыг хамгаалах тухай хууль; Хүүхдийн халамжийн тухай хууль; Хөдөлмөрийн стандартын тухай хууль; Далайчдын тухай хууль; Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн халамжийн тухай хууль; Сэтгэцийн эрүүл мэнд, халамжийн үйлчилгээг дэмжих тухай хууль; Орон гэргүй иргэдийн халамжийг дэмжих тухай хууль, Эрхтэн шилжүүлэн суулгах тухай хууль
127. Criminal Act (1953), Chapter 31. https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=28627&lang=ENG
128. АНУ-ын 2024 оны Хүн худалдаалах тайланд "хүн худалдаалах гэмт хэргийн үндсэн заалт болох 289 дүгээр зүйлийн тодорхойлолт нь мөлжлөгийн зорилгоор бусдыг худалдаж, худалдан авах үйлдлээр хязгаарлан тус гэмт хэргийн чухал шинж болох хүч хэрэглэх, залилан мэхлэх, албадах үйлдлийн аргыг хуульчлаагүй нь олон улсын эрх зүйн тодорхойлолттой нийцээгүй байна. Гэсэн хэдий ч хүн худалдаалах гэмт хэргийн бусад шинжийг 288, 292 дугаар зүйлд заасан гэмт хэргийн шинжид хуульчилсан хэмээн үзэхээр байна" гэж дүгнэжээ. US Department of State, 2024 Trafficking in Persons Report: South Korea, US Department of State, 2024 Trafficking in Persons Report: South Korea, <https://www.state.gov/reports/2024-trafficking-in-persons-report/south-korea/>, (Сүүлд үзсэн: 2024.07.23)
129. "Abduction" гэдэг нь аливаа эмэгтэйд биеийг нь үнэлүүлэх, татвар эм болгож авах зорилгоор хүчээр авч явах явдал бөгөөд зарим улс оронд насанд хүрээгүй охиныг гэрлүүлэх зорилгоор хулгайлж авч явахыг "crime of abduction" буюу хүн хулгайлах гэмт хэрэг хэмээн тооцдог. "Abduction" гэдэг нь "kidnapping" буюу хүн хулгайлах ойлголтын нэг хэлбэр юм. (Britannica, <https://www.britannica.com/topic/abduction-law>, (Сүүлд үзсэн: 2024.05.26)
130. Criminal Act (1953), Chapter 31. https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=28627&lang=ENG
131. Federal/Provincial/Territorial Working Group on Trafficking in Persons, A Handbook for Criminal Justice Practitioners on Trafficking in Persons, 2014, 21-29, <https://www.justice.gc.ca/eng/rp-pr/cj-jp/tp/hcjpotp2-gtpupjp2/pdf/hcjpotp2-gtpupjp2.pdf>, (Сүүлд үзсэн: 2024.07.15)
132. Laura Barnett, Law and Government Division, Trafficking in Persons, 2007, 8, https://epe.lac-bac.gc.ca/100/200/301/library_parliament/backgroundunder/2007/trafficking-e/PRB0624-1e.pdf, (Сүүлд үзсэн: 2024.07.15)
133. Immigration and Refugee Protection Act, 2001
134. Royal Canadian Mounted Police's (RCMP), National Strategy to Combat Human Trafficking, 2012, 9, https://publications.gc.ca/collections/collection_2014/grc-rcmp/PS64-104-2012-eng.pdf, (Сүүлд үзсэн: 2024.07.15)
135. Канад Улсын Хууль Зүйн Яамны цахим хуудас, <https://www.justice.gc.ca/eng/rp-pr/cj-jp/tp/hcjpotp-gtpupjp/fs-fi/fs1-fi1.html>, (Сүүлд үзсэн: 2024.07.15)
136. Annuradha Sikka, Trafficking in persons and the Canadian response: Looking for a victim, Doctoral thesis, University of Ottawa, 2014, 180, <https://ruor.uottawa.ca/server/api/core/bitstreams/0224c699-4e63-48d6-ac68-7523a0e38d4d/content>, (Сүүлд үзсэн: 2024.07.15)
137. Federal/Provincial/Territorial Working Group on Trafficking in Persons, *supra* note 143, 35.
138. "Прокурорт хүн худалдаалах гэмт хэргийг нотлоход дэмжлэг үзүүлэх зорилгоор "нотлох баримтын таамаглал"-ын талаар хуульчилжээ" *Ibid*, 22.
139. Criminal Code of Canada, 1892
140. The Royal Canadian Mounted Police's (RCMP), *supra* note 146, 4.
141. *Ibid*, 23.

142. Hayli Millar, Tamara O'Doherty, SWAN Vancouver Society, The Palermo Protocol & Canada Ten Years On: The Evolution and Human Rights Impacts of Anti-Trafficking Laws in Canada, 2015, 32, <https://icclr.org/wp-content/uploads/2019/06/Palermo-Project-Key-Findings-Report-15-October-2015-with-copyright-2.pdf?x27685>, (сүүлд үзсэн: 2024-07-15)
143. Ibid
144. Annuradha Sikka, *supra* note 148, 187.
145. Ibid, 27.
146. Annuradha Sikka, *supra* note 148, 187.
147. Royal Canadian Mounted Police's (RCMP), *supra* note 146, 9.
148. Federal/Provincial/Territorial Working Group on Trafficking in Persons, *supra* note 143, 27.
149. R. v. Joseph, 2020 ONCA 733 (CanLII), para 86.
150. Annuradha Sikka, *supra* note 148, 187.
151. R. v. Wilson, 2022 ONCA 857 (CanLII), para 28.
152. Annuradha Sikka, *supra* note 148, 187.
153. Federal/Provincial/Territorial Working Group on Trafficking in Persons, *supra* note 143, 24.
154. Annuradha Sikka, *supra* note 148, 187.
155. Federal/Provincial/Territorial Working Group on Trafficking in Persons, *supra* note 143, 24.
156. Laura Barnett, Law and Government Division, Trafficking in Persons, 2007, 8, https://epe.lac-bac.gc.ca/100/200/301/library_parliament/backgroundunder/2007/trafficking-e/PRB0624-1e.pdf, (Сүүлд үзсэн: 2024.07.15)
157. НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC)-ны Гэмт хэргийн тухай хуулиуд, цахим эх сурвалж хуваалцах портал, https://sherloc.unodc.org/cld/uploads/res/case-law-doc/traffickingpersonscrimetype/can/2019/g_v_gallone_html/2019ONCA0663.pdf, (Сүүлд үзсэн: 2024.07.15)
158. "Кровны зөвлөл, кровны хуульчид гэж шударга ёсыг эрхэмлэж, төвийг сахиж яллах чиг үүргийг хэрэгжүүлэх эрх бүхий Канад Улсын прокурорыг ойлгоно." Канад Улсын Олон Нийтийн Аюулгүй Байдлын Яамны цахим хуудас, <https://www.publicsafety.gc.ca/lbrr/archives/cnmcs-plcng/cn29668-eng.pdf> (Сүүлд үзсэн: 2024.07.31)
159. Criminal Code of Canada, 1892
160. Канад Улсын Хууль Зүйн Яамны цахим хуудас, <https://www.justice.gc.ca/eng/rp-pr/cj-jp/tp/hcjpotp-gttrpj/fs-fi/fs1-fi1.html>, (Сүүлд үзсэн: 2024.07.15)
161. Library of Parliament, Legislative Summaries, Bill C-22: An Act to amend the Criminal Code (age of protection) and to make consequential amendments to the Criminal Records Act, https://lop.parl.ca/sites/PublicWebsite/default/en_CA/ResearchPublications/LegislativeSummaries/391LS550E (Сүүлд үзсэн: 2024.07.15)
162. Kaila C. Ladd, Subjugated Innocence: Domestic Child Sexual Exploitation in Canada, 2020, 19-20, <https://mru.arcabc.ca/islandora/object/mru%3A791/datastream/PDF/view>, (Сүүлд үзсэн: 2024.07.15)
163. The Canadian Resource Centre for Victims of Crime (CRCVC), Bill C-2, An Act to amend the Criminal Code and to make consequential amendments to other Acts (Tackling Violent Crime Act), 2008, 3 https://csrcv.ca/wp-content/uploads/2021/09/Senate_BillC-2_Feb08.pdf, (Сүүлд үзсэн: 2024.07.15)
164. 2008 оны Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр насны доод хязгаарыг 14 нас байсныг 16 нас болгож өөрчилсөн. Канад Улсын Парламентын цахим хуудас, <https://www.parl.ca/documentviewer/en/39-2/bill/C-2/royal-assent/page-30#2>, para 54 (Сүүлд үзсэн: 2024.07.31)
165. R. v. Audet, 1996 CanLII 198 (SCC), [1996] 2 SCR 171, para 35.
166. Kaila C. Ladd, *supra* note 179, 07.

